

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 92
<hr/>	
1. <i>Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан</i>	7 – 50
<hr/>	
2. <i>Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан</i>	50 – 80
<hr/>	
3. <i>Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт</i>	80 – 92
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 4 дүгээр сарын 28-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Г.Ганбаатар;
Чөлөөтэй: Р.Батболд, Ч.Номин;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Ж.Ганбаатар.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, А.Энхбат, Н.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Мөнхсоёл, Н.Алтанхуяг, Х.Булгантуяа, Да.Цогтбаатар, М.Бадамсүрэн, Д.Пүрэвдаваа, Х.Ганхуяг, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, А.Энхбат, Н.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ц.Даваасүрэн, Да.Цогтбаатар, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 12 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, Тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Э.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын менежер С.Нацагдорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Г.Эрдэнэбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, референт Т.Гоцбаяр, Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Н.Алтанхуяг, Г.Тэмүүлэн, Да.Цогтбаатар, Л.Соронзонболд, С.Эрдэнэбат, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 13 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Гаалийн ерөнхий газрын Дэд дарга Г.Энхтайван,

Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд, Гаалийн ерөнхий газрын Татвар орлогын газрын дарга С.Баярмаа, мөн газрын Барааны ангиллын хэлтсийн дарга Ч.Чимгэрэл, ахлах байцаагч Ч.Тамираа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 14 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 18 минут үргэлжилж, 30 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 45 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Төсвийн байнгын хорооны хуралдааны ирц хүрсэн.

Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 56.7 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Норовын Н.Алтанхуяг 11 дүгээр тойрог, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Хүрэлбаатарын Булгантуяа 8 дугаар тойрог, Пүрэвжавын Ганзориг жагсаалт Хассуурийн Ганхуяг 9 дүгээр тойрог, Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, Батжаргалын Заяабал 2 дугаар тойрог, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Даваахүүгийн Пүрэвдаваа жагсаалт, Ганзоригийн Тэмүүлэн 1 дүгээр тойрог, Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог, Баттогтохын Чойжилсүрэн 2 дугаар тойрог, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан.

Хоёр.Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Гурав.Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Даваагийн Цогтбаатар гишүүн. Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хэлэлцэх асуудлын хоёр дээр байв уу, гурав дээр байв уу?

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний асуудлаар нэг үг хэлэх гэсэн юм.

Одоо байгаа бүрэлдэхүүнээр бид 12 хүний бүрэлдэхүүнтэй. Тэгээд даргаар нь би явж байгаа.

Ардчилсан намаас гурав хүн байгаа буюу Далай Батбаяр гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн бид гурав байгаа.

Тэгээд орон гарсан буюу гишүүд нь сайд болоод явсан хоёр хүнийх нь оронд Монгол Ардын намаас хүн оруулахаар байгаа. Ер нь хуулиараа энэ Төсвийн зарлагын хяналтын дэд хороо цөөнхдөө хяналт тавих гэдэг үүднээс нь ирж байгаа хяналтын чиг үүрэгтэй Зарлагын хяналтын дэд хороо.

Гэтэл үүнийгээ хүртэл дахиад 4 гишүүнтэй байгаа Монгол Ардын нам дээр дахиад 2 хүнийг нь нэмж өгнө гэдэг чинь үндсэндээ олонхоо авна.

Тэгээд энэ дээр нь нэмэх нь дахиад Үндэсний эвсэл, ХҮН нам хоёр чинь дахиад нэг нэг хүнтэй Зарлагын хяналтын хороонд байгаа.

Одоо Монгол Ардын нам 4 хүнтэй дээрээ нэмээд 2 хүнээ аваад ХҮН нам, Үндэсний эвсэл хоёроос дахиад авна гэх юм бол энэ чинь үндсэндээ 8 хүнтэй Зарлагын хяналтын дэд хороо.

Дарга нь симболоороо Ардчилсан намд, цөөнхөд гэж байгаа боловч олонхыг нь бүрдүүлж байгаа хэсэг чинь засаг барьж байгаа талдаа байгаад байгаа учраас үүнийг хэлэлцэх асуудлаасаа хасаад, энэ бүрэлдэхүүнийхээ асуудлыг дахиж ярилцъя гэдэг ийм саналтай байна.

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүн горимын санал юм байна. Тийм ээ. Горимын санал гаргалаа.

Хоёр дахь асуудлыг хасъя гэсэн санал гаргалаа. Санал хураана.

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Гишүүд орж ирээрэй. Төсвийн байнгын хорооны гишүүд орж ирээрэй. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн үү? Ирцийн санал хураалт явуулъя. Санал хураалт болж байна.

Горимын санал гаргасан Да.Цогтбаатар гишүүний саналаар санал хураалт явуулъя.

Хоёр дахь асуудал буюу Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулъя гэсэн томьёоллоор санал хурааа. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

21 гишүүнээс 11 хүн дэмжиж, 52.4 хувиар хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа орьё. Нэгдүгээр асуудал.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115.2.18-д хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороо жил бүр хэлэлцэнэ гэсэн хуулийн зохицуулалттай.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга,

Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,
Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,
Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,
Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,
Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Тайлан, илтгэл мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.

Тамгын газрын ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Ганбатын Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Жамбалдоржийн Сайнхишиг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга, Цогт-Очирын Лхагвагэрэл Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан танилцуулна.

Ажлын хэсгийн 2 дахь микрофоныг өгье.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг товчлон танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу орон тооны 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гишүүдийг Улсын Их Хурлаас 4 жилийн хугацаатайгаар томилсон.

2024 оны 01 сарын ар 11-ний өдөр бүрэн бүрэлдэхүүнээрээ томилогдож 2025 оны 9 сар хүртэл энэ бүрэлдэхүүн зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлж ирсэн.

Харин 2025 оны 9 сард ажлын албатай болж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл институцийн хувьд харьцангуй бэхэжсэн болно.

Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус мэргэжлийн байгууллага бөгөөд нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангах, Улсын Их Хурлын төсвийн хяналтыг бэхжүүлэх, төсвийн бодлогын шийдвэрүүдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хараат бусаар үнэлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

2027 оны 7 дугаар сараас өмнө Зөвлөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ашиглагдах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалыг боловсруулах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, төсвийн тодотгол болон хөгжлийн төлөвлөгөөний төсөлд дүгнэлт гаргах, мөн эдгээр баримт бичгүүдийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлуудыг хийж байсан. Бас Засгийн газрын санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, мөн Төсвийн

байнгын хорооны өгсөн чиглэлийн дагуу бодлогын баримт бичгүүдийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх зэрэг үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байсан.

Харин 2025 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн эрх зүйн орчинд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд зөвлөлийн чиг үүрэг, оролцооны хүрээ өргөжиж, төсвийн төслийн боловсруулалтын шатад төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн зардлын санал хуулийн хязгаарт нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, төсвийн боловсруулалтад олон нийтийн оролцоог хэрхэн хангаж ажилласан болон түүний үр дүнг төсөвт тусгасан эсэхэд хяналт тавих.

Уг асуудлаар гаргасан саналыг төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлэх үндсэн хяналтын чиг үүрэг нэмж хэрэгжүүлж ирсэн.

Мөн төсвийн төслийн хэлэлцүүлгийн шатад төсвийн төсөл нь Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, улсын хөгжлийн бодлоготой уялдаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох Байнгын хороо, дэд хороодыг тооцоо мэдээллээр хангах ажлыг хийж байна.

Түүнчлэн нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэлд богино хугацаанд дүн шинжилгээ хийх, дүгнэлт саналын хамт Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэх замаар төсвийн хэрэгжилтэд тасралтгүй хяналт тавих чиг үүргийн нөхцөл бүрдсэн.

Эдгээр өөрчлөлтийн үр дүнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь төсвийн бодлогын боловсруулалт, хэлэлцүүлэх үе шат, хэрэгжилтийн бүх шатад оролцдог Улсын Их Хурлын хараат бус мэргэжлийн институц болж бэхжиж байна.

2025 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь өөрийн хуульд заасан бүрэн эрхийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдлын таамаглал, дүгнэлт боловсруулахаас гадна Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, төсвийн эрх зүйн орчны өөрчлөлтөд өөрсдийн саналыг өгөх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдолтой байр сууриа илэрхийлэх болон бусад холбогдох дүгнэлт, зөвлөмжийг Улсын Их Хурал болон холбогдох талуудад хүргүүлэх байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлсэн байна.

Зөвлөлөөс 2025 онд макро эдийн засгийн таамаглал боловсруулах, төсөв болон хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, 2026-2028 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд уг таамаглалд гадаад, дотоод орчны шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг хамруулан боловсруулсан.

Шинжилгээгээр түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад зах зээлийн тодорхойгүй байдал нь экспорт, төлбөрийн тэнцэлд эрсдэл дагуулж байгааг онцолсон бөгөөд дотоодын хувьд эдийн засгийн өсөлт өндөр байсан ч уул

уурхайн орлогоос хэт хамаарал, төсвийн тэлэлт нэмэгдсэн дунд хугацаанд төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг онцолсон.

Хөгжлийн төлөвлөгөө болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн дүгнэлтээр хөгжлийн бодлогын зорилтуудын уялдаа, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд, санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой байдал, төсөл, арга хэмжээний эрэмбэлтийг сайжруулах шаардлагатайг тэмдэглэсэн.

Түүнчлэн макро эдийн засгийн таамаглал болон орлогын төлөвлөлтөд хэт өөдрөг хандлага ажиглагдаж байгааг анхааруулж, тэнцвэржүүлсэн үнэд тооцох аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатайг дурдсан.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн шинжилгээгээр төсвийн орлого, зарлага өндөр түвшинд хүрсэн боловч төсвийн бодлого, мөчлөг сөрсөн зарчмыг баримтлаагүй, төсвийн тэлэлт нэмэгдсэн, төрийн оролцоог бууруулах шаардлага хэвээр байгааг онцолсон.

Мөн төсвийн бодлогын үр нөлөөг үнэлэх тогтолцоо сул, хөрөнгө оруулалтын үр ашиг хангалтгүй байгааг тэмдэглэсэн.

Төсвийн тодотгол болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах төслүүдэд дүгнэлт өгснөөр орлогын төлөвлөлт бодит нөхцөл байдлаас зөрөх, түүхий эдийн үнийн таамаглал хэт өндөр байх нь төсвийн алдагдал, өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэйг анхааруулж ажилласан байна.

Төсвийн төслийг боловсруулах явцад төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан төсвийн хязгаарыг мөрдөхгүй, зардлын санал хязгаараас давсан, төлөвлөлт нь бодлогын бус байгууллагын хэрэгцээнд тулгуурлах хандлагатай байгааг ажиглагдсаныг дур дурдсан.

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд тодорхой ахиц гарсан ч хэлэлцүүлгийн чанар, үр нөлөө сул хэвээр хэмээн үзэж үүнийг холбогдох санал дүгнэлтдээ тусгасан болно.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр төсвийн бодлогын тэлэлтийг хязгаарлах, төрийн оролцоог бууруулах чиглэлд баримталж байгаа нь зөв боловч урсгал зардлын өсөлт өндөр хэвээр, төсвийн бодлого болон хөгжлийн бодлогын уялдаа хангалтгүй, төсвийн бодлогын орон зай хумигдсаар байгаагаас макро эдийн засгийн эрсдэл өндөр болж байгааг онцлон тэмдэглэсэн.

Тайлант хугацаанд зөвлөл нь нийт 16 асуудлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж боловсруулсан бөгөөд үүнд 94 дүгнэлт, 26 зөвлөмжийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн.

Зөвлөл өөрийн дүгнэлт, зөвлөмж, байр суурийг parliament.mn веб сайт дээр байршуулж олон нийтэд түгээж байгаа бөгөөд 2026 оны 4 сарын 01-ний өдрийн байдлаар 15 мянга 748 удаагийн хандалт авсан нь олон нийт, судлаачдын анхааралд хүрч, зөвлөлийн дүгнэлт, мэдээллийн ил тод байдал, хүртээмж нэмэгдэж буй хэрэг хэмээн зөвлөлийн зүгээс үзэж байна.

Үүнээс гадна зөвлөл нь 2025 онд төсвийн бодлогын ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллалаа.

Олон нийтийн хэлэлцүүлэг, хэвлэл мэдээлэл болон бусад байгууллагуудтай хийсэн уулзалт, ярилцлагын хүрээнд төсвийн бодлогын үндсэн асуудлуудаар мэдээлэл солилцож, санал, дүгнэлтээ олон нийтэд нээлттэй хүргүүлсэн.

Мөн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсвийн бодлогын чиглэлээр олон улсын туршлагаас суралцан, цаашид хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг дунд болон урт хугацаанд хангах эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, нотолгоонд суурилсан дүн шинжилгээг бэхжүүлэх, бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2025 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл голлон анхаарч ажилласан байна.

Монгол Улс цаашдаа улсын төсвийг –

- ▶ төлөвлөх,
- ▶ хэлэлцүүлэх,
- ▶ батлах,
- ▶ хэрэгжүүлэх,
- ▶ тайлагнах –

-үе шатуудад тодорхой ахиц гаргах, төсвийн сахилга бат, төлөвлөлтийн бодитой байдал, бодлогыг уялдааг сайжруулах шаардлагатай гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үзэж байна.

Энэ бол манай зөвлөлийн гол дүгнэлт гэж бид ойлгож Та бүхэнд танилцуулж байна.

Цаашид төсвийн тогтвортой байдлыг хангуулах, хуулийн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурал холбогдох талуудыг бодитой –

- дүгнэлт,
 - судалгаа,
 - шинжилгээ,
-

— мэдээллээр хангах —

-ажлыг улам чанаржуулах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрийнх нь институцийн чадавхыг нэмэгдүүлэх, судалгаа шинж шинжилгээ, хүний нөөц, макро эдийн засгийн судалгаа, загварын чиглэлд болон олон улсын болон дотоодын хамтын ажиллагаагаа сайжруулахаар ажиллаж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Н.Наранбаатар: Ж.Дэлгэрсайхан даргад баярлалаа.

Одоо тайлантай холбогдуулж ажлын хэсгээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа Г.Тэмүүлэн гишүүн. Б.Мөнхсоёл гишүүнийг нэмээрэй.

Г.Тэмүүлэн: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн энд тайлангаа оруулж ирж байна.

Албан ёсоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бий болоод 2 жил гаруй хугацаа болж байна.

Тэгэхээр үндсэндээ энэ улс орны эдийн засгийг бид төсөв санхүүгээс салгаж ойлгох боломж бололцоо байхгүй. Тэр дундаа эдийн засаг нь өөрөө эрүүл, зөв байя гэвэл хүссэн ч хүсээгүй ч бид төсвийн сахилга батыг заавал мөрддөг байх. Дээрээс нь хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага байгаа.

Энэ хүрээнд манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үндсэн суурь үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа гэж хувь хүнийхээ үүднээс үзэж байгаа.

Үндсэндээ Монгол Улсын хувьд нэг талдаа энэ улс орны эдийн засаг нь өөрөө их өрөөсгөл бүтэцтэй. Уул уурхай болоод энэ баялгийн хараалаас бүрэн дүүрэн хамааралтай.

Тэгээд түүхий эдийн үнэ өсөх бүрд эдийн засагт халаалт өгдөг. Пагаад цалин хөлсөө нэмдэг ч гэдэг юм уу, валютын ашиг нь чангардаг, зардлууд нь тэлдэг, өсдөг.

Тэгэхээр энэ байдлууд дээр уг нь бид тодорхой өсвийнхөө дүрэм, журмуудыг баримтлаад, төсвийнхөө тогтвортой байдлын хуулиа сахиж мөрдөөд, Үндсэн хууль мэт мөрдөж явбал уг нь улс орны эдийн засагт хэрэгтэй ийм л зүйл байгаа.

Би нэг зүйлийг Байнгын хорооны гишүүддээ мэдээлэл болгоод хэлэхэд 2024 оны 9 сард Сангийн яамнаас өргөн барьсан хуулийн дагуу төсвийн суурь тэнцэл, төсвийн суурь зарлага гэдэг үндсэндээ олон улсад байхгүй шинэ нэр томьёо, шинэ тодорхойлолтыг бий болгосон.

Энэ хүрээндээ үндсэндээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр байсан үндсэн 4 дүрмийнх нь 2 дүрмийг нь байхгүй болгосон байгаа.

Тэгээд уул уурхайгаас ямар нэг байдлаар хамгаалалт хийж байсан, уул уурхай, түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарсан гэнэтийн орлогоос хамгаалалт хийж тодорхой савлагаа үүсгэхээс сэргийлж байсан, зардлуудыг хэт нэмэгдүүлэхээс хориглож байсан энэ хоёр үндсэн дүрэм 2024 оны 9 сард байхгүй болсон байгаа.

Тэгэхээр нэг талдаа энэ дүрэм, журмуудыг бид олон улсынх нь стандартын дагуу, цаашид бас төсвийн сахилга батаа мөрдүүлэхэд хэрэгтэй энэ бодлогуудаа буцааж бий болгох зайлшгүй шаардлага байна гэж үзээд байгаа.

Энэ үндсэн дээр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр өмнө нь байсан Олон Улсын Валютын Сангаас болоод бусад олон улсын стандартын дагуу байх ёстой дүрмүүдийг буцааж оруулах нь хуулийн төслийг өргөн барихад бэлэн болсон байгаа.

Тэгэхээр би Төсвийн тогтвортой байдлын зөвлөл буцааж оруулах энэ хоёр дүрмийг дэмжиж байгаа байх гэж бодож байна.

Төсвийн байнгын хорооны гишүүдийг ч гэсэн энэ хуулийн төслийг өргөн барихад хамтарч оролцоорой. Энэ бол цаашдаа Монгол Улсын төсөв, санхүүгээр эрүүл байх суурь зарчмуудыг мөрдүүлэхэд хэрэгтэй зүйл байгаа.

Тэгээд ямар нэг хэрэгжүүлэх хугацааг нь хугацаагүйгээр Их Хурал дээр өөрсдөө тодорхой хугацааг нь зохицуулаад шийднэ биз гэсэн байдлаар энэ хуулийн төсөл... /минут дуусав/

Н.Наранбаатар: Хариулт. Хэн хариулах вэ? 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

2024 оны 9 сард орсон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээрх үзсэн төсвийн тусгай шаардлагуудын өөрчлөлтүүдийг тухайн үедээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргаж эсэргүүцсэн байр суурьтай байсан.

Энэхүү өөрчлөлтүүдийг хийх нь буруу бөгөөд төсвийн бодлогын тогтвортой байдал, төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг сулруулах нөлөөтэй гэж үзэж байсан.

Үүний дараа бид тодорхой дүгнэлтүүд дээрээ төсвийн энэ тусгай шаардлагуудыг өөрчилсөн нь буруу бөгөөд энэ тусгай шаардлагуудыг буцаан авч хэрэгжүүлэх шаардлага бол байна гэж үзсэн.

Учир нь тэдгээр дээр төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах гол дүрмийг алга болгосон. Төсвийн урсгал зардлыг 30 хувь хүртэл байж болохоор оруулж өгсөн.

Энэ байдал нь төсвийн зарлагын тэлэлт, ялангуяа урсгал зарлагын тэлэлтийг нэлээд өндөр байх ийм боломжийг бүрдүүлсэн ийм өөрчлөлт болсон.

Ерөнхийдөө өөрчлөлт нь өөрөө сөрөг өөрчлөлт байсан учраас үүнийг бид тэр буцаах. Тухайн үедээ эсэргүүцэж, дараа нь буцаах саналтай байгаагаа илэрхийлж байсан.

Тийм учраас хэрвээ ийм санал гарвал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс эергээр хүлээж авах магадлалтай гэдгийг хэлье.

Бид үүнийг хуулийнхаа дагуу хамтаараа хэлэлцэж байж эцсийн шийдвэр гаргадаг учраас ийм байдлаар хариултыг хязгаарлая.

Н.Наранбаатар: Б.Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Өмнө хэлсэн Г.Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байгаа.

Тэр утгаараа Г.Тэмүүлэн гишүүний санаачилсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Хоёрдугаарт нь, бид бүгдээрээ мэдэж байгаа. Төсвийн орлого одоогоор 720 тэрбум төгрөгөөр дутсан байна.

Тэгээд энэ байдал дээр манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн ямар дүгнэлт хийж байна.

Нөгөө талдаа ард иргэдийн олон нийтийн ажил, амьдрал хэцүүдэж байна. Өдөр тутмын өргөн хэрэглээний барааны үнэ, тариф нэлээн өссөн. Тухайлбал, махны үнийн өсөлт 52.6 хувиар өссөн гээд. Энэ нөхцөл байдал дээр Та бүхэн энэ нь эргээд төсөвт ямар үр дагавар авчирна гэж харж байгаа дүгнэлтээ хэлээч.

Ер нь энэ энгийн мэт боловч, жижиг мэт боловч энэ байдал чинь эргээд ирэх жилийнхээ Төсвийн тухай хуулийн байдалд нөлөөлөхөөс гадна өнөөдрийн төсвийн тодотгол хийх байдалд хүргэх ийм магадлалтай олон асуудлууд учирлаа.

Нэмээд бүр макро түвшиндээ бол геополитикийн олон асуудлууд гарч ирлээ. Энэ дээр товч дүгнэлтүүдээ хэлээч гэж бодож байна.

Мөн нэмээд гадаад зээлийн энэ хуулийн төсөл яригдаж байна шүү дээ.

Одоо ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг Та бүхэн харсан байх. Өнгөрсөн тав дахь өдөр. Гишүүд ер нь хуваагдмал байдалтай болсон.

- Төсвийн дүрмүүдээ баримаар байна.
- Төсвийн сахилга батаа хангамаар байна.
- Төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуулийг сахимаар байна.

Гэтэл нөгөө талдаа олон улсын Элчингүүд ирж уулзаж байна. Газрын тосны үйлдвэр дээр гэхэд инженерүүдийн цалин тавигдахгүй байна гэх мэтээр.

Тэгээд аргаа бараад 3 төсөл орж ирэхэд нь 3 дахь төсөл буюу тэр Сэлбийн дэд бүтцийн дэргэд түшиглэсэн гэр хорооллын төслийг нь хасаж байгаад энэ хуулийг явуулахыг бодъё гэтэл буцаад тухайн асуудал босож байгаа юм.

Тэгэхээр гэх мэт дандаа ийм англиар **dilemma** гэж хэлдэг. Монголоор алийг нь сонгоход хэцүү байдалд байнга орж байна. Энэ дээр манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн ямар санал бодолтой байна. Сонсмоор байна. Энэ асуудал тэгээд хойшилсон байгаа шүү дээ.

Та бүхэн анзаарсан байх.

Н.Наранбаатар: 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя.

Хоёр үндсэн асуулт байна гэж ойлголоо.

- ▷ **Нэгдүгээрт**, өнөөгийн эдийн засагт үзээд байгаа нөхцөл байдлын талаар бид Улсын Их Хурлын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу тодорхой санал боловсруулж, сая 4 сарын 13-нд Улсын Их Хуралд хүргүүлсэн байгаа.

Энэ хүрээндээ бид гол эрсдэлүүдийг харахдаа бид гадаад эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаатай эрсдэлийг 3 түвшинд үнэлж, үүнтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн саналыг боловсруулсан.

Бидний үзэж байгааг товчлон хэлбэл ерөнхийдөө гадаад эдийн засгийн нөхцөл байдлаас Монгол Улсын эдийн засагт тодорхой хэмжээний нөлөөлөл орж ирэх нь ойлгомжтой байна.

Гэхдээ энэ нөлөөллийн түвшин дээр бид хэт яарсан, түргэдсэн арга хэмжээ авахгүй байхыг бид зөвлөж байгаа.

- ▷ **Хоёрдугаарт нь**, хамгийн их эмзэг бүлгүүдэд чиглэсэн бодлогын арга

хэмжээнүүд чухал байж болно гэж үзэж байна.

Бодлогын сонгох сонголтуудын үр дүнг хэрэгжүүлэхдээ урдаас бид төлөвлөсөн бодлогын сонголтынхоо үр дүнг харсан байдлаар хийхгүй бол гадаад эдийн засгийн шокт цочирсон ийм хариу үйлдлүүдийг огцом хэрэгжүүлэх нь эргээд эдийн засагтаа эрсдэлийг үүсгэж болзошгүй гэсэн.

Бидний таамаглалаар гадаад эдийн засгийн эрсдэл 3 түвшинд байж болох бөгөөд энэхүү Ойрхи Дорнодтой холбоотой, дайн байлдаантай холбоотой үүссэн нөхцөл байдлыг бид хэвийн байдалдаа эргээд тун удахгүй орох, дунд хугацаанд өсөлт нь одоогийн түвшиндээ хадгалагдах, одоогийн түвшнээсээ дээш өсвөл яах вэ гэсэн хувилбаруудаар тооцоолж, энэ түвшнүүдэд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүд болон хэрэгжүүлэх шаардлагагүй арга хэмжээ гэдэг энэ зүйлүүдийг бид санал болгосон.

Тэгэхээр энэ хэрэгжүүлэх шаардлагагүй арга хэмжээнүүд дотор бид –

- төсвийн эрх зүйн орчин;
- төсвийн тогтолцоонд сөрөг нөлөөлөх өөрчлөлтийг хэрэгжүүлэхгүй байх;
- төсвийн бодлогоор дамжин эдийн засгийг дэмждэг хуучин уламжлалт арга замыг сонгохгүй байх;

-гэх мэтийн арга хэрэгслүүдийг бид санал болгосон.

Хэрэгжүүлэх шаардлагатай зүйл дээр хамгийн гол нь эргээд хэвийн байдалд орвол гэдэг дээр бид өнөөдөр хэрэгжүүлж байгаа төсвийн бодлогоо үргэлжлүүлээд, төсвийн тэлэлтийг хязгаарласан энэ бодлогоо цааш нь үргэлжлүүлээд болгоомжтой явахад харьцангуй цохилт гайгүй болов уу гэж харсан. Товчлоод хэлэхэд.

Хэрвээ дизелийн үнэ өндөр түвшиндээ байгаад байх юм бол, эсвэл үүнээс цааш өсөх юм бол онцгой нөхцөл байдал гэж үзэж тодорхой цогц төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй юм гэсэн ийм л зөвлөмжүүдийг бид өгсөн.

Хоёр дугаар асуултын хувьд “гадаад зээлийн ашиглалт” дээр мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрсдийн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан өгсөн.

Энэ дээрээ бид нэг л байр суурийг маш тодорхой хэлсэн байгаа. Энэ нь гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийг хэрвээ хэрэгжүүлэх юм бол төсвийн тогтвортой байдал, төсвийн эрх зүйн орчин, төсвийн дүрэм бөгөөд төсвийн цаашдын тогтолцооны байдлыг бүрэн эвдэх магадлалтай ийм том сөрөг нөлөөтэй ийм хууль санаачилж оруулж ирсэн байна.

Ийм учраас ийм хуулийг бид дэмжих боломжгүй гэдгээ дүгнэлтдээ маш тодорхой хэлсэн.

Ийм учраас бид тухайн дүгнэлт дээр дэлгэрэнгүй хариултууд байгаа гэдэг ийм байдлаар хариултыг хязгаарлая. Бидний байр суурь бол их тодорхой байсан.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэж их зөв байгууллага байгуулагдаж, тэгээд төсвийгөө тогтвортой байлгах санаатай нэлээн ажиллаж байгаа.

Би ч заримтай нь уулзаж, саналыг нь сонсож, зөвлөгөө авдаг юм.

Тэгэхээр энэ байгууллага харин нэг зөвлөдөг, одоо нэг нохойгоор нэг жижигхэн хав шиг амьтан хуцаад хуцаад л тэгээд л дуу нь ч хүрдэггүй нэг тийм л чадваргүй, потенцгүй л амьтан болоод байна л даа.

Одоо тэгэхээр Ж.Дэлгэрсайхан дарга, өмнө нь Н.Энхбаяр дарга байсан юм.

Ж.Дэлгэрсайхан дарга аа, надад ямар асуулт байгаа вэ гэхээр бид нарын энэ төсвийн тогтвортой байдлыг эвдсэн ямар ямар хуулийн төсөл Их Хуралд орж ирэв? Та нэг, хоёр, гурав, дөрөв гээд нэг хэлээдхээч.

Би нэг жишээг нь хэлье. Сая Г.Тэмүүлэн гишүүн хэлж байна.

Төсвийн тогтвортой байдал гэж баахан юм баталчхаад түүнийгээ эвдэлсэн хууль оруулж ирээд байхаар чинь одоо яаж тогтвортой байх вэ дээ.

Тэгэхээр та надад намраас хойш. Намар биш хавраас хойш. 2025 онд жишээлэх тэгэх юм бол төсвийн тогтвортой байдлыг эвдэх ямар ямар хуулиуд орж ирэв?

Сая ганц хууль орж ирсэн шүү дээ.

Ер нь энэ Улсын Их Хурлын гишүүд гадаадын зээлийн үр ашгийг нэмэгдүүлнэ гэдэг нэртэй төсвийн тогтвортой байдлыг эвдэлсэн хуулийг санаачилж болохгүй шүү дээ.

Тэгээд оруулж ирээд баталсан шүү дээ.

Одоо дахиад нэг Польшийн 50 сая гээд нэг зээл явж байна лээ. Тэр дотор жишээ нь Эрдэнэтэд. Намайг Эрдэнэтэд сонгогдсон үед л авсан зээл байна лээ. Тэр үйлдвэр нь босоо ч үгүй. Хогийн үйлдвэр. Дахиад л 9 сая евро бичсэн явж байна лээ. Гэх мэтчилэн гадаадын зээл гээд байгаа юм чинь.

Эсвэл өөр бусад үзүүлэлтүүдийг нь өөрчилсөн яг ямар ямар юм байна? Та нэг, хоёр, гурав, дөрөв гээд хэлээдэх. Би тэгээд юм тодруулж асуух гээд байгаа юм.

Одоо та нар сүүлд тэр Н.Алтаншагай нарын гишүүдийн санаачилсан хууль ерөөсөө Их Хурал дээр ийм хууль хэлэлцэж болохгүй. Би Байнгын хороон дээр саналаа хэлээд би гараад явсан.

Өмнөх юмаа эвдэлж байгаа хууль оруулж ирэхээр би хэлэлцэх асуудлаас хасаад өгөөч гэж гуйгаад хасахгүй болохоор нь би тэр хуралд суудаггүй.

Тэгэхээр хурал тасалсан гэж хэлээд байх юм.

Ер нь Үндсэн хууль зөрчсөн хууль өмнөх баталсан хуультайгаа зөрчилдсэн, эсвэл Их Хурлын гишүүдийн санаачилж болохгүй хууль энэ тэрийг оруулмааргүй л байх юм.

Одоо энэ Б.Жавхлангийн хийсэн ажил гэж би хардаг юм. Өөрөө юмаа оруулж болохгүй болохоор нь хэдэн гишүүдийг нь хүзүүнд нь углаж тавиад тэгээд одоо ингэж юм сүйдэлдэгээ болимоор байна.

Та нэг, хоёр, гурав, дөрөв гээд нэг хариулт хэлээдэх. Яаж эвдэрсэн юм бол? Тэгээд.

Н.Наранбаатар: Ж.Дэлгэрсайхан дарга. 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Н.Алтанхуяг гишүүнд баярлалаа. Асуултад хариулъя.

Ер нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль маш их өөрчлөгдөж ирсэн гэдэг түүхийг Та бүхэн мэдэж байгаа.

Бид энэ хуулийг хэрэгжүүлж эхэлснээсээ л хойш байнга Төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуулийг эвдэж ирсэн.

Мэдээж сайн өөрчлөлтүүд байсныг үгүйсгэхгүй. Гэхдээ төсвийн гол дүрмүүд, төсвийн өрийн тааз бүгдийг нь өөрчилсөн.

Бидний бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойших гурав, дөрвөн гол өөрчлөлтийг нэрлэ гэж хэллээ.

▷ **Нэгдүгээрт,** түрүүн Г.Тэмүүлэн гишүүний дурдсан 2024 оны 8 сард орж ирсэн төсвийн тодотголыг дагалдуулж орж ирсэн тэр төсвийн дүрмүүдийг, ялангуяа хоёр гол дүрмийг нь эвдсэн өөрчлөлт Монгол Улсын төсвийн тогтвортой байдал, төсвийн бодлого, төсвийн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх, төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах гол том нөлөөг үзүүлсэн ийм өөрчлөлт байсан.

- ▷ **Хоёрдугаарт**, 2025 оны 7 сард орж ирсэн бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн сайжруулсан өөрчлөлт байсан.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 3 сарын дотор өөрчилж болохгүй буюу ядаж байнга өөрчлөгддөг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилдээ төсөв батлах хүртэл тогтвортой хадгалах боломжтой байсан энэ зүйл бол 7 сард орж ирсэн хуулиар нэг удаагийн шинж чанартай гэсэн байдлаар өөрчлөгдөж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх орон зайг нээж өгсөн энэ хууль анх удаа хэрэгжиж эхлэхэд нь өөрчилсөн ийм харамсалтай өөрчлөлт байсан.

Цаашдаа бид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг ягштал барих, баталсан дунд хугацааны бүх хүрээний мэдэгдлээ төсвийн тодотгол, төсвийн төслийг дагуулж өөрчлөгдөхгүй байх ийм зүйлийг хийх ёстой гэж бодож байна.

- ▷ **Гуравдугаарт**, саяын таны дурдсан гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай тодорхой нэр бүхий 25 гишүүний 12 сард өргөн барьсан энэ хууль бол маш осолтой хууль гэж бид өөрсдийн зүгээс харж дүгнэсэн.

Б.Мөнхсоёл гишүүний хариулт дээр нэмээд хэлэхэд энэ хуулийг хэрвээ хэрэгжүүлбэл бид төсвийн гадуур дахиад төсөвтэй болох, төсөвт тодорхой хэмжээний сул орон зайг үүсгэх боломжийг нээх ийм маш том хор хохиролтой хууль байх боломжтой харагдаж байгаа.

- ▷ **Дөрөвдүгээрт**, сая өргөн бариад буцаан татагдсан татварын эрх зүйн орчинтой холбоотой өөрчлөлтүүд байгаа.

Татварыг бид хувийн хэвшлийг дэмжих, төрийн оролцоог бууруулах чиглэлд татварын реформ хийх ёстой гэдгийг дэмжиж байгаа боловч татварын өөрчлөлтүүдийг өмнө явсан бодлогуудыг харж, эдийн засгийн нөлөөллийн тооцоололгүйгээр огцом өөрчлөлт хийвэл макро эдийн засагтай болон төсөв, төсвийн орлого талдаа аль алинд нь эрсдэлтэй байх учраас иймэрхүү огцом өөрчлөлтүүдийг нэлээд тооцоолж судалгаатай, үе шаттайгаар хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн байдалтайгаар харж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн тодруулна.

Н.Алтанхуяг: Баярлалаа.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь ингээд зөвлөмжөө гаргаад өгөөд л байгаа юм л даа.

Тэгээд манайх юу байх вэ дээ, энэ Засгийн газар тэрийг нь авахгүй байна. Засгийн газар ч гэж аль Засгийн газар нь ч юм мэдэхгүй их ойрхон ойрхон гурав ч солигдоод явлаа.

Одоо Ерөнхий сайд чинь Н.Учрал болсон. Сангийн сайд нь хэн нь ч билээ нэг нөхөр болсон.

Н.Наранбаатар дарга аа, манайх чинь Төсвийн байнгын хороо байхгүй юу.

Ядаж манай Байнгын хороо манаачаа хиймээр байна шүү дээ.

Ямар манаач вэ гэхээр төсвийн тогтвортой байдлыг эвдлэн сүйтгээд байгаа хуулийн төслүүдийг өргөн барихыг. Өргөн барина л биз дээ. Энэ дээрээ хэлэлцэхгүйг буцаадаг баймаар байна шүү дээ.

Би бас энд хэлсэн шүү дээ.

Энэ Н.Алтаншагай нарын гишүүд. Чааваас тэр гишүүдийн буруу ч гэж юу байх вэ. Хүзүүнээс нь нэг юм дүүжлээд. Юу ч гэж тохирсон юм. Тэгээд л оруулдаг.

Энэ ингээд тэр гишүүний асуудал биш, Монгол Улсын төсвийн төсвийн тогтвортой байдлыг эвдлэн сүйтгэж байгаа асуудал. Г.Тэмүүлэн гишүүний... /минут дуусав/

Н.Наранбаатар: Хариулах уу? Асуулт байхгүй. Х.Булгантуяа гишүүн асуулт асууна. Д.Пүрэвдаваа гишүүнийг нэмээрэй. Асуултад.

Х.Булгантуяа: Төсвийн тогтвортой байдлын эрх зүйг сайжруулах чиглэлээр бид өнгөрсөн хаврын чуулган дуусахад Төсвийн тухай хуульд зарим өөрчлөлтүүдийг оруулаад цаглаварт өөрчлөлт оруулахад Төсвийн хяналт шинжилгээний газар гээд Улсын Их Хурлын Тамгын газар дээр байсныг ер нь татан буулгаад дээрээс нь илүү Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба байдлаар ажиллах боломжийг нь бид нээж өгсөн.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нийгэм, олон нийтийн зүгээс хүлээлт их байдаг.

Тэгээд би ийм хэдэн саналуудыг хэлэх гэсэн юм.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ганцхан намар төсөв өргөн барихад дүгнэлт өгөөд, мөнгөний бодлогоо зэрэг өргөн баригддаг.

“Мөнгөний бодлого”, “төсвийн бодлого” хоёрыг уялдаа холбоог хангах чиглэлээр ер нь хэн ч дүгнэлт өгөхгүй байх шиг харагдаад байдаг юм.

Тэгээд мөнгөний бодлого бол Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдээд өнгөрдөг. Төсвийн бодлого эндээ хэлэлцэгдээд явдаг.

Нэгэн зэрэг өргөн баригдахаар хүмүүс, нийгэм ч гэсэн төсөвт илүү их анхаараад.

Хэрвээ нэгэнт л Улсын Их Хурлаар “төсвийн бодлого”, “мөнгөний бодлого” хоёр нэгэн зэрэг хэлэлцэгдэх гэж байгаа бол үүний уялдаа холбоог хангах чиглэлээр Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хоёр хамтарсан байдлаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөр. Шаардлагатай бол нэмээд Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлын зөвлөл. Тэр нь төсөв, мөнгөний бодлого давхар өргөн барьж байгаа хоёр сайд ороод л, дээрээс нь нэмээд Санхүүгийн зохицуулах хорооны дарга гээд ийм хэдэн хүмүүс байгаад байдаг.

Одоо сүүлийн жилүүдэд нэг ийм зүйл ажиглагдаад байгаа юм. Манай мөнгөний бодлого хэтэрхий их тэлээд, жилээс жилд тэлдэг.

Ингээд мөнгөний бодлого ажиллах ерөөсөө орон зай бараг байхгүй.

Уг нь дэлхийн улс орнуудын бодлого эдийн засаг их хүнд үед мөнгөний бодлого, төсвийн бодлого хүчтэй орж ирж зарим нэг тохируулгууд, зохицуулалтуудыг хийдэг болохоос биш мөнгөний бодлогоор л ер нь эдийн засгаа илүү их удирдаж орж ирээд байдаг.

Гэтэл манайх ерөөсөө төсвийн бодлого нь гол үүрэг чиглэлтэйгээр байнга оролцоод мөнгөний бодлого дээр анхаарч байгаа ч хүн байхгүй.

Ингээд нэгэн зэрэг хэлэлцэгдээд явахад бүх нийгэм, улс төрчид ч тэр төсвийн бодлого дээрээ санаа зовсоор байгаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч энэ хоёрын уялдаа холбоог хангах дээр хэн ч анхаарал хандуулахгүй явснаас үүдээд бид нэг далавчтай эдийн засгийн бодлогын хувьд шувуу шиг болоод байгаа учраас манай эдийн засгийн бодлого, төсвийн бодлогоор гэдэг чинь төрийн оролцоог л дандаа нэмэгдүүлж явж байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр бид үүн дээрээ яаж анхаарах ёстой гэж үзэж байна вэ? Тэгээд манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дэлхийн бусад улс орнуудын хувьд ер нь юу гэж харж байна вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид тайлан хэлэлцэж байгаа цаг үед, эдийн засгийн засаг хүнд байгаа цаг үед төсвийн бодлого дээр ер нь бусад улс орны талаар... /минут дуусав/

Н.Наранбаатар: Хариулъя. 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Баярлалаа. Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Бид Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд бидний бүрэн эрхийг тодорхой заагаад өгсөн байдаг.

Мөнгөний бодлого дээр бидэнд тодорхой үүрэг байдаггүй учраас зүгээр хувийн бодлоо хэлье.

Х.Булгантуяа гишүүнтэй санал нэг байна. Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүдэд байнга дурдсанаар бид мөчлөг сөрсөн төсвийн бодлогоо хэрэгжүүлж чадахгүй байна. Төсвийн хэт тэлэлт нь мөнгөний бодлогын орон зайгаа шахаж байна. Төрийн оролцоо хэт нэмэгдсэн нь мөнгөний бодлогыг чөлөөтэй хэрэгжүүлэх боломж байхгүй болгож байгаа гэдэг тал руу манай дүгнэлтүүд гардаг.

Тийм учраас санал нэг байгаа зүйл нь төсвийн бодлогыг хэзээ ашиглах вэ, гэх мөчлөг сөрсөн бодлогоо тууштай ашиглаж, мөнгөний бодлогод орон зай гаргаж, эдийн засгийн суурь баазыг мөнгөний бодлогоор дамжиж тэтгэх ёстой гэдэгтэй би хувь хүний хувьд санал нэг байна.

Дараагийн асуултад нь, яг өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдалд улс орнуудын хувьд төсвийн бодлогуудаа хэрхэн өөрчилж байгаа тал дээр мэдээлэл одоохондоо хараахан алга байна.

Харин бидний сая түрүүний дурдсан 4 сарын 13-нд Улсын Их Хурлын даргын даалгаврын дагуу хийсэн бидний тайлан дээр улс орнууд өнөөгийн эдийн засгийн нөхцөлд тохируулан нефтийн бүтээгдэхүүнтэй холбоотой тодорхой зоримог өөрчлөлтүүдийг хийж байгаа.

- Нөөцөө нэмэгдүүлэх;
- нефтийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах;
- нефтийн бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах –

-тал руугаа тодорхой хэмжээний тактикийн арга хэмжээнүүд авч байгаа талаар бидний тайланд байгаа бөгөөд бид тийм зүйлийг олж харсан.

Зарим улс орнууд нефтийн бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг урт хугацааны гэж байдлаар хараад, ер нь цаашдаа нефтийн бүтээгдэхүүн болон энергийн бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг бууруулах урт хугацааны стратегийн бодлого авч хэрэгжүүлж байгаа байдлууд ажиглагдаж байгаа.

Тэгэхээр яг энэ дээр улс орнууд төсвийн бодлогоор дамжуулж эрсдэлийг бууруулъя гэсэн ийм мэдээлэл бидэнд одоохондоо байхгүй байна гэж хэлье.

Н.Наранбаатар: Тодруулъя. Х.Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Хэрвээ холбогдох хуульд нь өөрчлөлт оруулбал Төсвийн тогтвортой байдлын зөвлөл мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдаа нэгэн

зэрэг өргөн баригдаад Улсын Их Хурлаар хоёр Байнгын хороогоор хэлэлцэгдэж байхад уялдаа холбоог хангах чиглэлээр Та бүхэн зөвлөмж өгч бидэнд ажиллаж чадах уу?

Хоёр Байнгын хороогоор зэрэг хэлэлцэгдэхээр бид анхаарал сулраад, төсөв дээрээ анхаараад яваад байх шиг байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Сангийн яамнаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд сая жишээлбэл хэдхэн хоногийн өмнө болсон Олон Улсын Валютын Сангийн хуралд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Та бүхэн очиж оролцсон уу? Ер нь явдаг уу? Ийм хурал зөвлөгөөнд гэдэг нэг ийм асуултыг асууя.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хувьд манай зөвлөлийн гишүүд болон ажлын алба бүрдсэн. Тэрийг бүрдүүлж өгсөнд Х.Булгантуяа гишүүнд талархлаа илэрхийлье.

Цаашдаа бидний хувьд мөнгөний бодлого дээр дүгнэлт хийх эсэх асуудал, хөндлөнгийн дүгнэлт хийх асуудал нь орон зайн хувьд нээлттэй байж болох байх.

Түүнээс улс орнуудын жишгийг харахад мөнгөний бодлого, төсвийн бодлого дээр нэг институц удирдлага байхгүй байх хандлагатай байдаг. Дүгнэлтийн хувьд байж болохыг үгүйсгэхгүй байна. Одоогоор.

Чадавхын хувьд бид өнөөдөр зөвлөлийн 7 гишүүн ерөнхийдөө 2 жилийн турш бүх чиг үүргээ хэрэгжүүлж ирсэн. Энэ намраас л ажлын албатай болсон.

Одоо бид судалгааны нэгжээ бүрдүүлж чадаагүй байгаа. Судалгааны нэгжээ бүрдүүлэх асуудал эхлэлийн түвшинд явж байна. Судалгааны нэгж дээрээ бид үнэхээр чадвартай тийм бүтэц, бүрэлдэхүүн бий болгоод, чадвартай судлаачдыг бий болгох. Дээрээс нь... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулъя. 2 номерын микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Дээр дээрээс нь техникийн хүчин чадлаа сайжруулж чадах юм бол мөнгөний бодлого болон төсвийн бодлого дээр хоёулан дээр нь дүгнэлт өгч болох байх.

Уялдаа холбооны хувьд яаж уялдах вэ гэдэг дээр онолын хувьд маргаантай асуудал байдаг учраас тухайн үед бид зөвлөлөөрөө ярилцаад шийдэх байх.

Хоёр дахь асуудал дээр бид сая Валютын сангийн хуралд яваагүй. Бид өмнө нь явж байгаагүй. Бид өнөөдөр байгууллагынхаа хувьд Улсын Их Хурлын хараанд харьяат байгаа учраас төсөв, мөнгө бүх зүйл, түрүүний ярьсан хүнээ томилох асуудал хүртэл Тамгын газар дээр хүлээгдээд байж байгаа.

Бид төсвийн ерөнхийлөн захирагч биш, төсвийн шууд захирагч биш учраас энэ асуудлуудыг бие даан шийдэх боломжгүй.

Боломжийнхоо хүрээнд бид сая түрүү жил Бүгд Найрамдах Солонгос Улсын төсвийн алба буюу NABO (National Assembly of South Korea)-той хамтын ажиллагааны санамж бичиг зураад өөрсдийнхөө боломжийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ажлыг хийж байна.

Цаашдаа энэ хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг улам илүү... /минут дуусав/

Н.Наранбаатар: Х.Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Төсвийн байнгын хорооны гишүүд ээ, яг нөхцөл байдал ийм байгаа юм.

Олон Улсын Валютын Сангийн жилийн уулзалт тухайн жилийн эдийн засгийн талаар маш том хэмжээний илтгэлүүд тавигддаг, салбар хуралдаанууд болдог ийм том хурал болдог.

Гэтэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд гол параметруудийг гаргадаг. Түүнд дүн шинжилгээ өгдөг хүмүүс явж чаддаггүй. Төсөв, мөнгө нь ч шийдэгддэггүй, Сангийн яамнаас ч дэмждэггүй.

Сая жилийн уулзалт нь гэж байхад Төсвийн байнгын хороонд ч байдаггүй гишүүд зөндөө явсан байна лээ. Төсвийн байнгын хорооны дарга аа.

Тэгээд одоо эцэс сүүлд нь Төсвийн байнгын хорооных нь гишүүд нь ч биш, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд нь ч явж чадахгүй. Ийм хурал зөвлөгөөнд оролцож дэлхий даяар төсөв, эдийн засгийн бодлогоор энэ хүнд цаг үед юу ярьж байгаа вэ гэдгийг нь олж сонсож чадахгүйгээр Улсын Их Хуралд зөвлөмж өгнө гэдэг хэцүү шүү.

Тэгэхээр Төсвийн байнгын хорооны даргыг энэ дээр анхаарч өгөхийг хүсэж байна.

Н.Наранбаатар: Тодруулаад хариулъя. 5 номерын микрофон. Ажлын хэсгийн.

Л.Гангэрэл: Х.Булгантуяа гишүүний асуулт дээр нэмээд нэг тодруулга өгье.

Мөнгөний бодлого, төсвийн бодлого хоёрын уялдаа холбоо гэдэгт.

Олон улсад ер нь санхүүгийн секторын уялдаа холбоог хангасан институцүүд байгаа. Манай Монголд байгаа. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэсэн байгууллага байгаа. 4 гишүүдээс бүрдсэн.

- ▶ Сангийн яам,
- ▶ Төв банк,
- ▶ Санхүүгийн зохицуулах хороо,
- ▶ Хадгаламжийн даатгалын корпорац –

-гэсэн байгууллагуудын удирдлага орсон ийм зөвлөл байдаг.

Угтаа яах вэ гэхээр олон улсын жишгээ дагаад энэ зөвлөл дээр уг нь төсөв болон мөнгөний бодлогын уялдаа холбоог уг нь ярих ёстой байгаа юм. Ярьж байгаа гэж бодож байна.

Тэгэхдээ албан ёсоор энэ зөвлөлөөс дүгнэлт гаргах ёстой.

Тэгээд олон нийтэд төсөв болон мөнгөний бодлогын уялдаа холбоо ямар байгаа юм бэ гэдэг талаар хэвлэлийн бага хурал хийдэг ч юм уу, эсвэл мэдэгдэл хийдэг ч юм уу, ямар ч байсан тодорхой хэмжээнд... /минут дуусав/

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Төсвийн тогтвортой байдлын ажил миний бодлоор маш сайн явагддаг. Яг мэргэжлийн хар бараат бус байж чаддаг.

Одоо энэ 2024 оны зунаас эхэлсэн Улсын Их Хуралд сууснаасаа хойш харж байхад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Н.Энхбаяр даргатай ажиллаж байсан. Сүүлд Ж.Дэлгэрсайхан даргатай ажиллаж байгаа. Маш сайн ажиллаж байгаа.

- Одоо энэ төсөв чинь хяналт сул байна.
 - Тайлагнал, ил тод нь байхгүй байна.
 - Засгийн газраас тогтмол оролдлогоор урсгал зардлаа нэмж байна.
 - Эрэмбэ дараагүйгээр хөрөнгө оруулалтынхаа зардлуудыг шийдэж байна.
 - Мөчлөг сөрсөн бодлогын зарчим нь хэрэгжиж чадахгүй байна.
 - Яам, Тамгын газруудын уялдаа холбоо нь муу байна.
-

Тэгээд бид хөнжлийнхөө хэрээр хөлөө жийж чадахгүй буюу байгаа төсвийнхөө хүрээнд ажил, үйлчилгээгээ зөв төлөвлөж чадахгүй байна гээд бүх асуудлуудыг Төсвийн байнгын хороо, чуулганд өгдөг.

Тэгээд Та бүхэнд маш их баярлаж байгаа гэдгээ хэлье.

Тэгэхдээ ер нь Та хэд нэг их ажилгүйдээ тэнд тогтмол нэг ийм 7, 8 хуудастай дүгнэлт хийж суудаггүй байх. Энэ улс орныхоо төлөө л хийж байгаа ажлууд гэж би харж байгаа.

Одоо харин хэдүүлээ яаж шүдтэй арслан болох вэ гэдэг юмыг л яримаар байгаа юм. Ямар ч шүдгүй. Бүх асуудлуудыг ил тод гаргаж ирээд тавьдаг. Улсын Их Хурал ч тэр, Төсвийн байнгын хороо ч тэр ямар ч мэдээллийг нийгэмд ил тодоор нь хэлж чаддаггүй.

Уг нь Улсын Их Хурлын гишүүд чинь Үндсэн хуулиар олгосон боломж нь гэж эрдээд гэдэг юм уу, бүгдээрээ давхар дээл өмсөөд Засгийн газарт ороод суусан. Үг хэлж чаддаггүй.

Хамгийн сонгодог жишээ. Т.Аубакир сайд жишээлэхэд Төсвийн байнгын хорооны гишүүн. Төсөв хамгийн их үрж байгаа Засгийн газрын гишүүн.

Гэтэл одоо энэ Төсвийн байнгын хороон дээр яг энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн Засгийн газар чинь ийм ажлуудаа хийж чадахгүй байна, уялдаа холбоо алга гээд байхад Т.Аубакир сайд энд хурал дээрээ ч сууж чадахгүй байна.

Төсвийн байнгын хороон дээрээ ч гэсэн бид ёс зүйгээ яриад, ёс зүйтэй жоохон хариуцлагатай ажиллах талаас нь анхаарч ажилламаар байгаа юм. Төсвийн байнгын хорооны дарга аа.

Энэ дээр Та байр сууриа илэрхийлээч. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн ч гэсэн хэдүүлээ яавал шүдтэй арслан болох вэ гэдэг дээрээ нэг байр суурь илэрхийлээд нэг яримаар байгаа юм.

Ер нь сая Г.Тэмүүлэн гишүүн ч ярилаа, Н.Алтанхуяг гишүүн ч ярилаа, Б.Мөнхсоёл гишүүн ч ярилаа.

Төсвөөс гадуур дахиад төсөвтэй болох гээд хоёр, гурван чухал төслийн нэр барьж байгаад гадаадын зээл ашиглалтыг сайжруулмаар байна гээд байгаа юм.

Миний бодлоор Монгол Улсын хөгжлийн банк Засгийн газрын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа.

Хөгжлийн банкны хууль дээр нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийгээд, хувийн хэвшилд зээл олгох юм бол бүгдээрээ шоронд ордог. Тэгвэл Засгийн

газартаа зээл олгох эрхийг нь нэмэгдүүлээд буюу тэр газрын тосны үйлдвэрийн төслийн зээл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмэлт 1 минут.

Да.Цогтбаатар: Эдгээр төслүүдийг явал Хөгжлийн банкаар явуулдаг болох талаас нь Та хэдийн зүгээс ямархуу санал бодолтой байна гээд. Бараг тус бүрдээ санал хэлэх юм бол илүү сайн ч санал гарах байх. Нэгдсэн байдлаар гаргасан ч сайн санал гарах байх. Бүгдийг нь би маш их хүндэтгэж байгаа учраас Та бүхэн бүгдээрээ өөрс өөрсдийнхөө саналыг хэлээч гэж бодож байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

А.Энхбат: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын асуудлыг хөндөж ярьж байна.

Үнэхээр манайх Төсвийн тухай хууль органик хууль. 2011 онд анх батлагдаад, 2013 оноос эхэлж хэрэгжиж эхэлсэн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсан. Үндсэндээ 2024 оноос эхлээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл орон тооны болж үйл ажиллагаа нь нэлээн цэгцэрч жигдэрч явж байна.

Тэгэхээр бусад улс орнуудад төсвийн тогтвортой байдал, өөрөөр хэлбэл өнөөдөр 70-аад улс оронд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, түүнтэй ижил төрлийн ийм институцүүд байдаг.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эрхийг нэмэгдүүлэх гэдэг асуудал үнэхээр чухал асуудал.

Зарим улс орнуудад жишээлбэл Англид гэдэг ч юм уу, Лордын танхим дээр тухайн жилийн төсвийн төсөл нь орж ирэхэд төсвийнх нь тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр үндэслээд шууд Засгийн газар луу буцаадаг. Хэлэлцүүлгийн ямар ч шатад буцаадаг ийм эрх зүйн зохицуулалтууд байдаг.

Тэгэхээр өнгөрсөн 2026 оны төсвийг хэлэлцэж байх үед Улсын Их Хурал дээр гуравдугаар хэлэлцүүлгээс хоёрдугаар хэлэлцүүлэг рүү буцааж байсан энэ эрх зүйн зохицуулалт орж ирснээр тодорхой ийм эрх гарч ирж байгаа. Иймэрхүү асуудлууд үнэхээр байгаа.

Гадаад зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх тухай Н.Алтаншагай гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бид түрүүн хэлсэнчлэн эсрэг байр суурьтай

байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн тогтвортой байдал, төсвийн эрх зүйн харилцаанд ноцтой сөрөг үр дагавруудыг дагуулна.

Ер нь бидний барьж байгаа нэг зүйл бол Олон Улсын Валютын Сангийн гадаад өрийн статистикийн **guideline** гэж байдаг. Энэ guideline дээр ер нь Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрээр авч ашиглаж байгаа зээлүүд Засгийн газрын улсын төсвийн заавал бүртгэгчээр байх ёстой.

Энэ дээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөхгүй, хамаарахгүй гэж заасан нь эргээд энэ эрх зүйн өнөөдрийн тогтолцоогоо эвдэх ийм сөрөг үр дагавруудыг бий болгож байна.

Хоёрдугаарт нь, хоёр төсөвтэй болох үүд хаалгыг нээж байна.

Ингэсний үр дагавар нь эргээд макро эдийн засаг болон төсвийн алдагдал үүсэх, төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэл маш их хэмжээний алдагдалтай болох үүд хаалга бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна гэж харж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: 4 номерын микрофон.

Л.Отгонтуяа: Да.Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Тэгэхдээ бидний хувьд үнэхээр дүгнэлт, зөвлөмжөө өгөөд, түүнийг хэрэгжүүлэх тал дээр ч гэж сүүлийн 2 жилийн хугацаанд алхмууд гарч байгаа гэж ойлгож байгаа.

Улсын Их Хурлын гишүүд манай зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж асуултаа асуудаг, саналаа хэлдэг. Тийм ээ. Ийм болж байгаа нь бидний энэ ажлын нэг үр дүн гэж ойлгож байгаа.

Тэгэхдээ манай өгсөн дүгнэлт, зөвлөмжийг илүү хэрэгжилтийг нь хангах талаасаа өнгөрсөн жил ч гэсэн бид хуулийн төсөлд саналаа өгч явж байсан.

Ялангуяа төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийг Төсвийн байнгын хороо тусгайлан хэлэлцдэг байх. Болдог бүр Их Хурлаар тусгайлан зөвлөлийн дүгнэлтээ хэлэлцэх хэлбэртэй, эсвэл тусгайлсан танилцуулах тийм илтгэл танилцуулдаг байх явдал их чухал.

Нөгөө талдаа хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд Засгийн газар зөвлөлөөс өгсөн дүгнэлт, саналыг хүлээж авсан бол хүлээж авснаа, аваагүй тайлбараа өгдөг... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд 1 минутад гүйцээгээд хариулчих.

Л.Отгонтуяа: Ийм заалт бий. Түүнийг илүү хэрэгжилтийг нь хангах тал дээр аль аль талаасаа манай зөвлөлийн зүгээс ч, мөн Улсын Их Хурлын зүгээс ч гэсэн анхаарч ажиллах хэрэгтэй байх.

Энэ дээр саналаа солилцож ажиллахад бид бэлэн байгаа.

Саяын хэлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр юм уу, том төслүүдээ хэрхэн явуулах вэ гэдэг дээр миний хувьд, хувь судлаачийнхаа хувьд Хөгжлийн банкныг маш зөв ажиллуулах шаардлага энэ дээр бий. Ялангуяа өөрөө өөрсдийгөө санхүүжүүлээд явах, буцаагаад тодорхой хугацаанд хүүгүйгээр, зээлээ авсан ч бага хүүтэйгээр түүнийгээ буцааж үйл ажиллагаа нь жигдэртэл эргэж төлөх, тэгээд цаашдаа төсөвтөө орлогоо төвлөрүүлдэг байх Японы цонхны зохицуулалтын онол (window guidance) маягийн ийм зохицуулалтыг хийхээс өөр арга вэ гэж үздэг. Баярлалаа.

Н.Наранбаатар: 5 номерын микрофон хариулна.

Л.Гангэрэл: Манайхан дүгнэлтүүд, өөрсдийн санал бодлоо хэллээ. Нэмээд хоёр санал. Өөрийн бодож байгааг.

Хэрвээ энэ хууль батлагдах юм бол нэг ийм президент тогтох гээд байгаа.

Цаашид яах вэ гэхээр сонгууль дөхөж байна.

Тэгэхээр дахиад өөр ийм төслүүд нэмж орж ирэх магадлал үүснэ. Одоо ингээд 2 төсөл ороод, 3 төсөл батлагдсан. Одоо дахиад нэг ийм повт гаргаж ирээд энэ ч улс эх оронд хэрэгтэй, тэгж байгаа. Үүнийхээ замаар дахиад нэг удаагийн шинжтэй. Энэ 3 зээл дээрээ нэмээд энэ төслүүдийг оруулаад ирье гэдэг ийм цонхыг нээж өгөх ийм аюултай байдал үүснэ.

Энэ нь цаашаагаа ямар үр дагаварт үүсэх вэ гэхээр өр. Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа алдагдах. Нөгөө 60 хувиасаа. Тооцоо нь бүртгэгдэхгүй явахаар чинь 60 хувиасаа илүү гарах, гадаад өрийн дарамт улам нэмэгдэх ийм аюул тулгарч байгаа.

Үүнийг Та бүхэн нэг анхааралдаа авна биз.

Н.Наранбаатар: Өөр нэмж хариулах хүн байна уу? Түрүүн хүн тус бүрээс гэсэн. Тийм ээ. Тодруулах уу? Шаардлагагүй гэж байна.

Да.Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Сая хэлэлцэх асуудалтай холбогдуулаад Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн нэрс өөрчлөлт оруулъя гэдэг байдлаар орж ирж байгаа.

Энэ дээр би санал гаргаж оруулж байгаа юм. Төсвийн байнгын хорооны дарга анхааралдаа аваад ажиллаад өгөөч ээ.

Төсөв үрдэг сайд нарыг Төсвийн байнгын хорооноос хасмаар байгаа юм. Т.Аубакир сайд чинь жишээлэхэд 4.7 их наяд төгрөг үрж байгаа. Халамж тарааж байгаа хүн байхгүй юу. Халамжаа нэмж авъя л гэнэ үү гэхээс тэр хүн явал хөдөлмөр, бизнес эрхлээд халамж авдаг хэсэг багасдаг юм гэдэг дээр ерөөсөө толгой ажиллуулахгүй. Мөнгө нэмж авч үрье, халамж тараадаг, сонгуульдаа бэлддэг сайд байя л гэдэг нэг л зорилго тэр хүн дээр байгаа.

Тэгэхээр 126 гишүүнээс 20 сайдыгаа хасаад, 106 гишүүнээс Төсвийн байнгын хорооныхныг бүрдүүлээч гэдэг ийм зарчмын санал Төсвийн байнгын хорооны дарга, Монгол Ардын намын дарга, Улсын Их Хурлын даргад хүргүүлж байгаа юм.

Иймэрхүү асуудлуудаа яриад очъё гэхээр манай Их Хурлын дарга тэгээд хүлээж авахгүй зовлонтой юм.

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүний асуулт дээр би нэмээд хариулахад Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хуулийн төсөл боловсруулж байгаа юм.

- Их Хурлын тухай хууль,
- Хяналт шалгалтын тухай хууль,
- Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн төсөл боловсруулж ерөнхийдөө дуусаж байгаа.

Тэгээд манай Байнгын хорооноос Тогтвортой байдлын зөвлөл рүү бичиг явуулаад саналуудыг нь аваад уламжилсан байгаа.

Манай Төсвийн байнгын хорооны гишүүд саналаа нэгтгээд ажлын албанаас уламжилсан байгаа.

Одоо М.Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох.

Тэгээд эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж байгаа юм.

Тэгээд энэ хуулийн зорилгыг харахад нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахаас гадна экспортын 96 хувийг эзэлж байгаа уул уурхай буюу газрын хэвлийн баялгаас орж байгаа орлогоор нөхөн сэргээгддэг баялаг буюу –

- хүний хөгжил,
- хөдөө аж ахуйн салбарын хөгжил,
- жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих,
- баялаг бүтээж байгаа хүн, бизнесменүүдийг дэмжих,
- эдийн засгийн хөгжлийг дэмжих –

-гэдэг ийм хөгжилд чиглэсэн гол үүрэг байгаа гэдгийг маш сайн ухамсарлаж ойлгох хэрэгтэй гэж. Үүнийг Та бүхэн юу гэж боддог юм бэ гэдгийг би асуумаар байна. Нэг.

Хоёрдугаарт нь, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэхээр би хууль дээр эрх үүргийг нь уншсан л даа. Хараат бус, бие даасан, 7 гишүүнтэй гээд.

Тэгээд Та бүхэнд би юу гэж хоёр дахь асуулт асуух гээд байна гэхээр яг энэ нөхөн сэргээгддэггүй уул уурхайгаас орж байгаа энэ өндөр орлогоор бусад салбарыг дэмжихэд чиглэсэн ямар бодлогын зөвлөмж танай зөвлөл өгдөг вэ?

Өөрөөр хэлбэл эцэг, өвгөдөөс үлдээсэн хэвлий доорх “төрийн нийтийн өмч” гэж Үндсэн хуульд заасан байгаа энэ баялгийн орлогыг зөв хуваарилах чиглэл рүү нь ер нь ямар бодлого, зөвлөмж гаргаж өгч байгаа вэ?

Энэ талаар хоёрдугаарт нь хариулт авъя.

Дараагийнх нь, орон нутгийн хөгжлийн сан гээд байна. Орон нутгийн хөгжлийн санг улсын төсөвт тодотгохоороо дураараа шууд бууруулаад хаядаг. Тэгээд олон компани гэрээ байгуулсан гүйцэтгэгч байдаг. Тэд нар маш их хохирдог.

Тэгээд үүнийг хэрвээ тодотгол хийхээр бол доод шатдаа шууд ингэж тийм харгис хатуу ханддаг. Энэ дээр ер нь манай тогтвортой байдлын зөвлөл ямар санал, зөвлөмж өгч явдаг вэ? Үүнийг ер нь болно гэж бодож байгаа юу?

Гуравдугаарт нь, олон нийтийн хэлэлцүүлгийг ер нь хэр олон удаа, хэдэн удаа хийсэн байдаг вэ?

Эндээс ер нь ямар саналууд голчлон төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж байгаа, гүйцэтгэл хийж байгаа, тендер гэж ярьдаг гүйцэтгэл хийж байгаа аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гомдол маргаан их гардаг уу?

Ер нь тэд хэлж чадахгүй байгаа болохоос биш энэ аймаар том асуудал байгаа шүү дээ.

Тэгээд л өндөр хүүтэй зээл авдаг. Банк бус, хувь хүнээс авдаг. Ажлаа дуусгахын тулд. Энэ зовлон бэрхшээл ер нь хэр мэддэг вэ? Энэ тал дээр ямар санал ирүүлж байгаа вэ?

Н.Наранбаатар: 2 номерын микрофоныг өгье.

Ж.Дэлгэрсайхан: Гишүүний асуултад хариулъя. Баярлалаа.

Тэгэхээр Эдийн засгийн төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа зорилтыг бид хангаж ажиллахыг хичээж байгаа.

Тэгээд бид төсвийн тогтвортой байдал гэдгийг энд яригдаад байгаа төсвийн тусгай шаардлагуудаас гадна төсвийн бодлогын тогтвортой байдал, хууль эрх зүйн орчны тогтвортой байдал, макро эдийн засгийн нөхцөл байдалтайгаа нийцсэн байдал болон ирээдүйд Монгол Улсын төсвөөс шалтгаалсан эдийн засгийн эрсдэл үүсгэхгүй байдал гэсэн ийм гурав, дөрвөн чиглэлд бид бодлогын чиглэлээ барьж ажилладаг. Үүнийг танд тодруулж хэлье.

Тийм учраас хуулийн зорилт дээр байгаа уул уурхайгаас орж ирж байгаа нөхөн сэргээгдэшгүй баялгийн орлогыг эдийн засагт зөв хуваарилна гэдгийг бид бодлогын чиглэлийнхээ дагуу –

- Монгол Улсын төсвийн бодлого нь зөв байх ёстой,
- зардал нь үр ашигтай байх ёстой,
- төрийн оролцоо харьцангуй буурсан байх ёстой –

-гэдэг чиг баримжаан дээр явж байгаа.

Тэгэхээр уул уурхайгаас орж ирж байгаа төсвийн орлогуудыг бид зөв зарцуулах нь энэхүү баялгийг боловсролдоо, эрүүл мэнддээ, зөв хөрөнгө оруулалтдаа зарцуулах явдал нь сэргээгдэхгүй, нөхөн сэргээгдэхгүй баялгийг ирээдүйн баялаг болгон хувиргах нэг арга хэрэгсэл гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь, баялгийн сантай холбоотой асуудал нь ерөөсөө тэр нөхөн сэргээгдэхгүй баялгийг нөхөн сэргээгдэх, ирээдүйд тасралтгүй орлого бий болгох баялаг руу чиглүүлэх нэг гол механизм гэж үзэж байгаа. Үүнтэй холбоотой бид Баялгийн сангийн тухай хууль дээр өөрсдийн дүгнэлтээ өгсөн.

Бидний зүгээс үзэж байгаагаар Баялгийн сангийн тухай хууль бол ерөөсөө эхлэл юм байна.

Баялгийн сан дээр –

- засаглал,
 - үр ашигт байдал,
 - менежмент,
-

— хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог нь —

-бүрэн хийж өгөөгүй бөгөөд төрийн захиргааны төв байгууллагууд баялгийн санг шууд удирдаж байгаа байдал нь баялгийн сангийн бие даасан хараат бус байдлыг алдагдуулж байна гэх маягийн дүгнэлтүүдийг өгсөн.

Тэгэхээр бидний тэр сэргээгдэшгүй баялгийг хоёр чиглэлд.

- ▷ **Нэгдүгээрт**, байгаа төсөвт зарцуулж байгаа төсвөө зөв зарцуулах.
- ▷ **Хоёрдугаарт**, хуримтлагдаж байгаа баялгийн сангаа зөв зарцуулах –

-гэдэг хоёр чиглэлээр бид үүнийг харж байгаа юм гэж хэлэхээр байна.

Гуравдугаар асуултын хувьд Орон нутгийн хөгжлийн санд хуваарилж байгаа мөнгийг бид мэдэж байгаа.

Тэгээд төсвийн тодотголын хувьд төсвийн тодотгол өөрөө тусдаа хууль эрх зүйн орчинтой. Төсвийн тодотголыг хийж байгаа, яг хэрэгжүүлж байгаа институт нь өөрөө тэр эрх зүйн орчныхоо хүрээнд Засгийн газар байгаа.

Тийм учраас Засгийн газар тухайн үедээ бодлогын түвшинд улсын төсөв дээрээ илүү анхаарал хандуулаад, орон нутгийн төсөв төсөв дээрээ жоохон хатуу хандсан ийм тохиолдлууд байхыг үгүйсгэхгүй.

Ер нь бидний хувьд төсвийн бодлого нь нэгдмэл байх ёстой гэдэг ерөнхий дүгнэлтийг өгч байгаа.

- Бүсчилсэн хөгжил.
- Орон нутгийн хөгжил.

Эд нарыг харгалзаж үзэх нь зүйтэй. Гэхдээ бодлого нь нэгдмэл, дээрээсээ доошоо чиглэсэн top down чиглэлийн бодлого хэрэгжих ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: М.Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Би төсөвт тогтвортой байхад Тогтвортой байдлын зөвлөл маш сайн зөвлөмжөө өгдөг.

Энэ дээр ард түмний эрх ашгийн төлөө хараат бусаар дуу хоолойгоо илэрхийлдэг байх ёстой. Даргын нөлөөнд ордоггүй байх ёстой гэж боддог.

Би бас орон нутгийн төсвийн 9 жил захиран зарцуулсан хүн. Тэгээд энд ирээд ингээд харахаар ялгааг нь их мэдэрч байгаа.

Тэгээд муу муудаа дээрэлхүү, муна гадсандаа дээрэлхүү гэдэг шиг Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг дураараа хасаж байгаа шүү дээ.

Үгүйсгэхгүй гэж Та хариулж болохгүй. Ийм байгаа. Ер нь Та бүхэн ийм чухал Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн холбогдох албан тушаалтнууд ийм нэг арьсаа хамгаалсан, амиа хоохойлсон байдлаар битгий хариулж байгаарай цаашдаа гэдгийг би хэлмээр байна.

Тэгээд өнгөрөөх байдлаар. Нэг нь асуудаг. Нөгөөдөх нь нэг хариулдаг. Хариулсан болдог. Тэгээд өнгөрөөдөг. Эндээс гараад мартдаг тийм байж болохгүй шүү дээ. Бид ард түмний дуу хоолой.

Тийм учраас наад учраад байгаа бэрхшээлийг чинь би сайн мэдэж байгаа учраас та нарыг хүчтэй дуу хоолойгоо гаргаж өгөөсэй гэж би хүсэж байна. Тайлан сонсож байгаа учраас.

Н.Наранбаатар: Д.Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Юун түрүүнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл сайн ажилладаг гэж хэлмээр байна. Дэмжмээр байна. Үндсэн зорилго бол төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, макро эдийн засгийн дүн шинжилгээ хийдэг гэж харж байгаа.

Тэгээд үндсэн гурван асуулт байна.

→ **Нэгдүгээрт нь**, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл үндсэн ямар үүрэгтэй вэ гэдгийг Та бүхэн өөрсдөө мэдэж байгаа.

Тэгээд төсвийн тодотгол хийх тоолонд, төсөв өргөн баригдах тоолонд хүрээнийхээ мэдэгдлийг өөрчлөөд байдаг. Түүнд Та бүхэн зарим тохиолдолд дэмжээд яваад байдаг ийм тохиолдол гарсан.

Бодит жишээ. Өнгөрсөн 2026 оны төсвийг батлах 2025 оны 11 сард болсон хурлуудад Засгийн газраас өргөн барьсан төсөв 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн. Хөрөнгө оруулалтыг.

Энгийн жишээгээр хэлэх юм бол өнөөдөр төсвийн хэмнэлтийн тухай хуулиараа 5 дугаар сарын 31-ний дотор тендерээ зарлаж чадахгүй 1.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтаас хэдэн хувь нь өнөөдөр татагдах вэ? Энэ дээр Та нарын оролцоо байгаа шүү дээ.

Үүнийгээ нэг тайлбарлаад хэлээдхээрэй. Би давхар тодруулна.

→ **Хоёрдугаарт нь**, макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд Төв

банкны хуримтлагдсан алдагдал 7 их наяд төгрөг байна.

Энэ маш сөрөг үзүүлэлт. Энэ сөрөг үзүүлэлт эргээд татвар төлөгчдийн нуруун дээр, эргээд Засгийн газрын нуруун дээр ирэх асуудал. Энэ дээр Та бүхэн дүн шинжилгээ хийсэн үү?

→ **Гуравдугаарт нь**, энэ орлого буурахаар зарлагаа уялдуулдаг асуудал дээрээ яагаад Та бүхэн олон нийтэд таниулах ажлыг хийдэггүй юм бэ?

Хэт их өөдрөгөөр төсөөллөө гээд л. Тэгээд л эдийн засгийг чинь 8 хувьтай, тэдэн хувьтай гээд л байдаг. Одоо тэгэнгүүт эдийн засаг нь улам л хумигдаад байна. Орлого тал нь буурлаа гээд л тэгнэ. Зарлага талаа бууруулдаггүй. Аймаг болгон, дүүрэг болгон хэдэн тэрбум тэрбумаар зам тавьдаг. Тэрбум тэрбумаар урсгал зардлаа нэмэгдүүлдэг.

Гэтэл станцаа бид барьж чадахгүй шүү дээ.

Н.Наранбаатар: Хэдэн номер хариулах вэ? 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Д.Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Баярлалаа.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр Та бидний дүгнэлтийг нэлээд анхааралтай хардаг гишүүдийн нэг.

Бид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байх ёстой гэдэг дээр хатуу зогсдог.

Дэмжсэн гэж хэлэх үү, дэмжихэд хүрсэн гэж хэлэх үү нэг л тохиолдол байгаа. Түүрүү жилийн 7 сард Засгийн газраас оруулж ирсэн хуулийн санал байсан. Засгийн газрын хэлж байгаа шалтгаанаар хоёрхон тохиолдолд намар Улсын Их Хуралд төсвийг өргөн барих нөхцөл бүрдэхгүй гэсэн ийм үндэслэлээр тэр хуулиа оруулж ирсэн байдаг.

Тэгэхээр энэ хууль дээр бидний саналыг авсан. Бид дүгнэлт, зөвлөмж, байр сууриа бид гаргаж өгсөн. Түүнд хоёр зүйлийг л бид дурдсан.

► **Нэгдүгээрт нь**, Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх энэ өөрчлөлт нь нэг удаагийн шинж чанартай байх ёстой гэдэг дээр бид зогсохгүй бол та нар дөнгөж үйлчилж эхэлж байгаа хуулийн заалтыг алдагдуулж эхлэх гэж байна гэдэг ийм дүгнэлтийг өгсөн.

► **Хоёрдугаарт нь**, төсвийн зарлага ерөөсөө өсөхгүй байх ёстой гэсэн өмнөх Засгийн газрын хийж чадсан нэг сайн зүйлийг бид тэгж үзсэн учраас төсвийн зарлагын дотоодын ний бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувь хэмжээг бууруулах нөлөөг хийж, 38 орчим байсан төсвийн зарлагыг өнөөдөр 32 луу аваачаад, цаашаа 30 руу аваачна гэдэг энэ бодлогыг

хэрэгжүүлэх нөхцөлтэй байсан учраас бид тэрийг нэг л удаа дэмжсэн гэж хэлэхэд хэцүү. Хүлээн зөвшөөрсөн, хүчинд автсан байдалтай байсан гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Хоёрдугаарт нь, 3 сарын 13-нд бид өөрсдийнхөө макро эдийн засгийн таамаглалаа гаргасан. Гэхдээ Монголбанкны алдагдлыг тусгайлан макро эдийн засгийн тооцоололдоо бидний бүрэн эрхэд хамаарах асуудал биш учраас тооцоололдоо, яг түүнд тусгайлсан дүгнэлт, тооцооллыг хараахан хийгээгүй байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Н.Наранбаатар: 6 номерын микрофон нэмж хариулна.

Н.Энхбаяр: Д.Пүрэвдаваа гишүүний асуусан төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдолтой асуулт дээр нэг зүйл хэлье гэж бодож байна.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд дунд хугацааны төсвийн хүрээгээ Засгийн газар ирэх оны төсөв боловсруулах үедээ хамт өөрчилсөн байдлаар өргөн барьж байгаа.

Тэгэхээр гол нь энэ төсвийн тухай хуулийн 27.1.4-д заасан дараа жилийн төсвийн төсөл нь төсвийн жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх ёстой гэсэн төсвийн тухай хуулийн заалт байгаа.

Гэтэл энэ хуулийг зөрчөөд шинээр боловсруулсан төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй хамт боловсруулаад өргөн барьж байхад энэ хуулийг хууль тогтоомжид нийцсэн байна гэж аваад хэлэлцээд байгаа нь л алдаа байгаа юм.

Тэгэхээр хуулийг өргөн барих явцдаа Улсын Их Хурал цаашдаа энэ асуудал дээрээ илүү анхаарал хандуулах шаардлагатай болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт, аливаа Улсын Их Хуралд өргөн барьж байгаа хууль Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулагдах ёстой.

14.2.3 хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал гэж байгаа юм. Энэ арга хэмжээний санал байна уу гэдгийг хууль болгон дээр харах ёстой.

Гэтэл энэ нь байхгүй.

Н.Наранбаатар: Нэмээд дуусгачих.

Н.Энхбаяр: Олон жишээн дээр олон салбар дээр хэлэлцэгдэж байгаа хуулиуд дээр цаашид гарч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

тооцогдоогүйгээс хамаараад төсвийн хязгаараас давсан хамаагүй их зардал бий болж байгаа.

Саяхан бид Шүүхийн ерөнхий зөвлөлтэй ч гэсэн энэ асуудлыг ярихад яг л ийм асуудал гарч байгаа.

Өмнө нь батлагдсан маш олон хуулийн өөрчлөлт гардаг. Тэрийгээ дагаад зайлшгүй төсөв дээр зардал нэмэгдэх болдог.

Гэтэл тэр нь аль ч, ямар ч төсвийн хуультай уялдаагүй ийм асуудал салбар болгон дээр байгаа.

Тэгэхээр ийм байдлаар төсвийгөө дунд хугацаандаа төсөөлөхгүй зардал нэмж батлаад байгаа учраас “төсвийн хүрээний мэдэгдэл” гэдэг зүйл чинь өөрөө ямар ч утгагүй болж хувирч байна.

Тэгэхээр өргөн барьж байгаа хууль дээрээ зүгээр бүрдүүлбэр гэдэг хуудасны тоо хянах биш, доторх агуулга нь хууль тогтоомжийн хуулийн дагуу өргөн баригдаж уу гэдэг дээрээ маш сайн хянаж байж хуулийг хэлэлцэх ёстой л гэж үзэж байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Эхлээд 2 номер. Нэмээд хариулъя. 2 Номер.

Ж.Дэлгэрсайхан: Д.Пүрэвдаваа гишүүний гурав дахь асуулт дээр.

— **Нэгдүгээрт**, бид хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу олон нийтийн хэлэлцүүлэг хийдэг.

— **Хоёрдугаарт**, өөрсдийн гаргасан дүгнэлтийн дагуу хэвлэлийн бага хурал хийж, нийт хэвлэл, мэдээлэл, олон нийтэд танилцуулдаг.

— **Гуравдугаарт**, парламентын сайтаар дамжуулж бид өөрсдийнхөө дүгнэлтүүдийг олон нийтэд хүргэдэг.

Энэ хувилбаруудаар л бид өөрсдийн хийж байгаа дүгнэлт, зөвлөмжүүдийг бусдад түгээх ажлыг хэрэгжүүлж байна.

Мөн манай гишүүд мэргэжлийн зүгээс хэвлэл мэдээллээр ярилцлага өгөх, олон нийтийн хурал цуглаанд оролцох байдлаар өөрсдийн байр суурийг түгээх.

Энэ гурав, дөрвөн сувгийг албан ёсоор ашиглаж байна. Түүнээс бид Улсын Их Хурлын дэргэдэх мэргэжлийн байгууллага гэдэг утгаараа бүх зүйл дээр байнга босож ирээд хэвлэлийн бага хурал хийхгүй байх ийм л бодлогыг барьж явж байна.

Н.Наранбаатар: Д.Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Би эхэндээ ч хэлсэн. Та бүхнийхээ үйл ажиллагааг ойлгож байгаа, дэмжиж байгаа.

6 хүн үнэхээр ачаалалтай ажиллаж байгаа. Нийт энэ тоонууд, ялангуяа төсөв, орон нутгийн төсөв. Орон нутгийн төсвийн утгагүй тэлэлт, урсгал зардал. Энэ дээр сууж дүн шинжилгээ хийх 6 хүнд хэт их ачаалал.

Та бүхний бүрэлдэхүүнийг нэмэх хэрэгтэй. Дээрээс нь ажиллах боломж бололцоог нь нэмэгдүүлэх хэрэгтэй гэж бодож байгаа юм.

Гэхдээ Та бүхэн түрүүн хэллээ шүү дээ.

Дунд хугацааны, төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг бол маш чухал бичиг баримт, хязгаар. Тийм ээ. Үндсэндээ энэ хязгааруудыг бид мөрдөх ёстой байтал хүчинд автсан. Энэ бол сүүлдээ бүр утгаа алдлаа гээд. Энэ дээрээ Та бүхэн гол шалтгаан... /минут дуусав/

Н.Наранбаатар: 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Тэгэхээр түрүүн хэлсэн үгний хувьд хүчинд автлаа гэдэг бол бодит нөхцөл байдлыг харсан гэсэн утгаар хэлсэн гэдгээ дахиж тодруулъя.

Энэ дээр бидний зүгээс намар нөхцөл байдал өөрөө яалт ч үгүй тэр төсвийн хууль эрх зүйн орчин, өмнө нь өргөн барьсан байсан төсвийн хүрээний мэдэгдлийн өмнөх Засгийн газрын өргөн барьсан байсан Төсвийн хүрээний мэдэгдлийн хэт өндөр тоотой холбоотойгоор яалт ч үгүй тийм нөхцөл байдал үүссэн байсан гэдгийг дахин тодруулъя.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид бүх дүгнэлт дээрээ байнга хэлж байгаа. Үүнийг өөрчлөхийн эсрэг байна. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой тоонуудыг бид өөрчилъе.

Түрүүн Г.Тэмүүлэн гишүүний хэлсэнтэй санал байна. Суурь тэнцэл гэсэн. Макро эдийн засгийн чиг баримжааг алдагдуулсан тоонуудаа авъя.

Дээрээс нь бидний гол нэмээд байгаа санал төсвийн хүрээн дээр бид дунд хугацааны төсвийн хүрээний бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс гадна нэрлэсэн GDP-гээ бас оруулдаг байя. Тоон үзүүлэлтүүд болон агуулгын хувьд сайжруулах... /минут дуусав/

Н.Наранбаатар: Х.Ганхуяг гишүүн асуулт асууна. Х.Ганхуяг гишүүний нэрийг оруулаарай.

Х.Ганхуяг: Нэг асуулт байна.

Ер нь яах вэ одоо ингээд Засаг захиргаа, нэгжийн тухай хууль, Үндсэн хуулиар бид орон нутгийн эрх мэдлийг нэлээд нэмэгдүүлсэн.

Тэгээд Та бүхэн одоо энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл улсын төсөв дээр санал, дүгнэлт бэлдэж өгөөд байх шиг байгаа юм.

Орон нутгийн төсөв дээр ер нь анхаарал хандуулдаг эсэх асуултыг асуумаар байх юм. Яг энэ байдлаараа үргэлжлээд явахаар үндсэндээ бид чинь 22 ханилагтай болох гээд л байх шиг байгаа юм. Тэгж хэлээд байгаа шалтгаан нь юу вэ гэхээр хэрэгжүүлж байгаа төслүүд өөрсдөө эргээд улсын төсөвт нэлээн дарамт авчрахаар хэмжээний өндөр төсөвт өртөгтэй ийм төслүүд яваад байна л даа.

Тэгээд энэ дээр ер нь санал, дүгнэлт ер нь бэлдсэн юм байдаг эсэх, улсын төсөвтэй уялдуулах тал дээр ямар нэгэн байдлаар зөвлөмж өгсөн эсэх талаар асуумаар байх юм.

Тэгээд эргээд тодруулъя.

Н.Наранбаатар: Хэдэн номер. 4 номерын микрофоныг нээе.

Л.Отгонтуяа: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид төсвийн хүрээний мэдэгдэлд дүгнэлт өгөх, мөн төсвийн төсөлд дүгнэлт өгөхдөө ялангуяа ирэх жилийн төсвийн төсөл, тодотголд дүгнэлт өгөхдөө Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, орон нутгийн төсөв дээр нь бас нэгдсэн төсөв гэдэг утгаар нь товч дүгнэлтүүдийг өгч байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа Үндсэн хууль болоод Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар орон нутагт төсвийн эрх мэдлийг өгсөн.

Гэхдээ зарим тохиолдолд ялангуяа нийслэлийн зүгээс төсвийн тодотгол хийх нөхцөл бүрдсэн байхад эдгээрийг хийж байгаа юу, үгүй юу гэдэг анхаарах асуудал болсон байгаа.

Зүгээр хэрэгжүүлж буй төслүүдийн тухайд жилийн хөгжлийн төлөвлөгөөн дээр, ялангуяа мега төслүүдэд бид тусгайлсан дүгнэлт өгч байгаа.

Мөн нийслэлээс хэрэгжүүлж байгаа төслүүдийн тухайд ч гэсэн таны хэлж байгаа зүйлтэй санал нэг байна. Ялангуяа нийслэлийн мега төслүүд, дэд бүтцийн шинжтэй төслүүдийг төсвөөс санхүүжүүлэхээс өөр аргагүй гэдгийг бид бодох ёстой.

Гэхдээ төсвөөс, төрийн зүгээс санхүүжүүлэх ёстой төслүүд мөн үү, үгүй юу гэдэг дээр анхаарах шаардлага бий гэдэг талаас бид холбогдох дүгнэлтүүд

дээрээ их дэлгэрэнгүй биш гэхэд товч дүгнэлтүүдийг өгч ажиллаж байгаа гэж ойлгож болох байх. Зүгээр орон нутгийн төсөв рүү тусгайлсан дүгнэлтүүдийг детальчилсан анализ шинжилгээ хараахан бүрэн хийгдээгүй гэдгийг хэлэх байна.

Н.Наранбаатар: Х.Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд би нэг санал хэлэх гэсэн юм.

Одоо ингээд орон нутгийн төсвүүдтэй холбоотой. Бид улсын төсвийг ярих гэж байгаа бол орон нутгийн төсөвтэй нь хамт тоонуудаа үзэж хардаг байхгүй бол энэ чинь жилээс жилд алдагдал нэмэгдэх үндсэн шалтгаануудын нэг нь бас энэ орон нутгийн төсөвт байлгах болох боломжтой юм шиг харагдаад байгаа юм.

- Гадаад зээлээр санхүүждэг.
- Дотоод зээлээр санхүүждэг.

Тэгээд энэ нь эргээд зарим төслүүд нь төсөвт өртөгтөө багтахаа болиод, тэгээд тэр нь эргээд татвар төлөгчид болон улсын төсөвт нэлээн хэмжээний дарамт авчрахаар хэмжээнд ирлээ шүү дээ.

Хуучин нийслэл ч байдаг юм уу, бусад аймгууд ч байдаг юм уу хэрэгжүүлэх төслүүд нь жижигхэн байсан. Одоо бол ингээд харьцангуй том болоод байна.

Тэгээд энэ дээр нэгэнт төсвийн хүрээний мэдэгдэл, эд нарын асуудал ярих гэж байгаа бол бас үүнтэй уялдуулаад хамт цаашдаа хэрхэх талаар ер нь санал, дүгнэлт бэлдэх нэг ажлын хэсэг гаргамаар юм шиг байгаа юм.

Нэгдүгээр асуудал. Хоёрдугаар асуудал дарга аа... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд тодруулъя.

Х.Ганхуяг: Хоёрдугаарт, Ерөнхийлөгчийн санаачилсан ёс зүйн тэр хууль дээр харин энэ нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгч нартай холбоотой асуудлыг оруулахгүй бол өчигдөр нэлээн сэтгэл эмзэглүүлэхээр юм ярьж байна лээ шүү дээ.

Би мэдээгүй байхад тендер авсан байна. Тийм ээ. Юу гэсэн үг юм. Энэ чинь төсвөө өөрөө батлаад, мэдээгүй байж байгаад тендерээ аваад ингээд явж болдог юм уу? Тэгээд хуулиар хориглоогүй юм байна гэсэн юм яриад зогсож байх юм.

Тэгээд энэ асуудал дээр нэлээн онцгой анхаарал хандуулахгүй бол ер нь болохооргүй л болсон юм шиг надад харагдаад байгаа юм.

Тэгээд энэ дээр Байнгын хорооны гишүүд анхаармаар юм шиг санагдаад байгаа юм. Баярлалаа.

Н.Наранбаатар: Би нэг асуулт байгаа.

Гишүүд ч ярьж байна, тайланд ч байгаа. Та бүхэн зөвлөмж, дүгнэлтийг өгч байгаа.

Хэрэгжилт л тааруу байгаа гэсэн ийм л зүйл харагдаж байгаа. Тухайлбал, төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвөө батлуулахдаа хэтэрхий өндөр зардлаа хэтрүүлээд ингээд нөөцтэй гэдэг юм уу гээд батлуулдаг асуудал жил болгон явж л байна.

Тэр төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилдөг. Төсвөө дагаж өөрчилдөг нэг ийм баримт бичиг болсон гээд яригдаж байна.

Мөн гишүүд өөрсдөө зарчмын зөрүүтэй санал гаргаад төсвийг нэмдэг, урсгал зардлыг нэмдэг. Тухайлбал, энэ 2026 оны төсвийг чинь 1.4 их наяд төгрөгөөр нэмсэн. Засгийн газрын өргөн барьснаас. Ингээд л төсвийн шаардлагуудыг зөрчөөд л явж байдаг.

Та бүхэн эдгээрийг бүгдийг нь хэлээд, зөвлөмжөө өгөөд, дүгнэлтээ гаргаад л явж байдаг. Харамсалтай нь Та бүгдийн энэ зөвлөмж, дүгнэлт чинь цаасан дээр үлдээд л яваад байгаа юм л даа. Ямар нэгэн хариуцлагын механизм байхгүй. Эргээд үр дүнг тооцдог нарийн шалгуур үзүүлэлт байхгүй ч гэдэг юм уу, тайлан дээр л лав тийм юм харагдахгүй л байгаа.

Тэгэхээр товчхон. Та бүхэн цаашдаа нэлээн хэдэн жил энэ асуудал ингээд явчхаж байгаа юм чинь ямар тодорхой алхам хийх ёстой юм бэ? Энэ дээр та бүхний бодож байгаа санал, онол юу байна? Аль эсвэл хууль дүрэм, журам эрх зүйн орчинд нь өөрчлөлт хийх шаардлага байдаг юм уу, үгүй юм уу? Энэ дээр нэг Та бүхэн саналаа хэлээч. 2 номер.

Ж.Дэлгэрсайхан: Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Тийм ээ. Бидний тайлан дүгнэлт хийсэн Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээний хэлтсийн дүгнэлт дээр ч гэсэн яг тийм үг, өгүүлбэрүүд байгаа. Та бүхний хийж байгаа ажлын хэрэгжилт нь яах юм, юугаар хэмжих юм гэдэг асуултуудыг тавьсан байгаа.

Тэгэхээр бид хуулиараа хязгаарлагдмал байдалд байгаа юм.

Манай зөвлөл нь хамтын шийдвэр гаргалтаа өгөөд, зөвлөлийн шийдвэр нь зөвхөн дүгнэлт, зөвлөмж байна л гэсэн.

Тэгээд дүгнэлт, зөвлөмжөө холбогдох газруудад хүргүүлдэг механизмтай. Манай дүгнэлт, зөвлөмжийн дийлэнх нь Улсын Их Хурал буюу 90 хувь нь Улсын

Их Хурал дээр очиж байгаа. Макро эдийн засгийн таамаглал Засгийн газар дээр очиж байгаа.

Тийм учраас бид дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг яаж үнэлэх вэ гэдэг дээр Улсын Их Хурлаас гарсан шийдвэр гаргалтаар нь үнэлэх үү, эсвэл Засгийн газрын оруулж ирсэн дараа жилийн төсвөөр нь өгөх үү, өмнөх жилд бидний өгч байсан зөвлөмжийг төсөвтөө тусгаж өгсөн үү, үгүй юу гэдгээр үнэлэх үү гэдэг ийм гаргалгаануудыг хайж байна.

Тэгэхээр бид цаашдаа үнэхээр хэрэгжилтийг үнэлэх хувилбар гаргах нь зүйтэй юм байна гэдэг дээр санал нэг байна.

Гэхдээ энэ хувилбар дээрээ бид ярилцъя. Хууль эрх зүйн орчны хувьд бид нарт яах вэ, нэгдүгээрт өнөөдөр үйл ажиллагааны хувьд бид харьцангуй бүх зүйл Тамгын газраас хараат байгаа болохоор шийдвэр гаргалтууд нэг их хурдан явахгүй байгаа тал байна.

Хоёрдугаарт, энэ дүгнэлт, зөвлөмжүүдээ бид үнэлэхдээ яаж дүгнэлт, зөвлөмж үнэлэх вэ гэдэг тийм аргачлалыг өөрсдөө тусдаа боловсруулж өөрсдөдөө гаргаж авах нь зүйтэй. Тэгж байж тэр аргачлалаа дүрэм, журам байдлаар батлуулж авах уу, үгүй юу гэдэг ийм л зүйл харагдаж байгаа юм.

Түүнээс бусад манайх бие даасан байгууллага биш учраас 2013 онд гаргасан байгууллагын үнэлгээний тэр стандарт журмын дагуу үнэлнэ гэхээр бас биш болно. Түүний тулд бид бие даасан байгууллага юм уу, эсвэл ядаж төсвийн шууд захирагч болж байж энэ асуудлаа тэр байгууллагынх нь статусын түвшинд үнэлэх байдалтай болоод байгаа юм.

Тэгэхээр бид хуульд ийм хоёрдмол заалттай байгаа гэдгийг Та бүхэн ойлгоорой. Гэхдээ үүнийг ойлгож хүлээж авч байна. Цаашдаа бид ямар нэгэн байдлаар өөрсдөө тодорхой хэмжээний өөрсдийн үйл ажиллагааны дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг үйл ажиллагааны үр дүнг гэсэн хоёр чиглэл д үнэлгээ хийж дараагийн жилийн тайлангууддаа анхаарч тусгаж оруулъя.

Н.Наранбаатар: 6 номер нэмж хариулъя.

Н.Энхбаяр: Баярлалаа. Байнгын хорооны даргын асуулт дээр би нэг товчхон нэг ганц хоёр санал хэлье гэж бодож байна.

Та бүхэн саяхан Дэлхийн банкнаас 4 дүгээр сард гаргасан Монголын эдийн засгийн тойм гэсэн. Үүнийг сайн харах хэрэгтэй болов уу гэж бодож байна. Үүний дүгнэлт дээр ямар улс орнууд эдийн засаг нь их савлагаатай байгаа гэдгийг маш тодорхой ингээд графикаар харуулсан байгаа. Монгол Улс эдгээрийн нэг нь.

Манай эдийн засаг түүхий эдийн үнээс хамааралтай, маш их савлагаатай учраас энэ савлагааг бууруулахын тулд л бид төсвийн хүрээ гэдэг зүйлийг

хэрэглээд байгаа юм л даа. 10 гаруй жил. 2008 онд төсвийн хүрээний анхны хуваарийг баталж байсан юм байна лээ.

Тэгэхээр энэ дүгнэлтүүд бидний дүгнэлттэй нийлж байгаа.

Хоёрдугаарт, Байнгын хорооны дарга цаашдаа яах вэ гэж асууж байна. Тийм ээ.

Тэгэхээр миний хувьд олон жил Сангийн яам төсвийн юугаар ажилласны хувьд хууль тогтоомжийн хууль дээр л бид алдаа гаргаад байх шиг байна. Хууль тогтоомжийн тухай хуулиар Засгийн газрын 2016 онд баталсан журам зөвхөн тухайн хуулийг хэрэгжүүлэх холбогдсон зардлыг тооцоод байгаа байхгүй юу. Аргачлал нь. Одоо энэ сая өргөн барьсан Зээлийн ашиглалтын тухай хууль чинь. Тийм ээ. Зөвхөн энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой байгууллага орон тоо... /минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулъя.

Тэгэхээр үр дагавар нь харагдахгүй, гарч ирэхгүй байгаа юм.

Тэгэхээр уг нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.2.3-ыг бид цаашдаа илүү тодорхой болгоод, ямар нэгэн хууль тогтоомж болон нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа цаашид гарч болох төсөвт учруулах дарамт гэдэг зүйлээ тооцдог. Тэрийг нь өргөн барьж байгаа хууль дээрээ Төсвийн байнгын хороо ч юм уу. Тийм ээ. Нэгтгээд. Нийтдээ ирэх жилүүдэд энэ хуулийг баталснаар ийм ачаалал үүсэх юм байна гэдэг тооцоог хийдэг болохгүй бол нөгөө төсвийн хүрээг чинь эвддэг бүх ажлаа бид өдөр тутам л энд хийгээд байгаа.

Ганцхан хуулийн заалт батлаад л тэр нь дараа жилийн төсөв дээр маш их урсгал зардал бий болгодог ийм тогтолцоо одоо хүртэл байж л байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх байгууллага дээр. Тийм ээ. Урьд нь баривчилдаггүй байсан ялыг маргааш нь баривчилдаг болгоод батлахад энэ өөрөө төсөв дээр асар их ачаалал авчирч байна, шүүх дээр ачаалал авчирч байна.

Тэгэхээр энэ зардлаа бид тооцож чадахгүй байна гэдгийг л цаашдаа анхаармаар байна.

Н.Наранбаатар: 3 номерын микрофон нэмээд хариулъя.

А.Энхбат: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Санал, зөвлөмж цаасан дээр үлддэг. Цаашдаа тодорхой ямар хариуцлагын асуудал байж болох вэ.

Зүгээр миний хувь хүн санхүүч, эдийн засагчийнхаа хувьд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг анх бичихэд оролцож байсан хүний хувьд нэг зүйл байгаа. Өөрөөр хэлбэл бидний орхигдуулсан нэг анхаарах, цаашдаа өнгөрсөн бараг 15, 16 жилийн хугацаанд энэ хууль гээд явахад Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйл дээр хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага гээд.

Хэрвээ энэ төсөвтэй холбоотой төсвийн зардлыг хэтрүүлсэн тохиолдолд төсвийн шууд захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч, мөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэх мэт энэ хүмүүст хариуцлага тооцох асуудлуудыг хөндөж гаргасан байж байгаа.

Гэхдээ бид ялангуяа төсөв батлах үед, мөн төсвийг батлаад дараа жилийн гүйцэтгэл гарах үед ямар нөхцөл... /минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээгээд хариулъя.

А.Энхбат: Ямар нөхцөл байдал үүсээд, яагаад энэ зардал хэтэрсэн, эсвэл орлого дутуу төвлөрсөн гэдэг ч юм уу, тооцооллын алдаа гэдэг ч юм уу, ийм зүйл дээр бид Улсын Их Хурал төсвийн өмнө ямар хариуцлага хүлээх ёстой юм.

- Төсвийн байнгын хороо төсвийн өмнө ямар хариуцлага хүлээх ёстой юм.
- Улсын Их Хурлын гишүүд тухайн асуудал дээр ямар хариуцлага хүлээх ёстой юм –

-гэдэг энэ санкцын асуудлуудыг парламентын түвшинд, Ерөнхий сайд, Сангийн сайд, төсвийн ерөнхийлөн захирагч нар ямар хариуцлага хүлээх ёстой юм бэ гэдгийг тодорхой хуульдаа заагаад өгөх шаардлагатай байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Да.Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Дараалалд нь оруулъя. Д.Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт маш чухал дүгнэлтүүд гардаг.

Аль болох энэ дүгнэлтийг гишүүн болгон уншиж судалж, хууль тогтоомжийг нь, орж байгаа асуудлын нюанс уялдаа холбоог харж байх ёстой гэж ойлгодог юм.

Өнөөдөр зөвлөлийн үйл ажиллагааны тайлан гэхээс илүү энэ гарч байгаа дүгнэлт, шийдвэр, хэрэгжилт нь ямар вэ л гэдэг дээр хамгийн нэн тэргүүнд анхаарах ёстой юм шиг.

2025 онд хуулиар гаргах ёстой нийт 16 баримт бичигт зөвлөмж, дүгнэлт гаргахдаа 25 зөвлөмж өгсөн юм байна.

Гэхдээ үүний хэрэгжилт яг хэдэн хувь байв гэдэг тодорхойгүй. Ийм асуудлууд байна шүү л гээд гаргаад байдаг. Гэхдээ түүнд бодит үр дүнтэй арга хэмжээ авч чадахгүй байгаад л хамгийн асуудлын учир байна л гэж харж байна л даа.

Надад хэдэн санал байгаа юм.

Нэгдүгээрт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн асуудлыг манай байнгын хороо авч үзэж, ялангуяа хараат бусаар ажиллах нөхцөл, боломжийг нь бүрдүүлэх тал дээр анхаарах ёстой юм шиг.

Одоо Улсын Их Хурлын дэргэд гэж байгаа. Өөрсдийнхөө ажлын алба, баг бүрэлдэхүүнтэй болох гээд, хүнээ томилох гээд ч чаддаггүй гэж байна. Төсөв нь бусдаас хамааралтай яваад байдаг. Үйл ажиллагаа явуулах боломж нь ер нь хангагдаж байна уу, үгүй юу. Энэ дээр бид авч үзэх ёстой байх. Үйл ажиллагааг нь дүгнэж байгаа юм бол, тайланг нь сонсож байгаа юм бол.

Тэгэхээр юуны түрүүнд мэргэжлийн баг, судалгааны багтай байх ёстой гэж үзэж байгаа. Өнөөдөр 5, 6 зөвлөлийн гишүүд суугаад өөрсдөө энэ бүх судалгаа, шинжилгээ, тооцооллуудыг хийгээд явахад харьцангуй хүн хүч дутмаг.

Тийм ч учраас илүү макро загварчлалын түвшинд мэргэшсэн мэргэжлийн багтай байж яг энэ цаг үе нөхцөл байдалд таарсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, дүгнэлтүүдийг гаргадаг ажлыг давхар хийх ёстой болов уу гэж харж байгаа.

Хэдийгээр тухайн төсвийн жилд төсөв батлахад нь төсөвтэй холбоотой мэргэжлийн дүгнэлтээ гаргаад өгч байгаа ч гэлээ гэсэн. Тухайн төсвийн жилийн явцад. Одоо жишээлбэл энэ жил түлш шатахууны геополитикийн асуудлаас болоод томоохон хүндрэлүүд үүсээд эхэллээ шүү дээ.

Тэгэхээр үүсэж байгаа энэ нөлөө төсөвт ямар эрсдэл дагуулах нөхцөл байдал байгаа юм бэ гэдэг таамаглалын шинжилгээнүүдийг хийж олон нийтийг, ялангуяа эрх баригчдыг мэдээллээр хангаж байх, хууль тогтоогчдыг мэдээллээр хангаж байх нь чухал юм болов уу гэж харж байгаа юм.

Ер нь хамгийн сүүлд нь хэлэхэд ер нь бид Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг хэрэгжүүлэх механизмыг яаж бүрдүүлэх ёстой юм бэ. Хэрэгжихгүй байгаад ингээд зөвлөмж гаргаад л яваад байдаг. Зөвлөмжийг нь Улсын Их Хурал парламент дээр авдаггүй, улс төрчид зөвлөмжийг нь үл хайхардаг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа зөрчөөд байдаг. Хууль зөрчөөд байна шүү гэж гаргаж өгөөд байгаа зөвлөмж, дүгнэлтийг нь ерөөсөө

ойшоож үздэггүй. Энэ нөхцөл байдал байгаад л байвал ер нь цаашдаа дүгнэлт, зөвлөмж гаргахын хэрэг байгаа юм уу гэдэг юм руу явах гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ хэрэгжүүлэх механизмыг нь тодорхой болгохын тулд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрөө энэ дээр ямар дүгнэлт анализ хийж байгаа юм. Одоо уг нь тайлан хэлэлцэж байгаа энэ цаг үед ийм л дүгнэлт, саналаа зөвлөл оруулж ирэх ёстой байсан байх гэж бодож байна.

Хэчнээн дүгнэлт гаргав гэдгээс илүүтэй цаашдаа хараат бусаар үйл ажиллагаа явуулахад Төсвийн байнгын хорооны зүгээс, парламентын зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байгаа юм. Хууль эрх зүйн ямар орчин хэрэгтэй байгаа юм гэдэг зүйлийг илүү гаргаж тайлагнаж байх нь зүйтэй байх гэсэн саналтай байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Баярлалаа. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Тэгэхээр дэлхий нийтэд парламентын дэргэд төсвийн алба байдаг. Тэгэхдээ манайд сүүлийн үед ажиглагдаад байгаа нэг буруу хандлага гарч ирээд байгаа байхгүй юу. Одоо эд нар дүгнэлт гаргана. Тэрийг нь хэрэгжүүлэх юм шиг. Үгүй.

Эд нар Их Хурлыг зөвхөн зөвлөмж мэдээллээр л хангах ёстой байхгүй юу. Түүнээс биш цэц шиг ажиллаж болохгүй. Эд нар дүгнэлт гаргадаг. Тэрийг нь заавал биелүүлдэг байж болохгүй.

Төсөв өөрөө хууль. Их Хурлын гишүүдийн онцгой эрх. Тэд нар зөвлөх ёстой болохоос биш эд нар цэц шиг дүгнэлт гаргаад тэрийг нь Их Хурал хүлээж авч биелүүлнэ гэдэг юм байхгүй. Энэ буруу хандлага.

Тийм учраас үүнийг яаж өөрчлөх ёстой вэ гэвэл дэлхийн нийтлэг жишгийн дагуу тэр төсвийн алба гэдгийг нь бий болгоод, бидэнд зөвлөмж, мэдээлэл өгдөг, судалгаа хийдэг.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд ямар байх юм. Бид Монголбанкны үгэнд орж болохгүй байх нь эднийхийг бэхжүүлэх асуудал байгаа байхгүй юу. Тэр мөнгөний үзүүлэлтүүд үнэн юм уу, худлаа юм уу. Тийм мэдээллээр л биднийг хангах ёстой болохоос биш эд нар бодлого тодорхойлогч биш ээ. Та нар эндүүрээд байна. Эд нарын гаргасан дүгнэлт хэрэгжих ёстой юм шиг биш. Бидэнд зөвлөгөө өгөх улсууд байхгүй юу. Дэлхий нийтээрээ тийм. Энэ цэц биш. Үүнийг ингэж эндүүрч болохгүй.

Тэгэх юм бол Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаж эхэлнэ наадах чинь.

Тэгэхээр би ажлын хэсгийг нь ахалж байсан. Одоо хэвээрээ юу, үгүй юу. Төсвийн шинжилгээний алба энэ хоёрыг нэгтгээд явах ёстой. Цэц шиг ажиллуулж болохгүй. Бидэнд –

- туслалцаа үзүүлдэг,
- зөвлөдөг,
- мэдээллээр хангадаг ийм л байгууллага байх ёстой.

Тэгээд үүнийгээ бид эндүүрээд эд нар дүгнэлт гаргаад л, тэрийг нь Их Хурлын гишүүд биелүүлээд л, эд нар цэц шиг ажиллаад л ингээд явах юм шиг ойлгоод байх юм. Тийм юм биш шүү дээ.

Бид туслалцаа үзүүлж байх ёстой. Хамгийн гол функц нь ерөөсөө тэр байхгүй юу.

Тэгэхээр тэр ажлын хэсэг татан буугдаагүй бол бид тэрийгээ үргэлжлүүлж ажиллаад Төсвийн шинжилгээний алба гэж тусдаа биш, энэ хоёроо нэгтгээд явах ёстой.

Дэлхий нийтийн практикийн дагуу бид үүнийгээ хийх ёстой. Төсөв бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаардаг ажил. Үүнийг зөв хийхэд эд нар туслалцаа үзүүлж, мэдээллээр хангах ёстой.

Тэр инфляц оруулж ирээд байгаа нь үнэн юм уу, худлаа юм уу.

- Эд нар судалгаа хийх ёстой.
- Эдний дэргэд аппарат байх ёстой.
- Эрдэмтдийн баг байх ёстой.

Тэд нар судалгааг нь хийдэг. Тэд нар бид нарыг шаардлагатай мэдээллээр хангадаг.

- Монголбанкны аманд орохгүй.
- Сангийн яамны аманд орохгүй байх –

-бүх төрлийн мэдээлэл, судалгаагаар хангадаг ийм байгууллага л байх ёстой байхгүй юу. Тэгж хуульдаа ингээд өөрчлөлт оруулаад явмаар байгаа юм.

Төсвийн цэц биш. Үүнийг ойлгох хэрэгтэй.

Н.Наранбаатар: Төсвийн шинжилгээний алба, Тогтвортой байдлын зөвлөлтэй нэгдээд ажлын алба нь болоод явж байгаа.

Да.Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Гадаадын зээл ашиглалтын хууль гэдэг хууль чинь хууль зөрчинө шүү, төсвийн гадуур дахиад төсөвтэй болно шүү гэдгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл сая Ц.Даваасүрэн гишүүний хэлдгээр маш сайн зөвлөлөө.

Энд 6 хүн орж ирсэн. Зургуулаа хэллээ. Манай гишүүд ч сайн асуулаа.

Тэгээд үүнийг Улсын Их Хурлын даргад дахиад хэлье. Анхааруулж хэлье. Энэ хууль чинь батлагдах юм бол улсын төсөв чинь утгаа алдаж эхлэх зам нь нээгдэнэ шүү гэдгийг.

Жишээлэхэд, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Баянхонгор аймгийн Байдрагийн голын усан цахилгаан станцаас ямар ч ялгаагүй.

Байдрагийн голын усан цахилгаан станцыг би тэр хууль руу жишээлэхэд нэммээр байна. Гэхдээ төр, хувийн хэвшил концессын байдлаар ч юм уу хийгээд явах бүрэн боломжтой асуудлуудыг төсвийн гадуур дахиад нэг төсвийн хууль хийж байгаад хийх гэж байгааг нь болохгүй шүү гэдгийг зөвлөөд байна шүү гэдгийг маш сайн хэлье.

Хоёрт, Улсын Их Хурлын дарга өөрийнх нь харьяа буюу даргын харьяа байгууллага гэж ойлгоод Монголбанкт уулзаад байсан. Юу ярьсан юм бүү мэд.

Гэтэл Олон Улсын Валютын Сангийн уулзалт жилд хоёр удаа болж байгаа. Хоёр удаа болж байгаа энэ уулзалт руу Монголбанк маш данхар бүтцээр буюу бараг арваад хоолны сав явж байгаа юм. Ерөнхийлөгчийгөө дагаад.

Түүнийхээ оронд Монгол Улсад 3600 албан паспорт олгогдсон байгаа. Сая Х.Ганхуяг гишүүн энд нэгийг нь яриад явлаа. Гадаадад албан паспорт ашиглаад дэмий тэнээд явж байхад нь компани нь тендерт шалгарч байдаг ийм л утгагүй хулгайч нарын систем рүү орсон.

Тэгээд ийм хулгайчуудад гадаадын албан паспорт өгч дэмий тэнүүлж, тендер бэлэглэж байхынхаа оронд төсөв чинь дэлхий өөрөө санхүүгийнхээ хувьд ийм чиглэлд яваад байна.

Олон Улсын Валютын Сан ингэж үзэж байна, Дэлхийн банк ингэж үзэж байна. Энд ийм юм ярилаа, бид энэ иймэрхүү хуралд суугаад ирлээ гээд энэ 6 хүнд албан паспорт өгөөд Улсын Их Хурлын дарга тэр тансаглалаасаа, эсвэл тэр хулгайчдаасаа мөнгийг нь авч байгаад энэ 6-г жилд хоёр олдог тэр хурал руу ядахдаа нэгэнд нь явуулмаар байна.

Улсын Их Хурлын дарга, Төсвийн байнгын хорооны дарга хоёрт үүнийг анхааруулж хэлэх гэсэн юм.

Н.Наранбаатар: М.Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар уул уурхайн орлогын гэнэтийн өсөлт гэх юм уу, орж ирж байгаа орлогыг шинэ баян цээж өвчтэй гээд хамаагүй зардгаас сэргийлэх нэг ийм зүйл дээр зөвлөмж өгдөг гэж ойлгож байгаа.

Тэгвэл нөгөө талдаа энэ нөхөн сэргээгддэггүй баялгаас орж байгаа орлогыг яаж нөхөн сэргээгддэг бөгөөд эдийн засгийн хөгжлийг түргэдэхэд чиглэсэн арга хэмжээнд хэрэгжүүлэх вэ гэдэг дээр маш сайн судалгаа, шинжилгээ хийж олон улсын туршлагыг судалж, олон нийтээр хэлэлцүүлж, ялангуяа энэ говийн бүс, зүүн бүсийн энэ уул уурхайтай, газрын тостой бүс нутгуудаар энэ саналыг авч хэлэлцүүлж, тэгээд энэ зүйл дээрээ их сайн анхаарч өгөхгүй бол энэ нөхөн сэргээгдэхгүй баялгийг хуваарилах талаар, хуримтлуулах талаар Их Хурлын гишүүд зарчмын ийм өөр өөр байр суурьтай байдаг.

Тийм учраас энэ дээр танайх энэ ирэх оны хөгжлийн төлөвлөгөө, төсөв дээр тодорхой саналаа өгөөч ээ гэж би чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм.

Тэгээд ингэхгүй ингээд энэ уул уурхайн баялаг чинь нэг өдөр дуусна. Энэ чинь хэдэн зуун сая жилийн туршид хүний гараар бүтээгдээгүй баялаг.

Тэгээд үүнийгээ эргээд хөгжил авчирдаг зүйлд нь зориулах гэдэг гол ийм концепц байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ зүйлийг тийм маш сайн Та бүхнийг судалж шинжилж, харьцуулж нэг талыг барьсан биш, ингэж оруулж ирээч гэж хүсэж байгаа юм. Ингэхгүй бол үүнийг тойрсон маш их нууц гэрээ, оптик гэрээ л гэж байна. Үүнийг тойрсон хулгайн асуудал гэж байна. Авлига албан тушаалын асуудал гэж байна.

Тэгээд энэ зүйл чинь яг үнэндээ хэрээс хэтэрч байгаа байхгүй юу. Иргэд үнэндээ итгэл алдарч байна шүү дээ.

Уг нь зүй нь эцэг, өвгөдөөс үлдээсэн энэ өргөн уудам нутаг, баялгаа зөв зарцуулаад цөөн хүн амдаа зөв хүргээд, тэгээд улс орондоо шударга ёс, улс орондоо хөгжил дэвшил, ирээдүй хүүхдүүддээ сайн сайхныг авчраасай л гэж хүсэж байгаа шүү дээ. Энэ дээр би их санаа зовж явдаг.

Тийм учраас энэ зүйлийг Та бүхэн зориуд ингэж оруулж өгөөч ээ, судлаач ээ гэж хэлж байгаа юм.

Ер нь төсвийн тогтвортой байдал чинь тодотголоор алдагдаж байгаа юм. Одоо ингээд аягүй бол тодотгол өргөн барьж, тодотгол хийх байх гэж би таамаглаж байна. Тодотгол хийх бол муу. Аль болох тодотгохгүй сайн төлөвлөх ёстой. Ямар муу сөрөг үр дагавар гардаг вэ гэхээр тодотгохоор дийлдгээрээ Орон нутгийн хөгжлийн санг орлого бүрдээгүй гээд л хасдаг.

Гэтэл тэнд нь гэрээ байгуулсан, зээл авсан өчнөөн гүйцэтгэгч аж ахуйн нэгж байдаг.

Тэгээд тэд нар нь санхүүжилтээ авч чадахгүй, өндөр хүүтэй банк бус, хувь хүнээс аваад ингээд үндсэндээ тэр компани чинь хөгжиж чадахгүй байгаа. Өрөнд орж байгаа. Өнөөдөр Монгол Улсын төсөвт хүүхдийн мөнгө, цалин, тэтгэврийн 25 их наяд төгрөг ордог бол үүний 5-аас 6 их наяд төгрөг чинь хүүд явж байгаа.

Ингээд аж ахуйн нэгжүүд дээрээ хүндрэл үүсээд байгаа учраас үүнийг тийм эрсдэлийн сантай болгоод, тухайн жилдээ шууд дураараа хасдаг биш. Нэгэнт гэрээ байгуулсан төр үүргээ биелүүлээд бүрэн санхүүжүүлдэг. Тухайн жилийн. Энэ төсвийн тухай хуулийн 29.3.6 дээр байгаа шүү дээ.

Хөрөнгө оруулалтын төсвийн дүнг тодотголоор бууруулахгүй гээд.

Тэгэхээр үүнийг шийдэхийн тулд ингэж эрсдэлийн сангаас юм уу, үүнийг шийдээд, дараа нь ирэх оных нь хуваарилах дүнгээс нь бууруулдаг юм уу, ямар ч байсан тийм аж ахуйн нэгжид гэнэтийн хүндрэл үүсгэдэг зүйлийг л таслан зогсоох чиглэлээр онцгой анхаарах шаардлагатай байгаа. Наад орон нутгийнхан чинь хэлж чадахгүй байгаа.

Тийм учраас үүнийг би дуу хоолойг нь болж орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн өмнөөс үүнийг илэрхийлж байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2025 оны тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалдаа орно.

Хоёр.Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 115.2.1-д төрийн аудитын байгууллагын тайланг Төсвийн байнгын хороо жил бүр хэлэлцэнэ гэсэн хуулийн зохицуулалттай.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч, Буянтогтохын Бундхорол

Үндэсний аудитын газрын Тамгын дарга, Тэргүүлэх аудитор, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, Тэргүүлэх аудитор, Эрдэнэжаргалын Энхбаатар Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер, Сүхбаатарын Нацагдорж Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер.

Төрийн аудитын байгууллагын тайланд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээ хийж ирүүлснийг Байнгын хорооны гишүүд Та бүхэнд хүргүүлсэн.

Тамгын газрын ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Ганбатын С.Эрдэнэбат Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга, Жамбалдоржийн Сайнхишиг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга, Тогмидын Гоцбаяр Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт, Цогт-Очирын Лхагвагэрэл Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт.

Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайланг Монгол Улсын ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулна.

4 номерын микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллага 2025 онд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан мэдээллийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн бөгөөд тайлант хугацааны онцлох үйл ажиллагааны талаар Та бүхэнд тоймлон танилцуулъя.

Төрийн аудитын байгууллагаас 2025 онд дэвшүүлсэн чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд өнгөрөгч онд миний бие Монгол Улсын Ерөнхий аудиторроор томилогдох томилгооны сонсголын үеэр төрийн аудитын үйл ажиллагааг сайжруулахтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс өгсөн саналыг ажил хэрэг болгох үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг.Төрийн аудитын байгууллагын 2025-2030 оны стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлого, аудитын дээд байгууллагын олон улсын байгуулалтын стратеги, хөгжлийн чиг хандлага, төрийн аудитын хэрэгцээ шаардлагад үндэслэн аудитын хараат бус байдлыг хангах, харилцагч талуудын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжих, аудитын үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр нөлөөтэй байх бодлогыг тодотгон тусгаж шинэчиллээ.

Хоёр.Байгууллагын хүний нөөцийг зөв зохистой хуваарилах, аудит хийх чиг үүрэг бүхий хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадамжид суурилсан хүний нөөцийг бэхжүүлэх, аудитын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулалтын өөрчлөлтийг хийсэн.

Энэ хүрээнд аудитын чиг үүрэг бүхий нэгжүүд болох Нийслэлийн аудитын газар, Тусгай чиг үүргийн аудитын газар, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрыг тус тус шинээр зохион байгуулж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл болон холбогдох дүрэм, журмын өөрчлөлтийг хийсний зэрэгцээ 9 хэлтсийг татан буулгаж, удирдах албан тушаалтны тоог 20 хувиар бууруулж, нийт албан хаагчдын 80.2 хувь нь аудитын үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг байхаар өөрчиллөө.

Гурав.Төрийн аудитын үйл ажиллагаанд цахим технологийг үр дүнтэйгээр нэвтрүүлэх, аудитад их өгөгдлийг ашиглах, аудитын удирдлагын нэгдсэн системийг хөгжүүлэхийг зорьсон мэдээллийн технологийн бодлогыг баталж хэрэгжүүлж эхлээд байна.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлж, цахим шилжилтийг үр дүнтэй хийснээр шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлэх, цахим аудитын тогтолцоог хөгжүүлэхэд нөөцийг зохистой хуваарилах, бодлогын шийдэл гаргах чиглэлээр байнгын үйл ажиллагаатай ажиллах орон тооны бус нэгж болох –

- Мэдээлэл, технологийн удирдах хороо,
- Мэдээлэл, технологийн хэрэглэгчийн хороог –

-олон улсын жишгийн дагуу тус тус байгуулан ажиллаж байна.

Дөрөв.Аудитын шийдвэр, түүний хэрэгжилт, үр дүнд онцгой анхаарч, шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах, хэрэгжилтийг хянах тогтолцоог оновчлох зорилгоор тусгайлан хариуцсан чиг үүргийн нэгжийг байгуулан өмнөх онуудын хэрэгжээгүй шийдвэрүүдийн мэдээллийн санг үүсгэж бүртгэл хяналтын системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд аудитын шийдвэрийн хэрэгжилтийн нэг удаагийн тайлагналын бус тасралтгүй хяналт үнэлгээний горимоор удирдах, аудитын дараах нөлөөллийг тооцох боломжийг бий болголоо.

Тав.Аудитыг мэргэшсэн олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдын сургалт, хөгжилд анхаарал хандуулж, олон улсын төрийн аудитын суурь стандарт болох Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 140, Аудитын дээд байгууллагын чанарын удирдлага, мөн Аудитын дээд байгууллага, олон улсын стандарт 150, аудиторын чадамж, стандарт зааврыг баталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байна.

Түүнчлэн Үндэсний аудитын газар 21 аймаг болон нийслэл дэх Төрийн аудитын газарт ажиллаж буй аудиторуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтыг чанартай, үр дүнтэй, хэмнэлттэй хийхэд орчин үеийн мэдээллийн технологийн шийдлийг ашиглан олон улсын чиг хандлагад нийцүүлэн явуулж байна.

Энэ нь төсөв, санхүүгийн хязгаарлагдмал байдалд хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхийн зэрэгцээ нэг дор нэг цаг хугацаанд нийт албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулах шинэ технологи, арга барил, хууль эрх зүйн өөрчлөлтийн талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүлж өөрчлөлт шинэчлэлтэд хурдан дасан зохицох боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Тайлант онд хийж гүйцэтгэсэн аудитын ажлын үр дүнгийн талаар.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн аудитын байгууллага 2025 онд хуулийн дагуу 18, бодлогоор 19, нийт 37 аудитыг гүйцэтгэж Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодод тус тус хүргүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн болон бодлогоор хийж гүйцэтгэсэн аудитын 20 тайланг Улсын Их Хурлын чуулган болон Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн ба бусад аудитын тайланг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх чиг үүрэг, Төсвийн байнгын хорооноос баталсан 37 аудитын сэдвийн хүрээнд 6974 шалгагдагч байгууллагыг хамруулан санхүүгийн тайлангийн 3677, гүйцэтгэлийн гүйцэтгэлийн 94, нийцлийн 183, нийт 3954 аудитыг хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын дүнд –

- › 57.4 тэрбум төгрөгийн 3014 төлбөрийн акт тогтоож,
- › 14.4 их наяд төгрөгийн 7424 албан шаардлага,
- › 5.4 их наяд төгрөгийн 11 мянга 998 зөвлөмж,
- › 437.9 тэрбум төгрөгийн 296 сахилгын шийтгэл –

-ногдуулах албан шаардлага өгч, 55.8 тэрбум төгрөгийн 51 асуудлыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар тус тус шилжүүлээд байна.

Аудитын үр дүнд 2025 онд улс орон нутгийн төсөвт 62.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бол нийт 1.5 их наяд төгрөгийн үр өгөөжийг аудитад хамрагдсан байгууллагууд хүлээн зөвшөөрсөн нь улсын төсвөөс зарцуулсан нэг төгрөг тутамд 32.1 төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бий болгож, аудитын дүнд төрийн санхүү, төсвийн сахилга бат, засаглалын чанарт бодит нөлөө үзүүлэхүйц асуудлуудыг хөндөж, шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах аудитын үр нөлөөг дээшлүүлэхэд анхааран ажиллалаа.

Төрийн аудитын байгууллага 2025 онд дээрх үйл ажиллагааг хүний нөөцийн болон төсөв, санхүүгийн хязгаарлагдмал нөхцөлд хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 5.9 тэрбум төгрөгөөр төсөв буурч батлагдсан бөгөөд энэ нь 47 албан хаагчийн цалин хөлс болон аудитад оролцох шинжээч, дотоод албан томилолт, тээвэр, шатахуун зэрэг аудитын үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах зардлууд хасагдаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй байсныг дурдах нь зүйтэй байна.

Төрийн аудитын байгууллага 2025 оны аудитын дүн, шийдвэрийн хэрэгжилт, олон улсын аудитын дээд байгууллагуудын чиг хандлага, хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлсэн бодлогын саналыг үндэслэн 2026 онд аудитын үр дүн, шийдвэрийн хэрэгжилт, нийгэмд бий болгох, аудитын нөлөөллийг үнэлэх, үйл ажиллагааг шинэ шатад гаргах зорилгоор 2026 оныг аудитын нөлөөллийг тооцох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлэх жил болгож үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллага бодлогоор гүйцэтгэсэн буюу төлөвлөгөөт аудитыг эрсдэлд суурилсан ач холбогдолтой, олон түмний хариулт нэхсэн, улс орны хөгжилд тулгамдаж буй нэн тэргүүний асуудлыг онилсон сэдвийг сонгон хийх, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг нэмэгдүүлэн үр нөлөөг тооцох, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Төрийн аудитын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны талаар товчлон танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: С.Магнайсүрэн даргад баярлалаа.

Одоо тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Дараа нь үг байгаа.

Ж.Батсуурь гишүүнээр тасаллаа. С.Эрдэнэбат гишүүн нэрээ оруулах юм уу? Оруулах уу? С.Эрдэнэбат гишүүнийг нэмээрэй. Дэс дараалалдаа орсон уу?

Б.Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Би зүгээр практигал асуулт асууя гэж бодож байна. Тухайн тухайн үед нь нэлээн л асуудаг.

Тэгээд Үндэсний аудитын газрын тайлангаар маш их дутагдал, алдаа зөрчил гардаг.

Тэгээд бараг зарим нь жил болгон давтагдах магадлалтай. Нөгөө талдаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн маш их ийм дүгнэлт гаргаж байгаа. Тайлан гаргаж байгаа. Зарим дүгнэлт, зөвлөмжүүд нь давтагдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ Үндэсний аудитын газрын нөлөөг хэрхэн өсгөө гэж Та бүхэн боддог вэ? Баахан дүгнэлт гаргаад, зөвлөмж өгөөд хэрэгжихгүй байгаа юм чинь яавал зүгээр вэ гэдэг дээр нэг санаа оноогоо хуваалцаач л гэж ийм товч бөгөөд тодорхой мэдээжийн асуулт асууя.

Н.Наранбаатар: С.Магнайсүрэн дарга хариулъя. 4 номерын микрофоныг нээе.

С.Магнайсүрэн: Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн. Б.Мөнхсоёл гишүүний саналтай санал нэг байгаа.

Тэгэхээр өнөөдрийн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн төрийн аудитын тухай хуулиар аудитын шийдвэр заавал биелэгдэх ийм эрх зүйн орчин нь байна.

Тэгэхээр бид энэ эрх зүйн орчинд аудитын шийдвэрийг зайлшгүй хэрэгжүүлдэг болох энэ чиглэл рүү бүх зохион байгуулалтаа хандуулж хариуцлагын механизмыг энэ тал дээр өнөөдрийн байгаа хууль эрх зүйн орчинд нь хангалттай хэрэгжүүлэх энэ чиглэл рүү нэлээн анхаарч ажиллаж чадвал энэ бололцоо байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас өнөөдөр бид энэ аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар гэж тусгайлан зохион байгуулсан. Дээр нь өмнөх онуудад хэрэгжээгүй байсан бүх шийдвэрүүдийг бид гаргаж дата өгөгдөлтэй болж чадсан.

Ингээд үүнийгээ судлаад үзэхээр зэрэг зарим байгууллагууд татан буугдсан, зарим албан хаагч, албан тушаалтан байхгүй, зарим нь бурхны оронд явсан ч юм уу ингээд янз бүр байгаа учраас бид бүгдийг нь шинжлээд ингээд цэвэрлэсэн байгаа.

Одоо бид энэ дата дээрээ үндэслээд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бүх түвшинд төсвийн ерөнхийлөн болоод төвлөрүүлэн, шууд захирагч нартай хамтарч ажиллаж байна.

Өнгөрсөн жилийн тухайд Засгийн газар манай дүгнэлт, шийдвэр дээр нэлээн анхаарч ажлын хэсэг байгуулж ажилласны үр дүнд олон хариуцлагууд тооцогдож, олон шийдвэрүүд хэрэгжиж эхэлсэн байгаа.

Үүний дүр үр дүнд би сая дурдсан. 62.5 байна уу, 8 тэрбум төгрөг улсын төсөвт актаар төвлөрсөн.

Тэгэхээр үүнээс хойш би аудитын шийдвэрийн хэрэгжилтийн түвшин харьцангуй өндөр түвшинд гарах болов уу гэж найдаж байгаа.

Нөгөө талаар нэг зүйлийг би Төсвийн байнгын хороон дээрээс сэдэв оруулж ирэх үе дээрээ хуулийн заалтын зарим жижигхэн өөрчлөлт бидэнд шаардлагатай байгаа.

Тухайлах юм бол аудитын шийдвэрээр акт тавьж байгаа юм. Аудитын акт. Тэгэнгүүт тэрийг хуучин яасан бэ гэхээр зэрэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас бичигдээд, тэгээд ингээд албадан гүйцэтгэдэг байсан бол өнөөдөр улсын байцаагч биш учраас манай актыг гүйцэтгэхгүй байх ийм нөхцөл байдал үүссэн.

Өнөөдрийн үйлчилж байгаа хууль эрх зүйн орчинд захиргааны байгууллага гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг өөрөө хариуцна гэсэн ийм хуулийнхаа хүрээнд бид явж байгаа.

Тэгэхээр бид энэ тал дээр зарим өөрчлөлтийг Төсвийн байнгын хороон дээрээ оруулж ирж танилцуулж энэ тал дээр гишүүдийнхээ саналыг авах ийм шаардлага байгаа.

Тийм учраас би тулгамдаж байгаа асуудлаа 2027 оны бодлогоор хийх аудитын сэдвийг оруулж ирэх үедээ би танилцуулаад ингээд цаашаа явбал бидний хувьд бүх түвшинд эрх зүйн орчин бүрэн бүрдэнэ гэсэн ийм байдлаар харж байгаа.

Тийм ч учраас сая таны саналд хэлсний дагуу бид 2026 оныг “Аудитын нөлөөллийг тооцох, үнэлэх тогтолцоог төлөвшүүлэх жил” гэж зарлаад энэ хүрээндээ бид нэлээн онцгой анхаарч бодлого, үйл ажиллагааг чиглүүлж ажиллаж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Аудитынхан юм хийх гэж оролдож л байх шиг байна.

Надад хоёр асуулт байна. Нэг нь их тодорхой асуулт. Энэ дээр С.Магнайсүрэн дарга нэг тайлбар хийгээч.

68 дугаар хуудсан дээр байгаа. Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловчиг төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах гээд нэлээн хуудас материал байгаа. Энэ дотроос сая Б.Мөнхсоёл гишүүний асуугаад байгаа шиг дүгнэлт гаргалаа.

Тэгээд одоо яаж ч засаад, залруулаад, яг хэдэн төгрөгийг нь өөрчлөөд тэгээд байгаа юм уу, эсвэл дүгнэлт гаргаад хаяад байгаа юм уу? Үүнийг тайлбарлаад өгөөч.

Хоёрдугаарт нь, та түрүүн уншаад орхисон. Төрийн аудитын байгууллагын 2025 оны үр дүн гээд энэ хуудас байгаа. Үүнийг нэг бүрчлэн тайлбарлаад өгөөч.

Одоо ингээд илэрсэн зөрчил нь 20 их наяд юм уу, юу юм. Тэгснээ залруулсан алдаа нь 10 их наяд ч юм уу. Би тоог нь уншиж мэдэхгүй байна. Энэ нэгж нь байхгүй. Тэгээд төдөн зөвлөмж гаргасан. Хүлээн зөвшөөрүүлсэн. Үр өгөөж гэдэг нь юу гэсэн үг вэ?

Нэг төгрөгт оногдох санхүүгийн үр өгөөж 32 төгрөг гэдэг нь бас юу гэсэн үг вэ? Та үүнийг баахан бичээд байгаа арваад тоо байна л даа. Үүнийг танин мэдэхүйн үүднээс нэг тайлбарлаад өгөөч.

Тэгээд гурав дахь санаа болохоор яг Б.Мөнхсоёл гишүүний хэлээд байгаа шиг энэ их хяналт шалгалтын аудитын үр дүнд юм сайжирч биелж баймаар байна шүү дээ.

Тэгээд биелдэг байлгахын тулд таны саяын хэлээд байгаагаар юм уу? Та нэг хэдэн жижиг сажиг өөрчлөлт хийгээд хуульд өөрчлөлт ороор болох юм уу?

Би одоо ингээд харахаар арваад оны үеэс эхлээд л хийсэн аудитын тэр дүгнэлтүүд, хий гэсэн, залруул гэсэн юм залруулагдахгүй л яваад байгаа байхгүй юу.

Би Эрдэнэт үйлдвэрийг мэдэж байгаа. Тэр Хөгжлийн банкн дээр хийсэн аудитын юмыг би бүгдийг нь гэрт детальчилж үзсэн. Өчнөөн олон тэрбум төгрөг байгаа. Одоо болтол биелэгддэггүй байхгүй юу. Үүнийг яаж биелдэг болгох юм бэ? Биелэхгүй яах ёстой юм бэ?

Н.Наранбаатар: Г.Тэмүүлэн гишүүнийг асуултад нэмээрэй. Хэн хариулах вэ? С.Магнайсүрэн дарга уу? 4 номер.

С.Магнайсүрэн: Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

Тэгэхээр эхний асуулт дээр улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга, байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах энэ ажил сүүлийн хоёр жил хийгдсэн. Тэгэхдээ Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос сэдвээр батлагдаж хийгдсэн.

Тэгэхээр энэ их төвөгтэй ажил байсан. Өөрөөр хэлэх юм бол манай Гүйцэтгэлийн аудитын газрын хүмүүс бараг өнгөрсөн жил гэхэд бид 7, 8 сар зөвхөн энэ дээр ажилласан.

Яагаад вэ гэхээр зэрэг Сангийн яамнаас, бусад яамдаас Сангийн яамаар дамжаад маш олон ийм зогссон нийт 185 төсөл, арга хэмжээ ирнэ гэдэг бол бид тэрийг бүхэлд нь үзэж, энэ төсөвт өртгийн нэмэгдэл нь зөв байна уу, буруу байна уу гэдгийг бид нотлох баримтаар ингэж хянаж байгаа юм.

Тэгээд бид энэ дээр бичигдсэн байгаа байх. Хэдэн тэрбумаар билээ. Юуг бууруулсан. 87.9 тэрбум төгрөгөөр бууруулсан байдаг юм. Төсөвт өртгийг. Зарим дээр нь бид дүгнэлт өгч амжиж чадахгүй ээ. Яагаад гэвэл энэ нотлох баримтаар нотлогдохгүй байна. Боломжгүй. Заримыг нь угаасаа нэмэгдэхгүй гээд бид өгсөн. Энэ дээр байж байгаа.

Ингээд энэ ажил уг нь тухайн зураг төсвөө баталдаг, магадлал хийдэг тэр эрх бүхий төрийн байгууллагууд хийгээд хариуцлагаа хүлээгээд, тэгээд төсөв захирагч нараа дамжаад төсөвт суугаад явж байх ёстой ажил манай дээр ажил нэмээд. Тэгээд тэр бүх ажлыг нь бид эцсийн тайлангаа Төсвийн байнгын хороонд ирүүлээд, тэгээд бас Их Хурал дээр, Байнгын хороон дээр ажил нэмж байгаа юм.

Тийм учраас бид 2025 оны сүүлээр юу гэж Төсвийн байнгын хорооноос сэдэв авсан бэ гэхээр бид жил болгон энэ юмтай ноцолдохоо больё. Бид тэр зураг төсөв зохиогоод байгаа, магадлал хийгээд байгаа тэр суурь луу нь сэдэв баталж оръё гээд энэ жил бид –

- Барилгын хөгжлийн төв,
- Замын хөгжлийн төв,
- Эрчим хүчний хөгжлийн төв,

-тэр зураг төсөв зохиогоод магадалдаг тэр байгууллагуудынх нь үйл ажиллагаа руу орж энэ яагаад та нар буруу зөрүү юм хийгээд байгаа юм бэ, учир шалтгаан нь юундаа байгаа юм бэ гээд бид энэ ул суурь луу нь орж ноцолдохгүй жил болгон төрийн байгууллагуудад ажил нэмсэн, цаг хугацаа авсан ийм зүйл байгаа учраас энэ тал руу нь орсон.

Саяын таны асуудаг дээр яг сүүлийн хоёр жил сэдвээр батлагдаад орсон учраас бид зайлшгүй энэ дээр хийсэн. Маш их ажил болсон. Бас их асуудалтай байсан гэдгийг хэлье. Та зөв харсан.

Хоёрдугаарт нь, 2025 оны үр дүнг бид товчлоод хэдэн тоо оруулсан байгаа. 10.9 тэрбумын залруулсан алдаа гэдэг бол тухайн нягтлан бодох бүртгэлийн тухайн үед нь цифрийн алдаа, шууд залруулах бололцоотой алдааг нь хэлж байгаа юм.

20.2 их наядын илэрсэн зөрчил гэдэг дотор сая би дурдсан 3900 аудит хийсэн. Энэ дотор –

- гүйцэтгэлийн аудит нь ч орж байгаа,
- нийцлийн аудит нь ч орж байгаа,
- санхүүгийн аудит нь ч орж байгаа.

Манай 2025 онд хийгдсэн бүх үйл ажиллагаан дээр өгсөн зөвлөмж –

- хэдэн төгрөг дээр зөвлөмж өгсөн юм,
- хэдэн төгрөг дээр албан шаардлага өгсөн юм,
- хэдэн төгрөг дээр төлбөрийн акт тавьсан юм –

- гээд бүх манай тооны нийлбэр явж байгаа юм.

Тэр 1.5 их наядын хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж гэдэг цаад шалгагдагч байгууллагын тухайд шууд хүлээж аваад шийдвэрлэсэн ийм асуудал байж байгаа.

32.1 төгрөгт ногдох санхүүгийн үр өгөөж гээд тухайн жилийнхээ нийт... /минут дуусав/

Н.Наранбаатар: Хэн гүйцээх вэ? 1 номерын микрофоныг нээе.

Х.Баярмаа: Бодлогын газрын дарга Х.Баярмаа. Н.Алтанхуяг гишүүний асуултад хариульъя.

Ерөнхийдөө бид хийж байгаа ажлынхаа үр дүнг үнэлэхийн тулд илэрч байгаа зөрчил маань өөрөө хэр их хүлээн зөвшөөрөгдөж засагдаж байгаа вэ гэдэг чиглэл дээр олон улсын чиг хандлага байдаг. Энэ чиглэлээрээ бид ажиллаж байгаа.

Тэгээд ер нь аудит шалгагдагч байгууллагуудаас бид бүхэн хариу аваад, энэ дээрээ бид судалгаа хийгээд яг үнэхээр хэрэгжсэн, тэгээд үйл ажиллагааг нь сайжруулсан, зөвлөмж өөрөө хэрэгжээд тухайн байгууллагын үр ашгийг дээшлүүлсэн гэж үзвэл тухайн байгууллагатай ярьж байгаад санхүүгийн үр өгөөжийн асуудлыг тооцож гаргадаг.

Ер нь ингэж гаргах үндсэн зүйл яагаад ингэж тооцож байгаа вэ гэхээр бид төсвөөс авч байгаа нэг төгрөг тутамдаа хэдэн төгрөгийн... /минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээгээд хариулчих.

Х.Баярмаа: Өөрөөр хэлбэл хэдэн төгрөгийн бид үр ашигтай ажиллаж байгаа юм бэ. Бидний сонгож байгаа аудитын сэдэв өөрөө зөв сонгогдож зөв хийгдэж байна уу гэдэг чиглэлээрээ үнэлгээ өгдөг ийм олон улсын жишиг байгаа юм.

Н.Наранбаатар: Н.Алтанхуяг гишүүн тодруулна.

Н.Алтанхуяг: Их олон тоо байгаа юм. Би тэрийг нь товчилъё.

Энэ нэг төгрөгт ногдох санхүүгийн үр өгөөж гэж юу хэлээд байгаа юм бэ? Яг энд хариулаач. Их тойроод яваад байна. Бусад тоог нь больё.

Энэ дээр би дахиад асууя. ингэж бичээд байгаа юм. Энэ ер нь их ноцтой асуудал байхгүй юу. Энэ төсөвт өртөг нэмэгдэнэ гэж байгаа юм. Бид яагаад энэ улс дампуураад байгаа вэ гэхээр төсөвт өртөг нь жилээс жилд л нэмэгдээд л тэгээд 5-аас 10 жил үргэлжилдэг учраас бид дампуураад байгаа байхгүй юу.

Тэгээд та нар ингээд бичээд байна шүү дээ. Төсөв нэмэгдүүлэх саналын 31.3 хувь нь үндэслэлгүй байсныг бид залрууллаа.

Тэгээд магадлалын дүгнэлтийн алдааг зассанаар 87.9 тэрбум төгрөг бууруулсан гэдэг нь бодитойгоор бууруулаад байгаа юм уу? Та нар бууруулж бичээд байгаа юм уу?

Н.Наранбаатар: 4 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Н.Алтанхуяг гишүүний тодруулсан асуултад хариулъя.

Энэ төсөвт өртгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал ажил нь эхэлсэн. Тэгээд зарим нь ч 10 жил болж байна, зарим нь 5 жил. Ингээд дунджаар янз бүр байгаа юм.

Тэгээд ингэж хугацаа сунжирснаас болоод төсөвт өртөг нь нэмэгдээд, тэгээд зарим нь зургийн өөрчлөлт орж ирсэн. Түүнийгээ дагаад төсөвт өртөг нэмэгдсэн. Зарим нь хугацааны сунжралтаас болоод түүхий эд, материалын үнэ өссөнтэй холбоотой нэмэлт бий болсон.

Ийм асуудлууд орж ирээд, энэ асуудал дээр нь бид бүх. Жишээлбэл, бараа материал нэмэгдсэн гэхэд л бид зах зээлийн дундаж үнэлгээний судалгаагаа авч тулгаж үзэх жишээтэй. Ажиллах хүчний нэмэгдэл гэхэд бас яг тэгж үзэж байгаа юм.

Тэгээд энэ бодитойгоор бид үүнийг бууруулж байгаа юм. Зарим нэг асуудал дээр... /минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээгээд хариулъя.

С.Магнайсүрэн: Зарим нэг асуудал дээр ажил нь дөнгөж эхлээд зогссон. Огт яваагүй шахуу. Дөнгөж эхлээд олон жилээр хойш нь төсөвт өртгийг сунгаж хувааж тавьдгийн хор уршиг ер нь төсөвт өртөг нэмэгдэх магадлалыг их яадаг юм билээ.

Ингээд хоёр жилийн хугацаанд магадлагдсан байх ёстой. Магадлагдсан зураг төсвөөр төсөвт суудаг. Гэтэл тэр нь олон жилээр сунжирахаар нөгөө төсөвт өртөг нэмэгдээд байгаа юм.

Тийм учраас бид үзэхээр олон олон шалтгаан байгаа. Ер нь бидний тавьсан асуудал, энэ дээр дурдсан асуудал бодитойгоор бууруулсан асуудал байгаа.

Тэгээд яг энэ тоогоороо Их Хуралд орж ирж санал хураагдаж байгаа юм. Гэхдээ зарим талаар Их Хурал онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд нааш цааш болгож шийдвэрлэсэн ийм зүйл жишээлбэл энэ жилийн төсөв дээр харагдаж л байна лээ.

Н.Наранбаатар: Г.Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Би аудитын байгууллагаас хоёр, гурван зарчмын асуудлуудыг л хөндөж гаргаж ирж асуух гэсэн юм.

Уг нь манай аудитын байгууллага үндсэндээ төрийг төлөөлөөд, ард түмнийг төлөөлөөд төсвийн мөнгөн дээр төрийн манаач нь байх ёстой байгууллага.

Сүүлийн үеийн нөхцөл байдлуудыг аваад үзэхээр төсөвтэй холбоотой, төсвийн ерөнхийлөн захирагч захирагч нартай холбоотой төсвийн хулгай, авлигал, хээл хахууль, шамшигдуулалт гэдэг зүйл чинь хэрээс хэтэрлээ. Ард түмний төрд итгэх итгэл гэдэг зүйл байхгүй боллоо. Ёстой аль асуудлыг нь ярих вэ гэдэг шиг хүрээний булай гэр далай далай гэдэг шиг л дуусашгүй их л ийм хулгай зэлгийтэй, хэрэг төвөгтэй асуудлууд болоод байгаа юм.

Уг нь төрийн аудитын байгууллага аливаа эрсдэл, асуудлуудыг урьдчилж сэргийлж байх ёстой, алдаа зөрчил гарвал тэрийг цаг алдалгүй илрүүлж байх ёстой ийм л байгууллага л даа.

Тэгэхээр санхүүгийн сахилга бат, дэг журамтай холбоотой асуудлыг ер нь яая гэж бодож байгаа юм бэ?

Ахмадууд яриад байгаа юм. Портероор нь чулуу аваад нүүлгэсэн ч бараг тоохгүй ширэн нүүртнүүд наад төрд чинь бий болсон байна шүү дээ гээд байгаа юм.

Тэгээд энэ буруутай нөхдүүдэд хяналт хариуцлагуудыг нь тооцож байгаа зүйл байхгүй болчихоод байдаг.

Би аудитын байгууллагаас гуравхан заалтыг асуух гэсэн юм.

Яагаад вэ гэхээр 2023 онд Төсвийн тухай хууль дээр анх удаагаа хариуцлага тооцох заалтууд орж ирсэн. 2025 оноос энэ заалтууд хэрэгжиж эхэлсэн.

Тэгэхээр одоо хэрэгжиж эхлээд жил болж байна.

- Төсвийн тухай хуулийн 70.2.
- Төсвийн тухай хуулийн 70.4.
- Төсвийн тухай хуулийн 70.5.

Энэ хуулиар үндсэндээ аудитын байгууллагын гар хөл нь мухардмал, хэнд ч хариуцлага тооцож чаддаггүй, хий хоосон зөвлөмж, дүгнэлт гаргадаг байсан зүйл дээр одоо харин Та бүхнийг харин ёстой нэг ил бамбайтай, сэлэмтэй, хуягтай, дуулгатай болгоод өгсөн юм.

- Зардлыг хэтрүүлсэн,
- ангилал зөрүүлсэн,
- зориулалтын бусаар ашигласан бол –

-тухайн албан тушаалтныг аудитын дүгнэлтээр албан тушаалаас нь чөлөөлөх гэдэг заалт орж ирсэн байгаа.

Үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурлаад төсвөө батлуулсан гэдэг юм уу, төсвийн гүйцэтгэлээр тэр нь батлагдсан байх юм нь аудитын дүгнэлтээр гарсан бол бас тэр албан тушаалтныг ажил, албан тушаалаас нь чөлөөлөхөөр байгаа.

Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол ажлаас нь халахаар байгаа.

Энэ заалтууд анх удаагаа Төсвийн тухай хууль дээр хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс аудитын эрх мэдлийг сайжруулах үүднээс Та бүхний дүгнэлтийг үнэ цэнтэй болохын үүднээс энэ заалтууд анх удаагаа орж ирсэн юм. Төсвийн хяналт хариуцлагыг сайжруулах үүднээс.

Яг энэ гурван заалтын дагуу Та бүхэн хэн нэгнийг ажил албан тушаалаас нь чөлөөлөх, хариуцлага тооцох ийм дүгнэлт гаргасан уу?

Н.Наранбаатар: 4 номер. С.Магнайсүрэн дарга хариулна.

С.Магнайсүрэн: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Би түрүүн хэлсэн. Ер нь хууль эрх зүйн орчин боломжийн болсон гэж үзэж байгаа. Гэхдээ шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангахын тулд зарим албадлагын асуудал байгаа. Тэрийг нь би оруулж ирнэ гэдгээ хэлсэн.

Өнөөдрийн түвшинд сахилгын хариуцлага нэгдүгээрт ногдуулах энэ хууль эрх зүйн орчин байгаа. Тийм учраас үүнийгээ ашиглаж байгаа.

Хоёрдугаарт нь, бид гэмт хэргийн чанартай гэж үзвэл хууль хяналтын байгууллагад шилжүүлж байгаа. Ингээд энэ хоёр гол асуудал нэгдүгээрт байгаа.

Хоёрдугаарт, өмнө нь бид зөвлөмж юм уу, албан шаардлага өгөөд байхад давтсан тохиолдолд бид дараагийн шатдаа шилжиж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол –

- албан шаардлага өгөөд байхад давтсан бол “сахилгын хариуцлага” руу орно,
- зөвлөмж өгөөд байхад давтсан бол “албан шаардлага” болгоно.

Ингээд шат шат руугаа шилжих хууль эрх зүйн орчин нь бүрэн бүрдсэн байгаа.

Бид 2025 онд 296 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсний 242 буюу 81.0 хувь, өмнөх онуудын үлдэгдэл 93 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын 86 хувь буюу 80 хувийн албан шаардлага тус тус хэрэгжсэн байна гэсэн дүгнэлт гарсан.

Дунджаар 80 гаруй хувьтай сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хэрэгжиж байгаа.

Гэмт хэргийн чанартай гэж үзээд шилжиж байгаа асуудал дээр бид хууль хяналтын байгууллагатайгаа Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурортойгоо энэ талаар ярилцаж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол Улсын ерөнхий прокурорт гэмт хэргийн чанартай асуудлаа шилжүүлдэг. Ерөнхий прокурор цаашаагаа Авлигатай тэмцэх газар, эрүүгийн цагдаа, эдийн засгийн цагдаа гэдэг юм уу холбогдох байгууллагууд руу нь шилжүүлээд явж байгаа.

Энэ дээр тоон дүнгийн хувьд жоохон тааруу дүнтэй. Нэлээд тохиолдолд хэрэгсэхгүй болгох, хэрэг үүсгэхээс татгалзах гэсэн ийм хоёр хэлбэртэй байгаа.

Хэрэг үүсгэхээс татгалзсан тохиолдолд бид жишээлбэл давж заалдах юугүй болчихоод байгаа юм. Яагаад гэвэл бид мэдээлэл өгөх, гаргагч этгээд учраас давж заалдах эрхгүй. Дараагийн шатад хандах эрхгүй гэсэн ийм хууль эрх зүйн орчин байгаа учраас би дараагийн шатад оруулж ирэхдээ хууль эрх зүйн зарим өөрчлөлтийнхөө хүрээнд энэ асуудлыг Төсвийн байнгын хоорондоо танилцуулна гэж үзэж байгаа.

Дээр нь бас нэг асуудал төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлын асуудал гээд. Энэ асуудлыг манай аудитын байгууллага нэгтгэж жил болгон мэдээлж байх хуулиар хүлээсэн үүрэгтэй.

Энэ асуудлыг бид нэгтгээд Төрийн албаны зөвлөл, Улсын ерөнхий прокурорын түвшинд энэ асуудлыг нэгтгээд 2025 оныхоо түвшнийг нэгтгэж бэлэн болгосон байгаа.

Өмнө нь энэ нэгтгэгдээгүй байсан. Одоо бол ямар ч байсан нэгтгэгдээд гараад ирсэн.

3.6 тэрбум төгрөгийн хэрэгжилт хүлээгдэж байгаа. Энэ бол нэн тэргүүнд шийдвэрлэх бололцоотой асуудлууд байгаа юм. Голчлон энэ бол эрх бүхий албан тушаалтнууд шийдсэн.

Тийм учраас тэр албан тушаалтнууд үүнийг хөнгөхөн, төлөх бололцоотой шийдвэр юм болов уу гэсэн байдлаар бид харж байгаа.

Тийм учраас үүнийг богино хугацаанд төлүүлэх бололцоотой. Төрийг төлөөлж нэхэмжлэх эрх нь Улсын ерөнхий прокурор болоод Төрийн албаны зөвлөлд энэ нэхэмжлэх эрхүүд нь байж байгаа ийм мэдээтэй байна.

Н.Наранбаатар: Г.Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: С.Магнайсүрэн дарга аа, би яг Та бүхэн дээр хэнийг ажлаас халах, хэнийг ажлаас чөлөөлөх, хэний хэнд хариуцлага тооцох яг ийм хатуу ямар шийдвэр гаргасан юм бэ гэдэг асуугаад байна шүү дээ.

2025 оноос хойш Төсвийн тухай энэ заалт хэрэгжээд эхэлсэн.

Тэгэхээр төсвийн мөнгө гэдэг чинь үндсэндээ татвар төлөгчдийн мөнгө. Энэ дээр бид ямар нэг, хэн нэгнийх нь толгойг нь илээд, сахилгын шийтгэл оногдуулаад, давтан үйлдэх юм бол ийш тийш нь шилжүүлнэ гэж яриад байж болохгүй шүү дээ.

Энэ дээр хатуу хариуцлагаа тооцоод яв гэдэг эрх зүйн үндэс чинь нээгээд өгсөн байхад энэ дээр ийм бөөрөнхий байдлаар хариулаад байж болохгүй шүү дээ.

Тэгэхээр яг тийм шийдвэр гаргасан юм уу, гаргаагүй юм уу? Одоо би удахгүй 5 сараас 2025 оны төсвийн гүйцэтгэл чинь орж ирнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч нар болгон дээр бид хатуу хариуцлага тооцох энэ эрх зүйн субъект нь нээгдсэн юм. Эрх зүйн санкц нь өөрөө бий болсон юм.

Ийм төсөв, мөнгөтэй холбоотой юман дээр бид хэн нэгний толгойг нь илээд, хулгай зэлгийг гааруулаад байж болохгүй байхгүй юу. Хатуу хариуцлага тооцоод л зөвлөмж, шийдвэрээ мөрдүүлээд л явах шаардлага байгаа шүү дээ.

Н.Наранбаатар: С.Магнайсүрэн дарга. Тодорхой л хариулах хэрэгтэй.

С.Магнайсүрэн: Г.Тэмүүлэн гишүүний асуултад тодруулж хариулъя.

Сахилгын шийтгэл ногдуулах дотор сануулахаас авхуулаад цалин хасах, халах гээд сахилгын шийтгэлүүд байж байгаа.

Энэ хүрээндээ бид томилох эрх бүхий этгээд буюу тэр этгээдэд нь энэ хүндээ сахилгын шийтгэл ногдуул гээд нэгдүгээрт явуулж байгаа.

Хоёрдугаарт нь, дараагийн шатад халах хариуцлага ногдуулах механизмыг ашиглах боломж л манайд байгаа. Үүнийг нь бид эрх бүхий байгууллагад нь л явуулж байгаа.

Тэгээд эрх бүхий байгууллага нь хэрхэн шийдвэрлэсэн талаараа бидний зааж өгсөн хугацаанд эргэж хариу мэдэгдэх ийм хууль, эрх зүйн орчинтой. Энэ хүрээндээ бид явуулаад саяын тэр танд хэлдэг тоон мэдээлэл гарч ирсэн байгаа. Саяын 296 сахилгын шийтгэл... /минут дуусав/

Н.Наранбаатар: Г.Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Яах вэ, ингээд 2025 оны төсвийн гүйцэтгэл удахгүй орж ирэх байх.

Тэр дээр бид бүр нэг бүрчлэн Та бүхний энэ хийсэн ажлууд дээр, энэ хяналт хариуцлагатай холбоотой асуудлуудыг их хатуухан шүүж үзэж энэ асуудлуудыг ярина шүү. Энэ хуулийн заалтууд хэрэгжих ёстой.

Хоёрт, би өмнө нь Төсвийн байнгын хорооны гишүүд танай дээр ажиллаж байхад таны өмнөх удирдлага дээр төрийн аудитын байгууллага дээр үүрэг даалгавар өгч байсан.

Аудитын байгууллагынхаа удирдлагын загварыг нь өөрчлөөч ээ. Энэ ерөнхий аудитын загвартайгаар яваад байдаг. Нэг хүнээс хамааралтай байгаад байдаг. Ингээд гүйцэтгэх засаглал болоод улс төрөөсөө ангид байж

чаддаггүй асуудлуудыг зөвлөлийн загвар буюу хамтарсан шийдвэр гаргадаг удирдлагын тогтолцоо руу оруулаач ээ.

Ингээд хамтаараа хариуцлага хүлээдэг. Хэн нэгэн дангаараа шийдвэрийг өөрчлөхгүй байх асуудлыг шийдээч ээ гэдэг асуудлыг тавьж байсан. Энэ хуулийн өөрчлөлт өр нь ямар түвшинд явж байгаа юм?

Би мэдэх юм. Танай өмнөх. Нэрийг нь хэлээд яах вэ. Нэг дарга ингээд л гүйцэтгэх засаглалын тэргүүн дээр орчхоод нэг байгууллагын дүгнэлтийг зөрчилтэй гарах юм уу, зөрчилгүй гарах юм уу гээд бүр бариад явж байсан түүх байгаа шүү. Би бүр... /минут дуусав/

Н.Наранбаатар: Санал уу, асуулт уу? 4 номер. Хуулийн өөрчлөлттэй холбоотой асуулт. 5 номер хариулъя. Нэр, албан тушаалаа хэлээд.

Б.Бундхорол: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Тамгын дарга Б.Бундхорол байна.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбоотой Төсвийн байнгын хорооны гишүүд төрийн аудитын байгууллага дээр ажиллахдаа санал, зөвлөмж өгсөн.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Үндэсний хуулийн судалгааны төвтэй хамтарч судалгаа хийж, холбогдох хуулийн өөрчлөлт болон хуулийн судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын нөлөө гээд эдгээр судалгааны материалуудыг Төсвийн байнгын хорооны удирдлагад хүргүүлсэн.

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүн асуулт асууна. Тодруулах юм уу?

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Яах вэ, аудитын дүгнэлттэй танилцаж байна. Тэгэхдээ байгууллагынх нь дотор луу нь л орж асуух гээд байна.

Дарга яах вэ, мэргэжлийн гэхээсээ илүү төдийгөөс өдий болтол төрийн алба хашсан, энд тэнд нэг юм аргалаад л яах вэ яваад байх шиг байгаа юм. Яг танай байгууллага мэргэжлийн мэргэшсэн хүмүүсийн хүний нөөц хэр олон байна вэ гэдэг нэг асуулт байна.

Тэгээд яах вэ, шахааны хүмүүс захиалгын шат шатдаа энд тэнд очоод ийм улс төрийн намналт гэх юм уу, хийгээд байх шиг мэдээллүүд бас надад ирээд байгаа юм.

Танайд ч тэр. Одоо жишээлэхэд сая энд ярилаа. Барилга, хөгжлийн төвийн дарга ч гэсэн өөрөө мэргэжлийн бус хүн байгаа учраас тэр барилгын төсвүүд өсөөд байна. Жил ирэх тусам өсдөг. Тэрийг нь батлаад л явуулдаг.

Энд чинь төрийн мөнгө гэж байхгүй, аудитын мөнгө гэж байхгүй. Дандаа татвар төлөгч нарын мөнгө буюу хөлсөө урсгаж олж байгаа хүмүүсийн татварын мөнгийг буцаагаад үр ашиггүй үрж байгаа байдал дээр л аудит хийгдэж байгаа нэг хэлбэр байх. Эдгээр дээр нэг байр суурийг нь тодруулъя.

Ер нь тэгэхдээ яах вэ, өмнө нь С.Магнайсүрэн дарга хэлж байсан. Бид ингээд нэг ийм аудитынхаа зөрчил дутагдлыг илрүүлээд, тэрнийхээ араас явдаг газар нэгжтэй болсон гээд. Тэрний чинь үр дүн хаана байгаа юм? Тэр үр дүнгийнхээ талаар та нэг тодорхой мэдээлэл хэлээч.

Хоёрдугаарт, Өвөрхангай, Архангай аймгийн аудитын байгууллагынхантай уулзсан. Өмнө нь нэг гишүүд уулздаг ч үгүй байсан юм байна лээ.

Яах вэ, та хэд төсөв магадгүй оруулж ирэх байх. Төсөв дээрээ ядахдаа аудитынхаа ажилчдын цалин хөлсийг бодохгүй бол орон нутгийн нэмэгдэл ч байхгүй явдаг.

Тэгээд төрийн хулгайч нар нь аудитад машин авч өглөө гээд машин шахахаараа Арабын стандарт буюу ямар ч хүйтэн газар явдаггүй халуун орны машиныг халаалтгүйгээр Монголд авчраад шахахаар чинь тэр хүмүүс зайлуул зундаа л хөдөө явж аудит хийдэг. Өвөлдөө хөдөө орон нутгаар явах машиных нь хүчин чадал хүртэл хүрэлцэхгүй ийм асуудлууд байгаад байдаг юм байна лээ. Энэ дээр ямар дорвитой арга хэмжээ авч байна.

Аймгийн аудитынхантай уулзаж байхад төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо маш муу. Ядахдаа тайлан нэгтгэх гээд байгаа мэдээллийн системийн зөрүүтэй байдлууд нь хүртэл их зовлонтой байдаг. Жишээлэхэд Өвөрхангай аймагт наадам хийх гэж байгаа бол төсвийнх нь тэр журам нь хүртэл өөрчлөгдөхгүй сүүлийн арван хэдэн жил явсан. Тэгээд дандаа хандив тусламжаар л явдаг юм шиг байгаа юм.

Тэгэхээр анхан шат дээрээ бий болоод байгаа. Энэ бол зөвхөн нэг хоёр аймгийн миний хийсэн уулзалт Өвөрхангай аймаг, Архангай аймаг. Баянхонгортой би уулзаж амжаагүй байгаа. Тойргийнхоо.

Тэгэхээр анхан шат дээрээ та нар хэр хүрч ажилладаг юм бэ? Тэнд чинь бас нэг аудитын юмнууд явагдаад байх шиг байгаа юм. Одоо жишээлэхэд Орхон аймгийн уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн аудитын тайланг авъя гээд албан бичиг өчигдөр та хэд рүү хүргүүлсэн байгаа. Яаралтайгаар. Танай аудитын сайт дээрээс алга болсон байгаа гээд байгаа. Дарга нь... /минут дуусав/

Н.Наранбаатар: С.Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Өнөөдөр төрийн аудитын байгууллагын хэмжээнд 541 албан хаагч ажиллаж байгаа. Өмнө нь 595 байхаар Төсвийн байнгын хороо манай аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг баталж өгдөг. 95 байхаар батлагдсан байсан. Намайг ажилд авах үед.

Ингээд төсвийн тодотгол ороод 9 хувиар танагдсан. Одоо бид 541 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын хэмжээний бүх аудитыг хийж гүйцэтгэж байна.

Хүний нөөцийн тухайд түрүүн би танилцуулгадаа дурдсан. Үндсэн зарчмаа аудитын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд би хүний нөөцөө төвлөрүүлэх ёстой гэж үзсэн.

Намайг ажил авах үед 45, 55-ын харьцаатай. Дэмжих алба нь 40, 45 орчим байх. Ингээд харьцангуй тийм өөр тоо байсан.

Өнөөдрийн байдлаар яг би Үндэсний аудитын газраа 66, 33 гэдэг хатуу харьцаа барьж өөрчлөлт хийсэн.

Ингээд энэ өөрчлөлтийн үр дүнд өнөөдөр улс орон даяар 80.2 хувь нь аудитын чиг үүргээ гүйцэтгэж байгаа буюу аудиторүүд гэсэн үг. Ингэж ажиллаж байгаа. 19.8 хувь нь дэмжих алба буюу бусад ажлыг хийж гүйцэтгэж байгаа.

Энэ нь олон улсын жишиг хандлагатай нийцэж байгаа. Үүнийг би нэлээн хатуу барьж, Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ дээр анх томилгооны үед анхааруулж байсан учраас ингэж хийсэн.

Хүний нөөцийн чадавхын хувьд манайхан харьцангуй бололцооны мэргэжлийн хүмүүс байгаа. Гэхдээ өнөөдрийн хөгжиж байгаа энэ нийгмийн үед бид байнга өөрөө хөгжих ёстой байдаг.

Ингээд олон улсын аудитын дээд байгууллагын зөвлөмж юу вэ гэхээр зэрэг үндсэндээ аудит энэ сэдэв Төсвийн байнгын хороогоор батлагдаад манай ачаалал нийт хүн өдрөөрөө тооцоход 80 орчим хувьтай. Бид 20 орчим хувь нь сул байж байж энэ дээрээ хөгжүүлэлт, чадавхжуулах ажлаа хийх ёстой байдаг.

Гэтэл бид өнөөдөр 110, 120 хувь давсан. Бидэнд ямар ч сул орон зай байхгүй ажиллаж байгаа. Үүнийгээ бид цаашдаа бодолцох ёстой гэж харж байгаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар байгуулагдаад бүх аудитынхаа хэрэгжсэн хэрэгжээгүйгээр нь ялгаад анх удаа бид дата өгөгдөл мэдээллийн сантай болсон.

Ингээд өмнөх шийдвэрүүд дээрээ дүн шинжилгээ хийж үзээд цэвэрлэхийг нь цэвэрлээд, одоо бид хүчин төгөлдөр яг шийдвэрлэх ёстой, хэрэгжих ёстой ийм шийдвэр дээрээ ажиллаж байгаа.

Тийм учраас би аудитын шийдвэрийн хэрэгжилт дээр үр дүн гарч байгаа гэж үзэж байгаа. Олон улсын дээд аудитын дээд байгууллага болоод Азийн аудитын дээд байгууллагаас бас энэ талаар бидэнд үнэлгээ өгсөн.

Ажилтнуудын цалин хөлстэй асуудал дээр би тантай санал нэг байна. Жишээлбэл, манай байгууллага сүүлийн 6 жил нэг ч хөрөнгө оруулалт хийгдээгүй. Өнөөдөр ч гэсэн бид ямар ч хөрөнгө оруулалт байхгүй. Олон улсын хоёр, гурван төсөл бичээд үүнийгээ хэрэгжүүлэх гээд бид явж байна.

Цалин хөлс нэмэгдэх асуудал сүүлийн жилүүдэд бид чадахгүй байна. Өнөөдөр ч гэсэн бид цалин хөлс ярих юм бол Их Хурал дэмжих бололцоо байдаг би үүнийг тавимаар байгаа юм.

Гэхдээ нөхцөл байдал ямар байгаа вэ гэдгийг харгалзаад байж байгаа.

Дээр нь энэ орон нутгийн нэмэгдлийн асуудлыг би тулгамдаж байгаа асуудлынхаа хүрээнд зайлшгүй Төсвийн байнгын хороондоо танилцуулна гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бас дэмжиж өгвөл мэдээж манай орон нутаг асуудалтай учраас энэ бол бидний ажилд том тус дэм болж чадна. Энэ талаар би саналаа оруулж ирнэ гэж бодож байгаа.

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүн тодруулна.

Да.Цогтбаатар: Та хэдийн тайланд Улсын Их Хурлын Тамгын газраас бас нэг мэдээлэл гишүүдэд ирүүлсэн юм.

Тэгээд энэ дээр бас тэр мэргэжлийн байх тал руу нь анхаарлыг нь хандуулахгүй бол гэдэг утгатай мэдээлэл ирсэн байгаа. Түүнд Та бүхэн анхаараарай.

Ер нь Засгийн газрын үрсэн мөнгөн дээр аудит л хийж байгаа байхгүй юу.

Гэтэл Засгийн газрын тэргүүн нь намын дарга, Ерөнхий сайд.

Их Хурлын дарга чинь нам бус байя гэж попроод Их Хурлын дарга болсон. Намын гишүүн. Тэгээд намын гишүүн нь намынхаа даргын өөдөөс юм хэлж чадахгүй буюу аудитад зарчмын шаардлага тавих эрх бодит байдал дээрээ тийм үндэсгүй болчхож байгаа байхгүй юу.

С.Бямбацогт дарга та нарт Засгийн газрын шүүсийг нь шахаад, буруу байна, хулгайтай байна гэдэг юмнуудыг нь гаргаад ир гэж хэлж чадахааргүй түвшинд буюу Монгол Ардын намын гишүүн, Улсын Их Хурлын дарга, Монгол Ардын намын дарга Н.Учрал даргадаа юу ч хэлж чадахгүй байгаагийн бодит байдал нь л энэ аудитаар илэрч гарч ирж байгаа юм.

Түүнээс С.Магнайсүрэн даргын бодлоор сайжраад байгаа юм байхгүй.

Н.Наранбаатар: Л.Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Төрийн аудитын байгууллагын тайланг уншиж танилцлаа.

Танайх ерөнхийдөө бүтцийн өөрчлөлт хийгээд 3 орлогчтой болоод явсан байна.

Тэгээд тайланг чинь харахаар –

- Санхүү,
- Нийцэл,
- Гүйцэтгэл

-гэдэг 3 төрлөөр ангилж аудит хийдэг юм байна.

Төрийн аудитын төв байгууллагаасаа харахаар нийцлийн аудит нь илүү хамгийн ач холбогдолтой нь юм уу. Тийм ээ. Гүйцэтгэлийнх нь хоёрт нь орох юм уу. Санхүүгийнх нь хэдэд нь ордог юм. Ач холбогдлын зэрэглэлээр нь Та бүхэн ер нь яаж ангилдаг юм бэ?

Аймгийнхаа аудитын газруудад ажлуудаа хуваарилж өгөхдөө эдгээр 3 төрлөө яаж хуваадаг юм гэдэг нэгдүгээр асуулт байгаа.

Төрийн байгууллагын ажиллагсдын ачаалал, шат дамжлага, тайлан мэдээ нийлүүлэх гээд гаргаж байгаа цаг хугацааг багасгая гэдэг чиглэл рүү, цахимжуульъя гэдэг чиглэлээр яваад яваад байгаа шүү дээ.

Тэгээд танай бүтцийг чинь харахаар “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар” гээд шинээр байгуулсан юм байна.

Тэгээд уншаад үзэхээр ерөнхийдөө тухайн аудит бичсэн аудитор нь өөрөө хэрэгжилтээ тайлагнаад, шалгаад явдаг ийм бүтцийг дахиад нэгдсэн удирдлагатай болгож байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр энэ дээр яг ямар бүтцийн өөрчлөлт хийснээр ямар бүтээмж үр дүн гарсан юм бэ гээд нэгдүгээр асуулт байгаа юм.

Хоёрт нь, “Тусгай чиг үүргийн аудитын газар” гээд шинээр байгуулсан юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ аудитыг чинь өмнө нь танай хуучин бүтэц дээр яаж явдаг байсан юм? Өмнөхөөсөө ямар давуу талтай болж байгаа юм?

Энэ аудитын газрыг шинээр байгуулснаараа төсөв, зардлын хувьд ч гэдэг юм уу. Тийм ээ. Нэмэгдэж байгаа зүйл байгаа юу гээд.

Гуравдугаар асуулт нь, Монгол Улс бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар явъя гээд байдаг.

Тэгэхээр аймгуудаар хийгдэж байгаа аудитор ялангуяа энэ бүсчилсэн үзэл баримтлалын хүрээнд, бүсчилсэн хөгжлийн хүрээнд хийж байгаа хөрөнгө оруулалтыг аудитаар хэр хийж байна вэ? Энэ чиглэлийн үзэл баримтлалын дагуу хийж байгаа хөрөнгө оруулалт дээр хийсэн аудит байна уу? Энэ чиглэлээр Та бүхэн аймгууд дээр хийж байгаа аудитаараа хэр тусгаж харж байна вэ гээд.

Тэгээд аймгуудын аудитын тайлан, тоо, зөрчлийн дүнг хараад үзэхээр харилцан адилгүй байна. Зарим аймаг дээр зөрчлийн дүн нь өчнөөн зуун тэрбум төгрөгөөр яригдаж байна. Зарим аймаг дээр нь 5, 10 тэрбум төгрөгөөр яригдаж байна.

Тэгэхээр зөрчлийн дүн багатай аймгуудынх нь аудит сайн хийгдээд, тухайн аймгууд нь сайн ажиллаж байна гэсэн үг үү? Эсвэл олон дахин, жил болгон гараад байгаа аймгууд нь муу ажиллаж байна гэсэн үг үү? Энэ дээр нэг тийм тодорхой хугацааны интервалаар нь гаргаж тайлагнадаг байвал зүгээр юм болов уу гэж.

Салбар бүр дээр аудит хийсэн байгаа.

Тэгэхээр салбар бүр дээр хийгдэж байгаа аудитыг хараад үзэхээр жил болгон ч юм уу, 4 жилийн хугацаатай давтамжтай хийгдэж байна гэхэд тухайн салбарыг зохицуулж байгаа хуулийн ийм зүйл, заалт дээр хамгийн их зөрчил дутагдал илрээд байна.

Тийм учраас эдгээр зүйл, заалт яагаад вэ гэдэг шалтгааныг нь судлаад арга хэмжээ авах чиглэлээр нь тухайн салбарыг хариуцсан Байнгын хороонд нь танилцуулдаг байвал зүгээр юм шиг л санагдаж байна.

Н.Наранбаатар: 4 номер хариулъя.

С.Магнайсүрэн: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

- Санхүүгийн аудит,
- гүйцэтгэлийн аудит,
- нийцлийн аудит –

гэдэг төрийн аудитын тухай хууль дээр заагдсан аудитын үндсэн төрөл. Олон улсын жишгээрээ бүх тунхаглалд яг энэ чиглэлээр байгаа.

Ач холбогдлын хувьд эрэмбэлээд, тэр нь ийм, энэ нь ийм гэхээсээ илүүтэй санхүүгийн асуудлууд яг хуулиараа цаглаварт хугацааны дагуу тэдэн сарын тэдний дотор төсвийн шуудыг ерөнхийлөн төвлөрүүлнэ гэж гэдэг юм уу хуульчлаад өгсөн ийм санхүүгийн жил болгон хийгдэх ёстой ээлжит санхүүгийн аудитыг хийж байна.

Гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудитыг бид Төсвийн байнгын хороон дээрээ тодорхой сэдэв оруулж ирээд батлуулж аваад хийж байгаа.

Тэгэхээр ач холбогдол, эрэмбийн хувьд тийм ийм гэх юм алга. Тухайн сэдэв, тухайн асуудлаараа адилхан ач холбогдолтой аудитын төрлүүд байгаа.

Орон нутагт жоохон асуудал байгаа нь орон тоо цөөтэй байгаа учраас тусгайлан тус тусдаа нэгж байхад их төвөгтэй байгаа. Зүгээр нийслэл дээр тусдаа гүйцэтгэлийн, нийцлийн болоод санхүүгийн гэж байгаа.

Аймгууд дээр санхүүгийнх нь байна. Бусад нь тэгээд зарим үед хослуулаад хүний нөөцийнхөө хүрээнд нөөц боломжоосоо шалтгаалаад ингэж хийхээс өөр аргагүй байгаа. Гэхдээ нийцэл, гүйцэтгэл гээд Төсвийн байнгын хорооноос баталсан сэдвүүд аймаг дээр гэхээсээ илүүтэй төв дээр голдуу буюу Үндэсний аудитын газар дээр голдуу хийгддэг. Нийслэл дээр байна.

Тэгэхдээ яалт ч үгүй зарим үед нийслэл дээр. Жишээлбэл, энэ жил гэхэд шинэ хоршоо хөдөлгөөний үр дүн гэхэд бид бүх аймгууд дээр хийж байгаад эндээ нэгтгэхээр ингэж тохирсон.

Гэх мэтчилэн зарим тохиолдолд гүйцэтгэл, нийцлийн асуудал аймаг дээр тусгайлан хийгдэх зүйлүүд гардаг. Энэ тал дээр бид анхаарч хүний нөөцөө сургаж хөгжүүлэх бодлого барьж байгаа.

Тусгай чиг үүргийн аудитын газар дээр өнөөдөр нууцтай холбоотой олон асуудлууд байна. Нууц тайлан гаргадаг олон байгууллагууд байгаа юм.

Батлан хамгаалах болоод хууль хяналтын байгууллагууд. Дээр нь онцгой байдлын газар хүртэл нууцтай холбоотой тайлангууд гаргадаг.

Тэгэхээр нууцтай холбоотой тайлангууд гаргаж байгаа энэ тагнуул, шүүхийн шийдвэр гээд бүх байгууллагууд чиг үүргийн газарт хамаарч байгаа.

Дээр нь Улсын Их Хурлаас гэнэтийн шинжтэй ажлын хэсэг байгуулах, хяналт шалгалтын ч гэдэг юм уу ийм тохиолдолд манай газар орж байгаа. Бусад нь бүгдээрээ жилээрээ төлөвлөөд ажлаа эхэлсэн, боломжгүй байдаг учраас энэ газар ажилладаг. Энэ газрын ачаалал багагүй байгаа.

Цахимжилтын хувьд бид энэ дээр онцгойлон анхаар байгаа. Өнөөдөр бид одоо 7 мянга гарсан яваа манай санхүүгийн баталгаажуулах тайлан гаргагч байгууллагын тоо. Өнгөрсөн жилээсээ нэмэгдсэн гэсэн үг.

Тэгээд энэ дээр бид хүний нөөцөө зөрүүлээд төсвийн тодотголоор хасагдсан.

Тэгэхээр цар хүрээ өргөждөг, хүний нөөц хасагдаж байгаа тохиолдолд бид цахимжиж байж л энэ үүрэг чиглэлээ бүрэн биелүүлэхгүй бол бусдаар боломжгүй байгаа учраас цахимжилт, ажлын ачааллаа бууруулах, үр дүнтэй байх чиглэлээр онцгойлон анхаарч ажиллаж байгаа.

Бүсчилсэн байдлаар бид одоохондоо аудит хийгээгүй байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүд ийм саналууд гаргаж байгаа учраас энэ байдлыг бид судалж хийнэ гэсэн тооцоолол хийж байгаа.

Салбар бүр дээр бид аудит тэр болгон хийхгүй байна. Тодорхой сэдвээр хийж байгаа. Одоо жишээлбэл иргэний нисэхийн асуудал гэдэг юм уу, эсвэл эм, эмнэлгийн хэрэгсэл гэдэг юм уу, эсвэл ахмад настны сантай холбоотой асуудал.

Ингээд тодорхой сэдэв... /минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцгээж хариулъя.

С.Магнайсүрэн: Тодорхой сэдэв Байнгын хороо баталж өгч байгаа учраас яг энэ сэдвээрээ хийгээд тэгээд үр дүнг нь бид холбогдох Байнгын хороондоо. Эдийн засаг бол Эдийн засаг, төсөв бол Төсөв.

Ингээд тайланг нь хүргүүлж байгаа. Тайланг манай Байнгын хороод ярьж, шаардлагатай бол тогтоол санаачлаад явж байгаа.

Өнгөрсөн жилийн тухайд гэхэд бид нийтдээ 37 аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс одоогийн байдлаар 20 тайланг хэлэлцсэн. 17 тайланг хэлэлцэгдээгүй хүлээгдэж байгаа юм. Энэ бол Байнгын хороо ажлынхаа бололцоогоор хэлэлцээд үр дүн гаргаад явах ёстой.

Аймгууд дээр байгаа тэр янз бүрийн үр дүн бас хэд хэдэн учир шалтгаантай байгаа.

Нэгдүгээрт, сайн үр дүн гарч байгаа ийм аймгууд байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт өндөртэй. Зөрчил харьцангуй багассан ийм аймаг байна. Зарим нь магадгүй манай аудитын... /минут дуусав/

Н.Наранбаатар: С.Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Би энэ асуудлыг аудитын байгууллагуудаас удаа дараа тавиад байгаа юм.

Тэгээд энэ тал дээр нэг тодорхой нэг ажил ойлголцол хэрэгтэй. Тэр нь юу вэ гэхээр ихэнх аудитын газар дээрээс чиглэл ирсэн гэдэг нэрийдлийн доор хуульд нийцээгүй зарим акт тавиад байна. Энэ нь ихэвчлэн юун дээр байдаг вэ гэхээр ажилчдын хоол, тэтгэмж, түлээ нүүрс, тэгээд илүү цагаар ажиллуулсан хүмүүсийн илүү цаг, зарим нэг нь нийгмийн асуудлыг буюу Хөдөлмөрийн тухай хуулийн хамтын гэрээ, хэлэлцээрээр тохиролцоод тэр үүргийнхээ дагуу хийх эрх нь нээлттэй байгаа. Хөдөлмөрийн хуулиар.

Хэмнэлтийн хууль яг түүнтэй холбоотойгоор шууд тэрийг барих нь учир дутагдалтай шүү.

Тэгэхээр яг энэ Хөдөлмөрийн тухай хуулийн эрэмбэ гэж байдаг. Хөдөлмөрийн хууль бол Төрийн албаны хууль болон бусад хуулиудыг бодох юм бол хамгийн таатай нөхцөлөө төрүүлж барих буюу Хөдөлмөрийн хуулийг эрэмбийн хувьд дээш нь авч үзнэ гэдэг хуулийн заалт байгаа.

Тэгээд үүнийг үнэлдэггүй юм уу? Үүнтэй холбоотой маш олон байгууллагуудаас. Ялангуяа хөдөө орон нутагт явж байхад. Магадгүй олон гишүүдийг явж байхад ярьдаг байх. Гүйцэтгэлийн үнэлгээ гээд. Одоо манай боловсрол, эрүүл мэнд гэдэг салбарууд зарим байгууллагууд чинь гүйцэтгэлийн үнэлгээгээрээ цалинжина. Зарим нь төсвөөс цалин хөлсөндөө тааруулаад урамшуулал, дэмжлэгүүдийг нь нэмээд өгөхөөр аудитаас хүрч ирээд акт тавьдаг.

Тэгэхээр тэнд төсвийн үр ашиг гэж ярих ямар ч хэрэг байхгүй. Магадгүй тэр төсөвт хуульд тавьсан гэдэг байдлаар энэ олон илүү ажил хийх хэрэггүй гэдэг ийм сэтгэгдлийг төрүүлэхээр байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр манай аудит нэг анхаарч үзээч гэдгийг би хэлмээр байгаа юм. Магадгүй олон төрийн байгууллагуудтай энэ талаар нь Та бүгд хандаарай. Ялангуяа тэр үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, төсөв захирагч нартай холбоотойгоор.

Одоо бүх төрлийн тэмцээн, наадам уралдааныг зохион байгуулахгүй гэсэн юу байгаа юм.

Энэ чинь тэгвэл биеийн тамир, нийтийн спорт энэ Засгийн газар Их Хурлын зорилтод чинь “Эрүүл Монгол” тийм үү, спорт, соёл урлагийг дэмжинэ гээд маш олон хуулийн заалтууд болон тогтоол шийдвэрүүд байгаад байдаг.

Тэгээд энэ бүгдийг нэг нийцүүлсэн шийдвэр гаргахгүй бол зөвхөн нэг хуулийн зүйл бариад ингээд явдаг. Энэ нь өөрөө хэт өрөөсгөл байх юм гэж.

Ахмадын сан гэдгийг аудит хийсэн байна лээ. Би сайн хийсэн байна лээ гэж хэлье. 3 мянга гаруй манай төсөв, төрийн байгууллагууд ахмадын сан гэдэг зүйлийг хэрэгжүүлээгүй, хууль хэрэгжүүлээгүй.

Одоо Та бүгд 6 сарын 01-н дотор дахиж юу өгөөд, дахиад сангаа байгуулахгүй юм бол тэр Сангийн яамнаас тодорхойлолтыг нь авч байгаад тэр төсөв захирагчдад нь хариуцлага тооцох юуг хүргүүлээд өгөөч ээ.

Үүний цаана юу байдаг вэ гэхээр маш олон ахмадууд байгууллага, байгууллагууд дээр хийх ёстой хуулиуд хэрэгжихгүй байна л гэсэн үг. 1 минутаа нэмээд авчих уу.

Дараагийн нэг асуудал нь байна.

Ажлаас халагдсан хүмүүсийг буруу шийдвэр гаргасан албан тушаалдаа хариуцлага үүрч тэр төлбөрийг төрөөс барагдуулах ёстой гэж байгаа. Энэ дээр хэчнээн хүн байна. Түрүүний хэлдэг 3.6 тэрбум чинь энэ дотор явж байгаа юу, үгүй юу гэдэг.

Сүүлд харах нь маш олон дарга нар томилогдож очоод тухайн байгууллагад бараг жил ажиллаагүй байж олон сарын тэтгэмж юм аваад ингээд явдаг. Эсвэл баахан тушаал, шийдвэр гаргаж байгаад өөрөө олон хүнийг хууль бусаар халаад, тэр нь шүүх дээр эргээд цалингийн маш олон өрөнд оруулаад явдаг. Үүнийг нь хаанаас гаргадаг вэ гэхээр нийт цалингийн сангаас гаргадаг.

Тэгээд түрүүний хэлж байгаа тэр ажилтнуудад олгох ёстой илүү цаг, хоол унаа гэдэг юм уу гэх мэтчилэн ийм зардлуудаас ингээд хасаад байдаг юм гэж.

Дараагийн асуудал нь тендер, төрийн алба, төрөл садан гээд л нэг баахан асуудал байна. Энэ дээр манай аудитынхан нийцлийн буюу ашиг сонирхлын аудит хийж үзсэн үү? Хэний ямар ашиг сонирхолтой хүмүүс хаана хаана томилогдоод, хаана хаана ямар тендер дээр хэн хэн ороод байдаг юм бэ гэдэг дээр ухаалаг “Эй Ай” технологи ашиглаад Та бүгд нэг жоохон ажлаа хөнгөвчлөөд хийх, хүний оролцоогүйгээр үнэлэлт... /минут дуусав/

Н.Наранбаатар: 4 номер хариулья.

С.Магнайсүрэн: С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулья.

Үндэсний аудитын газар С.Магнайсүрэн.

Яг саяын асуудлаар манай дээр ч гэсэн асуудлууд байгаа. Жишээлбэл, одоо хэд хэдэн газрын үйлдвэрчний эвлэл манайхыг шүүхэд өгөөд, ингээд шүүхийн маргаан хэд хэдэн газар үргэлжилж байгаа.

Ганц нэг зарим шатад нь Үндэсний аудитын газар ялсан. Бас дээд шатдаа нөгөөдөх хүчингүй болох гэдэг юм уу. Шүүхийн процесс үргэлжилж байгаа хэд хэдэн тохиолдол байгаа. Энэ нь уул уурхайн компани, эрчим хүчний компани хоёр санагдаж байна.

Тэгэхээр энэ бол бид үүнийг нэг тийшээ ер нь болгох ёстой юм болов уу гэж бодож байгаа. Одоо жишээлбэл манайх санхүүгийн аудит хийгээд дуусаж байна. 6 сарын 10 гэхэд бид Улсын Их Хуралд оруулж ирнэ.

Тэгээд санхүүгийн аудит хийх явцад яг энэ чиглэлээр манайхны тавьсан асуудлууд байгаа юм. Одоо албан шаардлага, акт, зөвлөмжүүд өгсөн асуудлууд байгаа.

Тэгэхээр бид үүнийг судалж үзээд нэг тийшээ анхаарах нь зүйтэй байх. Нэг тийшээ болгох нь зүйтэй байх гэж бодож байгаа. Учир нь юу вэ гэхээр зэрэг ер нь хэмнэлтийн хууль дээр заагдсан юмаа л бид бариад байгаа л даа. Хуулиа.

Тэгэхээр үүнийг зүгээр ер нь яах вэ, энэ удаа бид оруулж ирэхдээ Их Хурал толилуулах асуудал дотор үүнийгээ нэг тийш нь болгоё гэдэг ийм санал орж ирэх байх гэсэн урьдчилсан байдлаар бидний яригдаж байгаа зүйл нь энэ байгаа юм.

Тэгэхгүй бол хамтын гэрээ хэлэлцээр дээрээ заасан юмыг нь хэмнэлтийн хууль зөрчсөн байна та нар гээд л манайхан тавьж байгаа юм. Яг хуулиа бариад. Ийм асуудал байгаа учраас үүнийг бид анхааралдаа авъя. Ер нь үйлдвэрчнийхэн манайтай уулзалдаж ярилцъя гэсэн ийм хүсэлт тавьсан. Бид санхүүгийн аудитын ид ажлын ачаалал байгаа учраас арай амжихгүй байгаа ийм зүйл байгаа.

Ахмадын сантай холбоотой асуудлаар манайх аудит хийгээд үр дүнг нь танилцуулсан.

Ахмадын сан байгуулаагүй байгууллагуудын асуудлыг сангаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханга гэдэг байдлаар бид асуудлаа хэлсэн байгаа.

Төсвийн төсөл боловсруулах явцад мэдээж энэ асуудал яригдана. Бид үүнийг анхааралдаа авч асуудлаа тавина. Яагаад гэвэл бид аудитынхаа шийдлийг гаргасан байгаа.

Тэр төрд учруулсан хохирлын асуудлаар 3.6 тэрбум төгрөг 2025 онд учирсан хохирлын асуудал байгаа.

Одоо бид оруулж ирэхдээ 6 сарын 10-нд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл оруулж ирэх үед энэ өссөн дүнгээр асуудлууд тооцогдож оруулж ирээд бид эцсийн үр дүнг танилцуулна.

Тендертэй холбоотой асуудлаар бид ашиг сонирхлын асуудлаар нь аудит хийж үзээгүй.

Уул уурхайн компаниуд. Манай хийсэн аудит яг хууль номынхоо дагуу явж байна уу гэдгийг нь үзэж байгаа юм.

Түүнээс тэр цаанаа хэн, ямар холбоо буюу ашиг сонирхлын талаас нь бид үүнийг ажиглаж анзаарч үзээгүй. Зүгээр 2027 оны сэдэв оруулж ирэх үед бид ер нь худалдан авалтын асуудлаар нэг сэдэв орж ирвэл яасан юм бэ гэж харж байгаа юм.

Яагаад вэ гэвэл энэ асуудлаар иргэд, олон нийтийн санал манайд нэлээн ирээд байгаа. Бид 2027 оныхоо сэдвийг боловсруулж байгаа.

Тэгээд Төсвийн байнгын хороогоор орж ирэх үед хамгийн олон санал авсан, иргэдийн хамгийн их санал авсан, 11-11 төв дээр хамгийн их санал ирсэн. Дээр нь нийгэм хүсэн хүлээж байгаа тэр сэдвээ сонгодог учраас энэ сэдэв орж магадгүй юм байна гэсэн байдлаар би зүгээр урьдчилсан байдлаар тэгж харж байгаа юм. Баярлалаа.

Н.Наранбаатар: С.Эрдэнэбат гишүүн тодруулна.

С.Эрдэнэбат: Ерөнхийдөө би хэлээд байгаа зүйл. Манай Их Хурлын гишүүд ч гэсэн хөдөө орон нутгаар яг үүнийг юмыг аягүй их давтаж ярьж байгаа.

Тэгэхээр энэ юуг бий болгодог вэ гэхээр эргээд нэг хуулийн асуудлуудын хоорондын нийцлийн аль хуулийг нь барих ёстой юм гэдэг юмыг та хэд ойлгоод анхнаас нь зөв явахгүй бол Их Хурлын гишүүд дээр ирж энэ асуудал шийдэх ёстой болдог. Одоо Их Хурлын гишүүд тэнд очоод илүү цагийг нь өгөх ёстой, өгөх ёсгүй, бүр тэтгэвэртээ гарсан зарим ахмадуудыг бүх цалинг нь зогсоож байна гээд л иймэрхүү юмнууд яригдаад байгаа учраас энэ тал дээр С.Магнайсүрэн дарга та хэд маань нэг яриад нэг тийш нь болгоод чиглэлээ өгөхгүй бол яг дээрээс ирсэн чиглэлийн дагуу гээд л аудиторүүд ихэнх нь тэгдэг юм байна лээ.

Магадгүй хөдөлмөрийн чиглэлээр гэдэг юм уу, энэ чиглэлээр ажиллаж байсан аудиторүүд ойлгоод байдаг. Энэ хуулийг бариад гарц нь байгаад байдаг. Гэхдээ дээрээс чиглэл өгч байгаа учраас үүнийг шийдэж болохгүй гээд. Энэ нь өөрөө улс орон даяар маш олон хүний асуудал хамраад байгаа учраас би зориуд хэлж байгаа шүү. Тийм. Баярлалаа.

Н.Наранбаатар: Төрийн аудитын байгууллагын тайланг хэлэлцэж байна.

Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийсэн.

Тэгээд дүн шинжилгээ хийсэнтэй танилцахад аудитын байгууллагын бүтэц, орон тоо өссөн. 2022 оноос хойш хоёр дахин өссөн мөртлөө хэрэгжилт маш муу байна.

Уг нь хамаарлаараа Та бүхний бүтэц, орон тоо өсөхөд Та бүхний тэр гаргасан зөвлөмж, актын хэрэгжилт чинь дагаад өсөх л ёстой. Мөн дээрээс нь “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар” гээд шинэ газар байгуулсан.

Ингээд байхад энэ хэрэгжилт их муу байна.

Мөн Та бүхний тавьсан акт хууль хяналтын байгууллага дээр очоод 33 хувь нь байсан байх. Ингээд хэрэгсэхгүй болдог гэх мэтчилэн ийм зүйл байгаад байх юм.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн ямар хариулт хэлэх вэ? Яагаад бүтэц, орон тоо нь өссөн мөртлөө хэрэгжилт энэ юмнууд нь муу байгаа юм? Аль эсвэл үндэслэлгүй тийм акт, шийдвэр гаргаад тэр нь унаад байдаг юм уу? Аль эсвэл байцаагчид, аудиторууд нь очоод хамгаалж чаддаггүй юм уу? Хууль хяналтын байгууллага дээр. Энэ дээр тодруулж хариулаач.

С.Магнайсүрэн: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулья.

Аудитын шийдвэрийн хэрэгжилт харьцангуй өмнөх оноосоо ахисан байгаа. Бид бүр аймаг аймгаар нь, он оноор нь авч үзэж байгаа.

Тусгайлсан нэгж байгуулсантай холбоотойгоор бид энэ дээр үр дүн гарна.

Ер нь аудитын шийдвэр нь өөрөө жилээр хэрэгжилт гардаг. Өнөөдөр тавьчхаад маргааш нь яадаггүй. Ийм учраас бид завсрын аудитаараа нэг үздэг. Тэгээд дараа жилийнхээрээ бүтэн жилийнхээ аудитаар үр дүнг нь тооцож гаргадаг учраас магадгүй ийм байдлаар харагдаж байж магадгүй.

Одоо жишээлбэл сая орсон аудитын акт албан шаардлага бол бид дараа оныхоо акт, албан шаардлагын үр дүнгээр тооцож гаргах хамгийн сүүлийн хугацаа. Наана нь магадгүй бид хугацаа заагаад тавьсан тохиолдолд тэр хугацаагаараа тооцно. Үгүй бол яг дараа жилийнхээ аудитын юугаар л ингэж гарчаж байгаа юм.

Тийм учраас шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудал бол тодорхой хугацааны дараа үр дүн гардаг ийм зүйл байгаа.

Хоёрдугаарт нь, хууль сахиулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлаар би бас хууль хяналтын байгууллагуудтай уулзах хүсэлт тавьсан. Уулзъя гэж ярьсан байгаа.

Хоёр талын асуудал байгаа юм.

Нэгдүгээрт, манайх гэмт хэргийн шинж шинж чанартай гэж үзэж байгаа асуудлынхаа нотлох баримтыг нь сайн тавьж, сайн гаргаж, материалаа сайн бүрдүүлж ингэж араас нь хөөцөлдөх нэг асуудал байгаа юм.

Манайх ерөнхийдөө өгөөд ингээд орхичоод байгаа байхгүй юу. Прокурорт шилжүүлээд тэгээд орхидог. Тэгээд араас нь явахгүй байгаа учраас энэ нэг асуудал байж магадгүй.

Хоёрдугаарт, манайхны тавьж байгаа зарим асуудал дээр бид хууль эрх зүйн талаас нь сайн дүгнэх шаардлага байна гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ тал дээр манай аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар тусгайлаад ажиллаад эхэлсэн байгаа.

Тийм учраас би энэ тал дээр ахиц дэвшил гарна гэж үзэж байгаа юм. Зүгээр өмнөх 2025 оны энэ дүнгээс харахад 30 гаруй хувь нь хэрэгсэхгүй болсон гэдэг яг бодит байдал, бодит тоо нь энэ.

Үүнийг бид өөр түвшинд аваачна гэж тооцож байгаа. Өөрөөр хэлбэл бидний тавьсан асуудал бол санхүү, төсвийнхөө хувьд яг мэргэжлийн тийм зөрчил юмаа, манай санхүүгийнхэн гаргаж, тэгээд хууль эрх зүйн хувьд бид тэрийг нь гэмт хэрэг мөн байна гэж ингэж үзэж цаашаа тавих учраас энэ бол тийм хэрэгсэхгүй болгох асуудал биш. Харин ч бүр мэргэжлийн түвшинд гаргаж тавьсан ийм гомдол, санал байх ёстой гэж би ийм шаардлага тавьж ажиллаж байгаа.

Өмнө нь тавьсан асуудлууд дээр хугацааны хувьд удаж байгаа. Шийдэгдээгүй өнөөдрийг хүрсэн.

Тэгээд замдаа хэрэгсэхгүй болоод байгаа юмнууд одоо байгаа. Зүгээр одоогоос тавигдах асуудлууд дээр тийм зүйл цаашид давтагдахгүй гэдэг дээр би эргэлзэхгүй, итгэлтэй байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тэгээд цаашдаа энэ өөрчлөлтгүй дүгнэлт авсан байгууллагын тоо сүүлийн 5 жилд тасралтгүй буураад байна гэж байгаа. Энэ чинь өнөө сахилга хариуцлага хэвээрээ улам л алдагдаад байна гэсэн үг.

Мөн албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт тоогоороо өндөр харагдах боловч мөнгөн дүнгээрээ дөнгөж 10-хан хувьтай байна гэж байгаа юм. Энэ анхаарууштай асуудал байна.

Дараа нь хариуцлагаас зайлсхийх хандлага байна. Их хэмжээний мөнгөн дүнтэй зөрчил, төлбөрийн акт тогтоохоос зайлсхийж зөвхөн албан шаардлага өгөх хандлага ажиглагдсан гэж. Дүн шинжилгээнд ийм юм тусгагдсан байна.

Мөн хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн асуудлын 30 гаруй хувь нь хэрэгсэхгүй болдог. Баримтжуулалт муу байна. Очоод хамгаалж байгаа Та бүгдийн чадвар, нотолгоо гэдэг юм уу, юу гэдэг юм энэ тааруу байна гэсэн ийм зүйлүүд энэ Тамгын газраас хийсэн дүн шинжилгээнд тусгагдсан.

Тэгээд “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар” цаашдаа энэ дээр нэлээн сайн ажиллах ёстой юм байна гэсэн ийм зүйлүүд ажиглагдлаа. Энэ дээр Та бүхэн цаашдаа анхаарч ажиллаарай гэж.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Төрийн аудитын байгууллага 2025 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудал.

**Гурав.Улсын Их Хурлын даргын
2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан
Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах,
холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах
үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт**

Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын Дэд дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Дондогийн Сайханчулуун Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга, Түмэндэлгэрийн Баярмаа Татварын ерөнхий газрын Бүртгэлийн хэлтсийн дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татвар орлогын газрын дарга, Баатарын Болд Татварын

ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын барааны ангиллын хэлтсийн дарга, Чулуунбаатарын Тамираа Гаалийн ерөнхий газрын ахлах байцаагч гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Л.Соронзонболд танилцуулна.

Л.Соронзонболд гишүүний микрофоныг өгөөрэй.

Л.Соронзонболд: Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 29 дүгээр захирамжаар татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, ажлын хэсгийн дэд ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, ажлын хэсгийн гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Н.Наранбаатар, Да.Цогтбаатар, А.Ариунзаяа, Д.Батбаяр, Р.Батболд, Ж.Баясгалан, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, С.Цэнгүүн, Ө.Шижир, Д.Энхтүвшин, Ц.Энхцэцэг, С.Эрдэнэбат нар ажиллалаа.

Ажлын хэсэг татварын бодлого, тогтолцоо буюу –

- шударга байх,
- тодорхой байх,
- үр ашигтай байх,
- зайлшгүй байх –

-зарчмын хүрээнд татварын эрх зүйн орчныг судалж, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоо төрийн бус байгууллага, олон нийтээс татварын хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдуулан санал, хүсэлтийг авч, холбогдох хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан.

Тухайлбал, 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал асуулгыг явуулсан бөгөөд санал асуулгаар 700 гаруй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, олон улсын байгууллагаас 2271 саналыг цаасаар болон цахимаар ирүүлсэн дүн шинжилгээ хийж Ажлын хэсгийн хуралдаанаараа хэлэлцүүлсэн болно.

Дээрх саналуудын –

- 37.2 хувь нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар,

- 27.4 хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвар,
- 23.2 хувь нь Татварын ерөнхий хууль,
- 12.2 хувь нь Хувь хүний орлогын албан татварын тухай –

-хуулиудын хэрэгжилт болон дээрх албан татваруудыг –

- ногдуулах,
- төлөх,
- тайлагнах,
- хяналт шалгалт явуулах –

-зэрэг асуудлуудтай холбогдож байна.

Нэгдсэн төсвийн орлогын тооцооллыг авч үзэхэд 2024 оны гүйцэтгэлээр –

- татварын орлого 92.4 хувь,
- татварын бус орлого 7.6 хувийг –

-бүрдүүлснээс орлогын нэр төрлөөр нь авч үзвэл –

- хувь хүний орлогын албан татвар 8.6 хувь,
- аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 21.6 хувь,
- нэмэгдсэн өртгийн албан татвар 20 хувийг эзэлж байна.

2025 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн –

- 93.8 хувийг татварын орлого,
- 6.2 хувийг татварын бус орлого бүрдүүлэх бөгөөд дээрх орлогын –

- 9.2 хувийг хувь хүний орлогын албан татвар,
- 20 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар,
- 22 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвараас –

-төвлөрүүлэхээр тооцож Улсын Их Хурлаас баталсан байна.

Ажлын хэсэг татварын хууль тогтоомж хэрэгжилтэд гарч буй асуудлыг онол, практикийн түвшинд нарийвчлан судалж холбогдох харьцуулсан судалгаа, лавлагаа, тооцоолол, мэдээлэл, олон улсын байгуулалтын зөвлөмжтэй танилцаж дараах асуудлыг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Татварын бодлогын хувьд.

Татварын бодлого нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн шударга ёсыг хангах, инфляц, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг зохицуулах зорилгыг агуулдаг бөгөөд энэ хүрээнд Монгол Улсын

Их Хурал 2019 онд татварын хууль тогтоомжийн шинэчлэл хийж, олон улсын татварын үзэл баримтлал, ойлголтуудыг нэвт нтрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын татварын орлого нь 30 гаруй нэр төрлийн албан татвар, төлбөр, хураамжаас бүрддэг бөгөөд голлох татвар нь –

- ◆ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар,
- ◆ нэмэгдсэн өртгийн албан татвар,
- ◆ хувь хүний орлогын албан татвар,

▪ бусад нь

- үл хөдлөх хөрөнгийн албан татвар,
- гаалийн татвар,
- онцгой албан татвар,
- тэмдэгтийн хураамж,
- ашигт малтмалтын нөөц ашигласны төлбөр,
- ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн хураамж,
- газрын төлбөр,
- агаарын бохирдлын төлбөр,
- нийслэл хотын албан татвар гэх мэт байна.

Татварын Ерөнхий хуулиар татвар төлөгчийг –

- бүртгэх,
- татвар ногдуулах,
- тайлагнах,
- төлөх,
- хянан шалгах,
- хураах,
- хөнгөлөх,
- чөлөөлөх,
- суутган тооцох,
- буцаан олгох –

-эрх зүйн үндсийг тогтоож татварын алба болон татвар төлөгчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг бөгөөд энэ хүрээнд ирүүлсэн саналууд нь татварын хууль хоорондын уялдааг хангах, зөрчлийг арилгах, татвар төлөгчийн эрхийн баталгааг нэмэгдүүлэх, хангах, татварын байгууллагын эрх хэмжээг хязгаарлах, торгууль, алдангийн зохицуулалтыг пропорциональ болгох, татварын зөвлөн туслах ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй болгох, татварын маргаан шийдвэрлэх ажиллагааг ил тод, шуурхай болгох, маргаан таслах, зөвлөлийг хараат бусаар

ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, татварын хэрэг маргааныг шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулах зэрэгт чиглэж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувьд.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсвэл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байх бөгөөд албан татвар төлөгчийн үйл ажиллагааны чиглэл, ногдуулах орлогын хэмжээнээс хамаарч татварын хэмжээг нь ялгамжтай байдлаар зохицуулж, улсын төсвийн орлогын 25 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар бүрдүүлж байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд ирүүлсэн саналууд нь татвар ногдох орлого, хасагдах зардлын зохицуулалтыг тодорхой болгох, татварын ачааллыг бууруулах, хөрөнгө оруулалт болон экспортыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрх зүйн орчныг тогтвортой болгоход чиглэж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь эцсийн хэрэглээнд ногдуулдаг албан татвар бөгөөд бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын үе шат бүрт бий болсон нэмүү өртөгт ногдуулж буй нэмэгдсэн өртгийн албан татварыг эцсийн хэрэглэгч төлдгөөрөө онцлогтой.

Уг татвар нь Монгол Улсын төсвийн орлогын 25 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг төсвийн хамгийн тогтвортой эх үүсвэр болж байна.

Нэмэгдсэн өртгийн албаны татварын тухай хуулиар уг албан татварыг ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, буцаан олгох, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж, үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая төгрөг ба түүнээс дээш төгрөгт хүрсэн албан татвар төлөгчийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар албан татвар ногдуулж, дотоодын үйлдвэрлэлийн зарим түүхий эд, хүнсний зориулалттай тос, үр тариа, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүн, импортын тодорхой бараа, тусгай бүсэд зорчигчийн худалдан авалтыг татвараас чөлөөлөх зохицуулалттай байна.

Өнөөдрийн байдлаар 28 төрлийн бараа, 19 төрлийн үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хүрээнд ирүүлсэн саналууд нь татварыг нийтээрээ жигд, шударга төлөх, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг оновчтой зохицуулах, буцаан олголтын тогтолцоог сайжруулах, экспорт, үйлдвэрлэл, нийгмийн ач холбогдолтой салбарыг зөв тодорхойлон татварын

оновчтой, бодит дэмжлэг үзүүлэх, тайлагналын ажиллагааг хялбаршуулах, татвар төлөх, тайлагнах хугацааг сунгахад чиглэж байна.

Хувь хүний орлогын албан татварын хувьд.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хувь хүний орлогын албан татвар нь орлогын тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангахын тулд орлогыг дахин хуваарилах, түүгээр дамжуулан нийгэмд зохих зохицуулалтыг хийх, эдийн засгийн хөгжлийг дэмжих ач холбогдолтой бөгөөд 2024 оны байдлаар нэгдсэн төсвийн орлогын 8 орчим хувийг, орон нутгийн төсвийн орлогын 36 хувийг бүрдүүлж, сум, дүүргийн төсвийн гол эх үүсвэр болдог.

Эдийн засгийн аль ч мөчлөгийн үед тогтвортой орлогыг бүрдүүлдэг онцлогтой татвар юм.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд ирүүлсэн саналууд нь татварын ачааллыг иргэдийн орлогын түвшинтэй уялдуулах, нийгмийн хамгааллын чиглэл дээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, цахим болон гадаадын эх үүсвэртэй орлогын зохицуулалтыг тодорхой болгоход чиглэж байна.

Дээрх хуулиудын талаар бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн саналуудыг багцлан дүгнэвэл татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход олон улсын гэрээ, конвенц, татварын болон салбарын хуулиудын уялдааг хангаж, хуулийн зарим нэр томъёог ойлгомжтой, хоёрдмол утгагүй болгох, аливаа татварыг тэгш, шударга, нийтээрээ төлөх зарчмыг тодорхойлох, мөн Татварын маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд төр, хувийн хэвшлийн оролцоог тэнцвэржүүлэх, үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, татварын зөвлөн туслах үйлчилгээг хүртээмжтэй болгож, татварын тайлагнал, баталгаажуулалт, төлөлтийн хугацааг практикт нийцүүлэх зэрэг асуудлыг хөндсөн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хувьд албан татвар ногдуулах, орлогын шатлалыг нэмэгдүүлэх, групп компаниар татварын тайлан гаргах боломжийг нээх, хөрөнгө хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжсэн татварын бодлогыг хэрэгжүүлэх, биржийн болон биржийн бус зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгө, оршин суугч бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хүү, ногдол ашигт ногдуулж буй татварын хувь хэмжээг бууруулах, давхар татварын хүрээг өргөжүүлэх, гадаадаас зээл, хөрөнгө оруулалтын эх үүсвэр татахад ногдуулдаг албан татварыг банк болон бусад салбарт жигд болгох зэрэг саналуудыг ирүүлсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд хөнгөлөлт, чөлөөлөлтийг оновчтой болгох, өртгийн сүлжээнд бэлтгэн нийлүүлэгчид бэлэн бусаар төлсөн бол нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөнд тооцох, буцаан олголтын тогтолцоог сайжруулах, экспорт, үйлдвэрлэл, нийгмийн ач холбогдолтой салбарыг зөв тодорхойлон татварын оновчтой, бодит дэмжлэг үзүүлэх, тайлагнал, хянан баталгаажуулах ажиллагааг хялбаршуулах, бизнесийн гинжин хэлхээнд оролцогчид суутган төлөгч болж борлуулалтын орлогын босгогүй байх, эсхүл суутган төлөгчийн борлуулалтын орлогын босгыг 400 сая төгрөгт хүргэх саналууд дийлэнх хувийг эзэлж байна.

Мөн хөдөө аж ахуйн анхдагч бүтээгдэхүүн арьс шир болон уул уурхайн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж татвараас чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татварыг мөнгөн сууриар тооцох, татвар төлөгчийн тайланг хянан баталгаажуулах хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага алдсан төрийн албан хаагчид хариуцлага оногдуулах зэрэг саналыг мөн ирүүлжээ.

Ирүүлсэн саналд нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг салбар олон байгааг бизнес эрхлэгчид шүүмжилж байснаас гадна оршин суугч бусаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөр, нэмэгдсэн өртгийн албан татвар суулган төлөгч бусаас худалдан авалт хийж төлбөрийг бэлэн бусаар төлсөн тохиолдолд худалдан авалтад тооцож нэмэгдсэн өртгийн албан татвар суутган тооцохыг зөвшөөрөх зохицуулалт нь бизнес эрхлэгчдийн хувьд таатай эерэг зохицуулалт болсныг дурдаж байсныг хэлэх нь зүйтэй.

Энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдсан байсан.

Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг гэр бүлийн гишүүдийн нэг хүнд ногдох орлоготой уялдуулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү нийгмийн шинж чанартай болгох. Жишээлбэл, оюутнуудын хөдөлмөрийн хөлсийг татвараас чөлөөлөх, урт хугацааны өндөр өртөгтэй эмчилгээнд зарцуулсан өрхийн зардлыг татварт ногдох орлогоос чөлөөлөх, ногоон хөгжлийн шаардлага стандартад нийцсэн орон сууцын худалдан авалтыг хөнгөлөлт, чөлөөлөлт хамруулах зэрэг асуудал дийлэнх саналыг эзэлж байна.

Бусад асуудлын хувьд.

Ажлын хэсэг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйгээр төдийлөн зохицуулагдаагүй зарим харилцааг олон улсад татварын бодлогоор хэрхэн дэмжиж буй талаар судалгаа хийлгэж үзэхэд дараах асуудлуудыг татварын шинэчлэлийн хүрээнд нарийвчлан судалж, цаашид анхаарах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- олон хүүхэдтэй өрхийн санхүүгийн ачааллыг бууруулж, нийгмийн тэгш байдал болон гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, улс орнуудад олон хүүхэдтэй өрхийг дэмжих бодлогыг хувь хүний орлогын албан татварын тогтолцоонд суурилан хэрэгжүүлж байна.
- Өрхийн орлого, хүүхдийн тоо, орон сууц, асаргаа, амьжиргааны зардлыг харгалзан татварын ачааллыг бууруулах зорилгоор Монгол Улсын өрхөд чиглэсэн татварын бодлогыг тодорхойлох, өв залгамжлал, бэлэглэлийн албан татварын харилцааг Татварын ерөнхий хуульд нэрлэн тодорхойлсон хэдий ч нарийвчлан зохицуулаагүй байна.

Энэ төрлийн татварын асуудлыг хуульчилснаар баялгийн төвлөрөл, тэгш бус байдлыг бууруулахад тодорхой нөлөөтэй талаар олон улсын байгууллагаас зөвлөсөн байна.

Хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой татварын бодлогыг тодорхойлох.

Энэ төрлийн татварын үндсэн зорилго нь хүлэмжийн хийг хэмжээгээр ялгаруулж байгаа иргэн, хуулийн этгээд илүү их татвар төлөх зарчмын хүрээнд зохицуулагдах бөгөөд Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилготой байна.

Ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүдээс болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллага холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн саналуудыг татварын хууль бүрээр багцлан агуулгаар нь тодорхойлж, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалттай харьцуулсан харьцуулалтыг Та бүхэнд танилцуулахаар тараасан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

М.Бадамсүрэн: Ажлын хэсгийн ахлагч Л.Соронзонболд гишүүнд баярлалаа.

Одоо санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүний нэр авъя.

П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа.

Ажлын хэсэг гараад ажиллажээ. Одоо үүнийг яах билээ? Ингээд сонсоод ийм хайран ажлыг мартагнуулах юм уу?

Ер нь Татварын багц хууль Засгийн газраас өргөн барьж орно гээд байгаа. Энд хүргүүлж байгаа яг тухайлан ямар асуудлууд байгаа юм?

Нийгэмд татварын асуудлаар ажлын хэсэг ажиллаж байна. Татварын асуудлыг гишүүд ингэж байна гэдэг бол сайжруулахаар ажиллаж байна гээд баахан хүлээлт үүсгэжээд байгаа байхгүй юу.

Тэгээд ийм зүйлүүд явж явчхаад ямар ч шийдэлгүй байдаг. Сүүлдээ иргэд, олны ч юм уу гайхаад л байна л даа. Баахан юм шинэчлэгдэх гээд байгаа ч юм шиг, явах гээд байгаа ч юм шиг.

Тэгэхээр үүнийг ер нь яах гэж байгаа вэ гэдгийг ажлын хэсгийн ахлагч нэг хариулж өгөөч.

Төсвийн байнгын хороон дээр сонсоод өнгөрөх нэг хэрэг.

Хоёрдугаарт, уг асуудал үнэхээр цаашдаа цаашдаа төсөвт ямар нэгэн нөлөө үзүүлэх асуудал байгаа юм бол эртхэн хаврын чуулгандаа татварын асуудлуудаа цэгцлээд ирэх жилийн төсвийг боловсруулахдаа бид бас энэ татварын өөрчлөлтүүдийг харгалзаж үзэж төсвөө боловсруулах ёстой байхгүй юу. Тэгж байж Улсын Их Хурал хэлэлцэх ёстой. Тэгж байж Улсын Их Хурал батлах ёстой.

Тэгээд одоо ингээд яг төсөв боогоод ороод ирэнгүүт нь татварын багц хууль яригддаг. Төсөвт наадах чинь ингэж болохгүй, тэгж болохгүй гээд шийдэлгүй. Тэгээд л хүлээлт үүсгэсэн баахан хэлэлцүүлэг өрнүүлж байгаад л хаяаад байна. Энэ дээр яах гэж байгаа вэ? Цаг хугацааны хувьд ер нь энэ асуудлыг яах гэж байгаа юм.

Хоёрдугаарт, татварын багц хууль гээд байгаа боловч улсын тэмдэгтийн хураамж татвар мөн үү? Би хувьдаа мөн гэж ойлгодог. Татварын ерөнхий хуулиар ч байж байгаа. Энэ хуулийн дүгнэлтийг аваад үзмээр байгаа юм.

Хоёрдугаарт, хамгийн чухал суурь асуудал болсон АМНАТ болон байгалийн нөөцийн асуудал. Байгалийн нөөцийн төлбөрийн асуудал.

Энэ ерөөсөө дурдагдаагүй. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хүн амын орлогын татвар гээд энэ хүрээндээ л бид асуудлыг яриад байдаг.

Уг нь тодорхой хэмжээний тэдгээр байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой асуудлыг дүгнээд ийм шийдэл орж ирмээр байна гээд дүгнэх бололцоо байгаагүй юу, эсвэл ажлын хэсгийн удирдамжид байгаагүй юм болов уу?

Энэ дээрээс бас нэг зүйл, хамгийн чухал юмыг Л.Соронзонболд гишүүний юунаас оруулсан байна л даа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн тэр гаргаж байгаа санал байна.

Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч нь оршин суугч бус татвар төлөгчид шилжүүлсэн орлогод 15 хувиар татвар ногдуулсан суутган төлөх энэ тэр гээд.

Ер нь тэгээд энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 10, 25 гэсэн шатлалыг дунд нь ойртуулж ирэх асуудал дээр судалгаа хийж үзэв үү? Энэ өөрөө эргээд аж ахуйн нэгжүүд чинь 25 хувийн татвар төлөхгүйн тулд 10 хувь руугаа шилжихийн тулд жижгэрээд байна шүү дээ.

Жижгэрэхээр дундаас дээшээ гэдэг юм уу, одоо бид хэдийн нийгэмд үүсээд байгаа мега төслүүд дээр оролцох бололцоо байхгүй. Нягтлан бодох бүртгэлийнхээ хувьд... /минут дуусав/

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Лхагвасүрэнгийн Соронзонболд хариулья.

Л.Соронзонболд: Тэгэхээр П.Сайнзориг гишүүний ярьж байгаа үнэн.

2024 оноос хойш Улсын Их Хурлын даргын захирамжаар Хассуурийн Ганхуяг гишүүнээр ахлуулсан татварын хуулийн ажлын хэсэг ажилласан.

Энэ ажлын хэсэг ажиллаад нэг жил хагас гаран ажиллаад ажилласан ажлынхаа танилцуулга үр дүнг Монгол Улсын Засгийн газарт танилцуулж, тэгээд энэ дээр үндэслэж Монгол Улсын Засгийн газраас Татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн барьсан.

Энэ өргөн барихдаа Х.Ганхуяг гишүүний ахалсан ажлын хэсгийн ирсэн саналын ерөнхий ойролцоогоор 52 хувийг тусгуулаад ингэж орж ирсэн.

Засгийн газар 2025 оны 12 сард төслөө өргөн барьсан. Манай ажлын хэсэг 2026 оны 1 сард байгуулагдсан.

Асуудал юун дээр байгаа вэ гэхээр Засгийн газраас өргөн барьсан Татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл хэлэлцүүлэх эсэх шатдаа байж байгаад Монгол Улсын Засгийн газраас татсан байгаа.

Тийм учраас манай ажлын хэсгийн зорилго нь Татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллах ийм ажлыг хийсэн байсан.

Дээрээс нь тухайн үед Монгол Улсын Засгийн газраас хэлэлцүүлэхээр төсөл өргөн барьсан учраас тэр хүрээнд саналууд нэлээн явсан гэдгийг хэлье.

Ер нь Ажлын хэсэг үндсэн зорилгынхоо хүрээнд ажлуудаа хийсэн гэж үзэж байгаа.

Тийм учраас Төсвийн байнгын хороонд танилцуулаад, мөн Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг учраас тайлангаа Улсын Их Хурлын даргад хүргүүлнэ.

Мөн дээрээс нь Монгол Улсын Засгийн газарт ажлын хэсгийн тайлан дүгнэлт, саналуудыг хүргүүлнэ.

Мэдээж аливаа татварын асуудал өөрөө цаанаа Монгол Улсын төсөв, зардалтай холбоотой асуудал байдаг.

Тийм учраас энэ дээр мэдээж нарийн тооцоо судалгаа хийж байж шийдвэр гаргах шаардлага байгаа.

Тийм ч учраас шууд үүнийг ингэ тэг ингэ гэж гэхээс илүүтэй ийм саналууд ирж байна, эндээс боломжтой хэрэглэх зүйлийг нь оруулах тал дээр анхаарч ажиллах ёстой гэдэг чиглэлийг Засгийн газарт хүргүүлнэ гэж үзэж байна.

Ер нь яах вэ, Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан 2025 оны 12 сарын Татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр үйл ажиллагааны чиглэлээ сайжруулсан олон зүйл заалтууд байсан. Тэрийг бизнес эрхлэгчид, иргэд ч тэр нэлээн хүлээж байсан. Яах вэ, орлогын татварыг бууруулах талаар санал харьцангуй бага байна гэдэг асуудал байсан гэдгийг дурдаж хэлмээр байна.

Тэгээд таны асуугаад байгаа тэр хураамж ер нь ерөнхийдөө төсвийн орлогод тодорхой хувийг эзэлдэг. Татварын бус орлого бүрдүүлдэг хэсэгт хамрагдаж байгаа.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой асуудал тусгагдаагүй. Ашигт малтмалын нөөц ашиглалтаас гадна Ашигт малтмалын тухай хуулийн төсөл өргөн баригдаад Их Хурал дээр хэлэлцэгдээд Их Хурал дээр ажлын хэсэг ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хүрээнд тодорхой саналууд дараа нь гарч ирэх байх гэж харж байна.

М.Бадамсүрэн: П.Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тийм.

Аж ахуйн нэгж, байгууллагын талаасаа харахаас гадна энэ орж ирж байгаа татварын орлогуудыг зөв хуваарилах дээр санал, дүгнэлтээс ерөөсөө юм харагдсангүй.

Тэгэхээр яг улсын төсөвт орж байгаа зарим татварууд зөв байгаа юм уу, орон нутагт орж байгаа нь зөв байгаа юм уу? Эсвэл тодорхой хувь хувиараа аж

ахуйн нэгжийн орлогын албан татвар шиг хуваарилалтууд байх ёстой юм уу? Энэ жишээ нь АМНАТ байхгүй юу.

Иймэрхүү байдлаар иж бүрэн нэг дүн шинжилгээ хиймээр байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын талаасаа сонсох нь зөв боловч бас орж ирээд аж ахуйн нэгж, байгууллага чинь өгч байгаа юмыг зөв хуваарилж байна уу гэдэг асуудлыг бид дүгнэх ёстой шүү дээ.

Тэгээд энд ерөөсөө харагдахгүй, хэн ч ярьдаггүй.

Сүүлийн үед хүн амын орлогын татварыг нэг хувь болгоно гээд байх юм. Энэ боломжтой юм уу? Л.Соронзонболд гишүүн үүнийг хариулаад өгөөч. Засгийн газрын татварын газраас хариулаад өгөөч.

Хэн дуртай нь улс төрийн популизм хийхээрээ иргэд, олон нийтэд гоё юм ярьдаг. Нөгөө шилний цаанаас мөхөөлдөс долоолгоно гэдэг шиг 1 хувь болгох ер нь бүрэн боломж байгаа юм уу? Үүнийг... /минут дуусав/

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Л.Соронзонболд гишүүн хариулаад, дараа нь Сангийн яам 5 дугаарт хариулна.

Л.Соронзонболд: Тэгэхээр П.Сайнзориг гишүүний яриад байгаа татварын орлогын бүрдүүлэлтийг хуваарилж байгаа болон зарцуулж байгаа газар эргэж харах асуудал байна уу гэдэг дээр анхаарах асуудал байна гэж харж байгаа.

Ялангуяа аймаг, орон нутгийн, сумдын, дүүргийн төсвийн орлогод хувь хүний орлогын албан татвар нэлээн өндөр хувийг эзэлж байгааг би түрүүн тайланд дурдсан.

Гэтэл зарим гишүүдээс хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгох тухай санал олон орж ирсэн байгаа. Одоогийн 10 хувийг 10 дахин бууруулна гэсэн үг. Гэтэл хувь хүний орлогын албан татвар өөрөө манай төсвийн орлогын 8 хувь гэж байгаа шүү дээ. Үүнийг бүр 0.8 хувь болгох ийм зохицуулалт орж ирж байна гэсэн үг.

Тэгэхээр сумын төсөв, дүүргийн төсөв эрс буурах ийм байдалд орно.

Тийм учраас хувь хэмжээн дээр шууд ингэж эрс өөрчлөлт оруулах нь эрсдэлтэй гэж хувь гишүүний хувьд бодож байгаа.

Тэгээд талдаа төсвийн хувьд тийм боломж байхгүй гэж харж байна. Энэ асуудал дээр нэмэлтээр Сангийн сангийн яамнаас хариулна.

М.Бадамсүрэн: Сангийн яам хариулна. 5 дугаар микрофон.

Ч.Чимидсүрэн: Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээг 1 хувь болгох боломжгүй. 10 хувиар бид үндсэндээ төлөөд явж байгаа. Нийтлэг.

Эзгээд энэ бол сум, дүүргийн төсвийг бүрдүүлдэг орлого байгаа. Эффе́ктээр нь аваад үзсэн ч гэсэн сум дээр орлого төвлөрөхгүй. Тэгээд магадгүй улсын төсвөөс ч юм уу явах юм бүр 5.4 их наядын эффе́кт үзүүлэх тийм том нөлөөтэй зүйл.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 29 дүгээр захирамжаар байгуулагдсан татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 18 минут үргэлжилж, 14 цаг 03 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД